

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-85
1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий/	9-12
2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан сонсох	12-39
3. Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./	40-48
4. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./	48-85

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
9 дүгээр сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 39 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Батлут, М.Нарантуяа-Нара, Д.Энхтуяа;
Томилолттой: Ш.Бямбасүрэн, Л.Энхнасан;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Б.Түвшин.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун хэлэлцэх асуудлын 2 дугаарт байгаа “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг 1 дүгээрт хэлэлцэх горимын санал гаргав.

Б.Найдалаа: Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Б.Найдалаагийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Найдалаа: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Найдалаа: Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналаар дахин санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг 1 дүгээрт хэлэлцэхээр тогтов.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баярболд оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, Б.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Эрүүл мэндийн яамны танилцуулгыг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баярболд нар танилцуулав.

Тогтоолын төсөл болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл үг хэлэв.

Б.Найдалаа: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 4

Бүгд: 19

78.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Б.Алтанхуяг, Ш.Зоригоо, Т.Баясгалан, Б.Рагчаа, Ж.Гэрэлмаа, мөн зөвлөлийн ажлын албаны дарга Ц.Сарантуяа, мөн албаны Нягтлан бодогч, санхүүгийн шинжээч Г.Ганцэцэг, мэргэжилтэн Д.Отгонжаргал, Б.Энхбат, Н.Энхцэцэг, Б.Нямдаваа, Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, мөн газрын Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын дарга Г.Ариунсайхан, Худалдан авалт, гэрээлэлтийн газрын дарга Ж.Нарангэрэл, Бодлого, төлөвлөлтийн газрын Тусламж, үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн дарга Б.Ууганбаяр, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Янжиндолгор, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, Б.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, А.Ариунзаяа, О.Саранчулуун, Х.Баасанжаргал, С.Зулпхар, Т.Мөнхсайхан, Д.Бум-Очир, Б.Найдалаа нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Б.Алтанхуяг, Ж.Гэрэлмаа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын Тусламж, үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Янжиндолгор нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Д.Рэгдэл, С.Зулпхар, Ц.Баатархүү, Б.Найдалаа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг сонслоо.

Уг асуудлыг 17 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, Р.Ренчинбазар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Батхүү, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Гэр бүл, хөдөлмөр,нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Ц.Мөнхзул, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга З.Бауыржан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Стратеги төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Туяа, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баярболд, Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтсийн дарга Ш.Энхтуяа, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, мөн хэлтсийн ахлах шинжээч Я.Болормаа, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, мөн яамны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жаргалсайхан, Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж, Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга В.Батчимэг, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга А.Амгаланзаяа, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө

оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамир, Боловсролын газрын дарга Т.Ням-Очир, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, мөн газрын Нэхэмжлэлийн хяналтын газрын дарга Г.Ариунсайхан, Санхүү, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Б.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, Б.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын тавьсан асуултад Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар нар хариулж, тайлбар хийв.

Б.Найдалаа: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн “Засгийн газрын өрийн нийт хэмжээ 51 их наяд 200 тэрбум” гэснийг “51 их наяд 690 тэрбум” болгож өөрчлөх, “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 31 их наяд 600 тэрбум” гэснийг “32 их наяд 90 тэрбум” гэж өөрчлөх, “нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 32 их наяд 980 тэрбум” гэснийг “33 их наяд 470 тэрбум” гэж өөрчлөх, “нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 29 их наяд 552 тэрбум” гэснийг “30 их наяд 42 тэрбум” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 12

Бүгд: 23

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, Р.Ренчинбазар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Ц.Мөнхзул, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга З.Бауыржан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Стратеги төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Туяа, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баярболд, Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтсийн дарга Ш.Энхтуяа, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, мөн хэлтсийн ахлах шинжээч Я.Болормаа, Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, мөн яамны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жаргалсайхан, Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж, Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга В.Батчимэг, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга А.Амгаланзаяа, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамир, Боловсролын газрын дарга Т.Ням-Очир, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, Нэхэмжлэлийн хяналтын газрын дарга Г.Ариунсайхан, Санхүү, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Б.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, Б.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, С.Эрдэнэбат, Ц.Мөнхтуяа, Б.Найдалаа, О.Саранчулуун, Г.Хосбаяр, С.Зулпхар, Ц.Баатархүү, Ж.Галбадрах, Д.Бум-Очир, А.Ганбаатар, М.Ганхүлэг нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын сайд П.Наранбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн

бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга З.Бауыржан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, мөн яамны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жаргалсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Ц.Мөнхтуяа, С.Зулпхар, С.Эрдэнэбат, Б.Найдалаа нар үг хэлэв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд төсвийн төслийн хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулга Төсвийн байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 20 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 51 минут үргэлжилж, 30 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 76.7 хувийн ирцтэйгээр 20 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 39 минут.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Найдалаа: Сайн байцгаана уу. Өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хурлаа эхэлье. Ирц 30 гишүүн байх ёстойгоос 17 гишүүн 56,7%-тай бүрдсэн байна. Ингээд хуралдаанаа эхэлье.

Хуралдаанд ирсэн гишүүдээ танилцуулъя. Тогтмолын Мөнхсайхан, Мөнхчулууны Энхцэцэг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Дүгэрийн Рэгдэл, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Сүхбаатарын Эрдэнэбат, Отгоны Саранчулуун, Сархадын Зулпхар, Жанчивын Галбадрах, Дуламын Бум-Очир, Амгаланбаатарын Ганбаатар, Мягмардашийн Сарнай, Ганбатын Хосбаяр, Цэндийн Баатархүү, Аюушийн Ариунзаяа, Жадамбаагийн Баясгалан нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Өнөөдөр чөлөөтэй байгаа Дамбын Батлут гишүүн, Доржзовдын Энхтуяа, Шинэбаярын Бямбасүрэн гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн нар чөлөөтэй байгаа.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

2 дугаарт Байнгын хорооны тогтоолын төсөл “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай”

3 дугаарт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

4 дүгээрт Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл. Эдгээр 4 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу. Саранчулуун гишүүний микрофон өгье.

О.Саранчулуун: Дарга аа, хэлэлцэх асуудлын дараалал дээр Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн 2 дахь асуудлыг эхэнд нь оруулж өгөөч. Тэгж болох уу.

Б.Найдалаа: Гишүүний гаргасан горимын саналын дагуу 2 дугаар асуудал буюу Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэхийг 2-т биш 1 дүгээрт тавьж өгөөсэй гэсэн үг. Энэ гаргасан горимын саналын дагуу санал хураалт хийе. 1, 2 дугаар асуудлын байрлалыг солино гэсэн үг. Хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчилье гэсэн гишүүний гаргасан саналын дагуу өөрчилье гэсэн томъёоллоор

санал хураана. Гишүүд санал хураалтдаа бэлдэх үү. Санал хураалтдаа бэлдье. Хуруугаа уншуулъя. Гишүүний гаргасан горимын саналын дагуу хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчилъе гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. Минийх ажилласангүй. Яг 50 хувь болоод дундуур нь орчихлоо. Тэгэхээр төхөөрөмж ажиллаагүй учраас энэ санал хураалтыг хүчингүй болгох томъёоллоор санал хураая. Санал хураалт. 61,1 хувийн саналаар саяын санал хураалт хүчингүй боллоо. Одоо түрүүний анхны томъёоллоор буюу хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчлөхийг дэмжъе гэсэн санал томъёоллоор санал хураая. Санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт орлоо.

Ингээд эхний асуудал нь. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

1 дүгээр асуудал.

Байнгын хорооны тогтоолын төсөл /Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж холбогдох санал дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай/ асуудлыг хэлэлцэж эхэлъе.

Ажлын хэсэг байгуулах тухай асуудлаар хүсэлт ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун ажлын хэсэг байгуулах үндэслэл шаардлагын талаар танилцуулгаа хийнэ. Саранчулуун гишүүний микрофоныг нээгээрэй.

О.Саранчулуун: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тодорхой чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсэг байгуулах тогтоолын үндэслэл.

Монгол Улсын Их Хурал 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг батлан гаргасан. Энэ хуулийн зорилт нь хүн амын эрүүл мэнд, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, үнэлэх, хариу арга хэмжээг авах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн. Хэдийгээр тус хууль хэрэгжиж эхлээд 1 жил 4 сар орчмын хугацаа өнгөрч байгаа боловч Засгийн газраас хуулийн хэрэгжилтийг хангах, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төсвийг оновчтой хуваарилах, тус ач холбогдлыг нийтэд сурталчлан таниулах, үнэн зөв мэдээллээр хангах нэгдсэн ойлголт өгөх ажлыг хангалтгүй байна хэмээн үзэж байна.

Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос /тухайн үеийн нэршлээр/ 2025 оны 5 дугаар сард Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар сонсгол хийсэн боловч ямар нэгэн шийдвэр гаргаагүй, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлоогүй болно.

Хуулийн хэрэгжилтийг хангах явцад гарч байгаа хүндрэл бэрхшээл эерэг болон сөрөг үр дагавруудыг тодорхойлж, холбогдох яам, агентлагт хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр хуульд заасан арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.14-д “эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлнэ.” гэж, 2.3.4.2-т “эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулийн сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлнэ.” гэж, 2.3.1.1-д “эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасныг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, явц байдлыг тандан судалж, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх нь зүйтэй байна.

Иймд ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Б.Найдалаа: Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.3-д зааснаар “Байнгын хороо хяналт шалгалт явуулах саналыг хэлэлцэн шийдвэрлэхийн өмнө тухайн асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтны тайлбар, мэдээллийг авч харгалзан үзнэ.” гэсэн байгаа. Энэ хуулийн дагуу Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын Халдварт өвчний хэлтсийн дарга Баярболд тухайн ажлын хэсгийг байгуулах шаардлагатай эсэх талаар товч мэдээлэл өгнө. 1 дүгээр микрофоныг нээгээрэй.

Д.Баярболд: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Саранчулуун гишүүний тавьсан асуулттай холбогдуулаад дараах тайлбаруудыг хэлье.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль батлагдаж, мөрдөгдөж эхэлснээс хойш бол 1 жил 4 сар гаруй хугацаа өнгөрч байгаа. Энэ хугацаанд Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн сайдын баталсан төлөвлөгөөний дагуу хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бүх салбарын хэмжээнд нэгдсэн зохион байгуулж, халдварт бус өвчний нас баралт, өвчлөлийн эрсдэлийг бууруулах замаар хүн амын дундаж наслалтыг дээшлүүлэх, амьдралын чанарыг сайжруулах үндсэн нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, үүрэг болгох, санхүүжилтийн эх үүсвэр болон хэрэгжих хугацааг тодорхойлох зорилгоор 2 үе шаттай төлөвлөгөө хийгдээд явж байгаа.

Хийгдэж байгаа гол ажлуудаас дурдвал Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийг ажиллах журам Нийгмийн эрүүл мэнд мэндийн асуудал хариуцсан үндэсний төв буюу манайхан Си Ди Си гэж яриад байгаа энэ байгуулах байгуулах асуудлыг Засгийн газрын хуралд танилцуулж шийдвэр гаргуулахаар ажиллаж байна. Гэсэн хэдий Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 7-ны 21 дүгээр тогтоолоор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан боловч 2025 оны Засгийн газрын 22 дугаар тогтоолоор уг зөвлөлийг татан буулгасан. Зөвлөлийг дахин сэргээх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар сайдын өгсөн үүргийн дагуу бэлтгэж байна. Энэ зөвлөл нь бол орон тооны бус бөгөөд улсын төсвөөс нэмэгдэл санхүүжилт шаардахгүй. Салбар хоорондын оролцоонд тулгуурлан нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, санал зөвлөмж гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төв байгууллага байгуулах ажлын хэсэг томилогдоод, Эрүүл

мэндийн яамны харьяа нийгмийн эрүүл мэндийн чиг үүрэг хэрэгжүүлэн ажиллаж буй зарим байгууллагуудад болон бүтцийн зарим нэгжийг нэгтгэх орон нутагт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах замаар нэгдсэн тогтолцоо бий болгохоор ажиллаж байгаа. Энэ асуудлыг Засгийн газрын хуралдаанаар оруулахад бэлэн болсон байгаа.

Түүнчлэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц төлбөрийн хэмжээ санхүүжүүлэх журмыг Сангийн сайдтай, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах журмыг Шадар сайдтай хамтран батлахаар ажлын хэсэг томилогдон журмын төслийг боловсруулан холбогдох хэлэлцүүлгүүдийг зохион байгуулан ажиллаж байна.

Цаашдаа нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сангийн ажиллах журмыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдтай, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах сайн дурын ажилтныг урамшуулах журам, мөн Нийгмийн эрүүл мэнд хариуцсан үндэсний төв байгууллагын бүтэц нийгмийн эрүүл мэндийн төвүүдийн дүрэм, бүтэц болон нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтуудыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлах ажлууд хүлээгдэж байгаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Одоо ажлын хэсэг байгуулахтай холбоотой асуудлаар асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Байвал нэрсээ оруулаарай. Ажлын хэсэг байгуулах. 1 хүн байна. Рэгдэл гишүүнээр тасалъя. Рэгдэл гишүүний микрофоныг нээе.

Д.Рэгдэл: Ажлын хэсэг байгуулах тогтоол гаргах саналыг дэмжиж байна. Тэгээд тогтоолын агуулгатай санал нэг байгаа юм. Зүгээр удирдамжтай холбогдуулаад ерөнхийдөө 1 жаахан редакцын чанартай засвар байна. Жишээлбэл, 1.2 зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэдгийн 1 дүгээр заалт ойлгомжгүй бичигджээ. Энэ юу гэсэн юм бол.

2 дугаар заалт ер нь бас жаахан ойлгомжгүй бичигдсэн. Яагаад гэвэл 2 дугаар заалт нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төсөв санхүүжилтийг судалж, тухайн чиглэлээр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хяналт шалгалт явуулна гэж байгаа юм. Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ийм ийм хяналт шалгалт явуулна гэж заагаагүй байх. Тийм учраас санхүүжилтийг судалж, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хяналт шалгалт явуулна гээд өөрчилчихвөл их ойлгомжтой болно. Тийм ээ. 1 дүгээр заалт дээр үг хаячихсан юм шиг байна. 2 дугаар заалт дээр тухайн чиглэлээр гэдгийг нь дарчхаад яавал агуулгад нийцэх юм шиг байна. Энэ санал л юм даа янз нь. Асуулт биш юм байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тайлбарлаж, хариулт хийх үү. Ойлголоо. Тэгвэл Рэгдэл гишүүний гаргаж байгаа саналаар засвар оруулаад явъя.. Гишүүд үг хэлж, асуулт асуулт асууж дууслаа.

Одоо тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.2.2 дахь заалт, 9.4, 9.7 дахь хэсгийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо бас тогтоох нь:

1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт, шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч О.Саранчулуун Монгол Улсын Их Хурлын гишүүн,

Ажлын хэсгийн гишүүд Ариунзаяа Монгол Улсын Их Хурлын гишүүн, Б.Бейсен Монгол Улсын Их Хурлын гишүүн, Д.Ганмаа Монгол Улсын Их Хурлын гишүүн, Т.Мөнхсайхан, Ц.Мөнхтуяа, М.Сарнай, Л.Энхнасан, Д.Энхтуяа, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат.

2.Ажлын хэсгийн хяналт шалгалт хийх үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэг О.Саранчулуунд зөвшөөрсүгэй.

Холбогдох санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Үажлын хэсэгт даалгасугай.

Ийм тогтоолын төсөл байна. Энэ тогтоолын төслөөр санал хураалт явна. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Гишүүд санал хураалтад бэлэн үү. Байнгын хорооны тогтоолын төсөл болон удирдамжийг хавсралтаар батлахыг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 19 гишүүнээс 15 гишүүн буюу 78,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна. Тэгээд Саранчулуун гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгт ажлын амжилт хүсье. 1 дүгээр асуудал хэлэлцэж дууслаа.

15.55 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.2.12-т зааснаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо жил бүр, мөн Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн 15.1.10-д байгаа “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр хэлэлцэнэ.” гэж заасны дагуу өнөөдөр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэж байгаа юм шүү.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Чинбүрэн танилцуулна. Чинбүрэн сайдын микрофоныг нээгээрэй.

Ж.Чинбүрэн: Эрхэм хүндэт байнгын хорооны дарга, Байнгын хороодын гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 2024 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн тусламж, үйлчилгээний үр дүн цаашид авах арга хэмжээний талаар товч танилцуулъя.

1.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны талаар:

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих дээд байгууллага бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагч, ажил олгогч Засгийн газрын тэгш оролцоог хангах, төрийн бодлого Эрүүл мэндийн даатгалын байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг хууль, эрх зүйн хүрээнд тодорхойлон хэрэгжүүлэх, хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь бүтцийн хувьд Засгийн газрыг төлөөлөн 3 гишүүн, ажил олгогчийг төлөөлөн 3 гишүүн, даатгуулагчийг төлөөлөн 3 гишүүн, орон тооны бус нийт 9 гишүүнтэй өдөр тутмын үйл ажиллагаа эрхлэн явуулах чиг үүрэг бүхий ажлын албатай ажилладаг.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр даатгуулагчийн олонхыг эрх, хууль, ёсны, ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн МҮЭХ-ны Ерөнхийлөгч Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат нь Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ Нийгмийн бодлогын байнгын хороонд гаргасан тул Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл нь 2024 оны сүүлийн хагас жилд 8 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явууллаа.

Тайлант онд 8 удаагийн ээлжит хуралдаанаар Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээ, журмыг шинэчлэн, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийн үндсэн цалин, орон нутгийн нэмэгдлийг өсгөж, тусламж, үйлчилгээний тарифыг шинэчлэх, төсвийн нарийвчилсан хуваарийг батлах зэрэг 11 тогтоол, өөрийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 5 тогтоол, нийт 16 тогтоол баталж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд шинээр бүртгүүлсэн байна.

Түүнчлэн ЭМДҮЗ-ийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг Дархан-Уул, Орхон, Өмнөговь аймгийн 24, нийслэлийн 22, нийт 46 эрүүл мэндийн байгууллагад албан томилолтоор ажиллаж, 1 мянга гаруй эмч, эмнэлгийн ажилтнуудтай уулзан ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэж, ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн газар дээр нь танилцан санал хүсэлтийг сонсож,

тулгамдсан асуудлыг бодлогын шийдвэрт тусгах, холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

2.Эрүүл мэндийн даатгалын хамрагдалт, Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн талаар:

2024 онд Эрүүл мэндийн даатгал 3.274.009 даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 93,4 хувьтай байсан. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн сангийн орлого 1 их наяд 964 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд тайлант онд 1 их наяд 921 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 97,8 хувийн биелэлттэй гарсан байна. Сангийн орлогын 38,9 хувийг төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 42,3 хувийг ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл, 16,9 хувийг Эрүүл мэндийн даатгалыг төрөөс хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл, 1,8 хувийг бусад орлого эзэлж байна. Харин сангийн зарлагын хувьд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 2 их наяд 110 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий 2385 эрүүл мэндийн байгууллагад олгосон байна. Тухайлбал, улсын эмнэлэгт 1 их наяд 127,9 тэрбум, анхан шатын эрүүл мэндийн байгууллагад 487,4 тэрбум, хувийн эмнэлэгт 266,8 тэрбум, эмийн санд 137,8 тэрбум, урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний зардал 31,6 тэрбум, сувилалд 27,2 тэрбум, төр хариуцах эмийн зардалд 31,6 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

Ийнхүү 2024 онд батлагдсан зарлагын төсвөөс зарлагын гүйцэтгэл 403,5 тэрбум төгрөгөөр давсан учир 2024 оны эрсдэлийн сангийн 53,6 тэрбум төгрөгийг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд 43,6 тэрбум, амбулаторийн тусламж, үйлчилгээний зардалд 10 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2 их наяд 31,2 тэрбум төгрөг, зарлага 2 их наяд 348,1 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос орлого 357,9 тэрбум төгрөгөөр, зарлага 403,5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд сангийн тусламж, үйлчилгээний зардлыг олгохоор тооцсон гүйцэтгэл 2 их наяд 129 тэрбум төгрөг, үүнээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэний зардалд 1 их наяд 923,3 тэрбум төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 137,8 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 15 тэрбум төгрөг, эрсдэлийн санд 53,6 тэрбум төгрөг, илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт 25,6 сая төгрөгийг тус тус олгохоор тооцсон нь Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал 197,9 тэрбум төгрөгөөр, эмийн үнийн хөнгөлөлтийн зардал 478 сая төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтэрсэн байна.

Өмнөх оны өглөг 218,3 тэрбум төгрөгийг 2024 оны төсвөөс олгосонтой холбоотой сангийн нийт зарлага 2 их наяд 348,1 тэрбум төгрөг болсон байна.

3.Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж, үйлчилгээг өргөжүүлж, иргэдэд очих санхүүгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн гол зорилго нь даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, иргэнд эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн. Энэхүү зорилгын хүрээнд 2024 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолууд бодлогын өөрчлөлт хийж, шинэчлэн баталсан байна. Үүнд орон нутгийн өрхийн эрүүл мэндийн

төвүүд болон сум тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар өсгөж, орон нутгийн нэмэгдлийг 40 хувь хүргэх холбогдох тооцооллыг цалингийн тохируулга хэсэгт тусгалаа.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу байгуулагдсан 1500-аас доош хүн амтай 23 сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хувийн үйл ажиллагааг хангах үүднээс 1 иргэнээр тооцох санхүүжилтэд хүн амаас хамааран тэгш байдлын индексийн коэффициентийг 2 дахин, оношилгоо шинжилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, зарим сэргээн засах өдрийн эмчилгээний тарифыг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн байна.

Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээг өргөжүүлж, хүүхдийн өдрийн эмчилгээний багц, хүүхдийн халдварт бус суулгалт өвчний багцуудыг шинээр үүсгэснээр лавлагаа шатлалын ачааллыг бууруулах, анхан шатдаа хүртээмжтэй тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн. Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний багцыг өргөжүүлж, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ болон хүүхэд, тулгуур хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмнэлэгт ирэх боломжгүй ахмад настанд зайлшгүй үзүүлэх тусламж үйлчилгээг шинээр нэмсэн. Алслагдмал хүн ам цөөтэй аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагыг дэмжих, эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож буй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ нь бүсчилсэн коэффициентийг тогтоож өглөө. Тухайлбал, баруун бүсэд 1,15, нийслэлд 1.0 байхаар тохируулга хийснээр баруун бүсийн эрүүл мэндийн байгууллагууд нийслэлийнхээс 15 хувиар илүү тарифаар санхүүжих болсноор иргэн амьдарч буй газраас санхүүгийн эрсдэлгүйгээр шаардлагатай тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүллээ.

Төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүд төвлөрсөн, төвлөрсөн хорт хавдар, зүрх судас, хүүхдийн шүд, амны хөндий, ерөнхий мэс заслын тусламж үйлчилгээг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад үндсэн тусламж, үйлчилгээг нутагшуулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн багийг орон нутагт ажиллуулсан тохиолдолд нэмэгдэл урамшуулал олгох зохицуулалтыг бас хийсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангийн үр ашгийг сайжруулах, шаардлагагүй өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний тоо хэмжээг бууруулах үүднээс бодлогоор амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, шинэ багцыг бий болгож, амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүллээ.

Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр даатгуулагчийн амь насанд гэнэтийн эрсдэл учруулж болзошгүй төрөх, жирэмсэн, нярайн тусламж үйлчилгээ, халдварт өвчин, хавдар, түргэн тусламж, яаралтай тусламж зэрэг нэн шаардлагатай тусламж үйлчилгээнд зарцуулах зардлын хэмжээг тогтмол нэмэгдүүлснээр 2024 онд 84,2 хувьд хүрч 2020 онтой харьцуулахад 2 дахин өссөн байна. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний зардлыг нэмэгдүүлснээр тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын тоог 2021 онтой харьцуулахад хорт хавдрын мэс засал үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын тоо 7,8 дахин, хорт хавдрын хими ба эмчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын тоо 2,8 дахин, яаралтай тусламж үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын тоо 13 хувиар нэмэгдсэн байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хийсэн судалгаагаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авч буй иргэнээс төлөх төлбөрийн хэмжээг хувиар тогтоох нь

иргэнд санхүүгийн хувьд ядууралд илүү өртдөг байдал тогтоогдсон учир хамтын төлбөрийн бодлогод өөрчлөлт оруулж, хамтын төлбөрийн хэмжээг хувиар биш тогтмол мөнгөн дүнгээр төлөх хэлбэрт шилжүүлснээр өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний иргэдийн төлөх төлбөрийн хэмжээ буурсан. Тухайлбал, элэг шилжүүлэн суулгах мэс заслын төлбөрийн хэмжээ 113,6 сая, даатгуулагч хувиасаа 28,4 сая төгрөг төлдөг байсныг 5 сая төгрөг болгон бууруулснаар халааснаас төлөх төлбөрийн хэмжээ өмнөхөөс 5,7 дахин буурсан.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцдаг иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэний хариуцан төлөх хамтын төлбөрөөс бүрэн чөлөөлөгдсөнөөр 2021 онд 39 тэрбум төгрөг, 2022 онд 47 тэрбум төгрөг, 2023 онд 62,8 тэрбум төгрөгийг, 2024 онд 76,8 тэрбум төгрөгийг хамтын төлбөрөөс чөлөөлсөн нь 2021 онтой харьцуулахад 2 дахин өссөн байна.

Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай бодлого арга хэмжээний хүрээнд:

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн удирдах, төлөвлөхтэй холбогдон харилцаа, гүйцэтгэлд суурилсан арга, хэмжээг оновчтой болгох чиглэлээр Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах,

2. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэнд нийт даатгуулагчийн 70 хувийг эзэлж, нийт шимтгэлийн орлогын 27,7 хувийг бүрдүүлж, сангаас зарцуулсан зардлын 77,2 хувийг эзэлж байгаа тул төрөөс зардлыг нь хариуцах иргэдийн шимтгэлийн хувь хэмжээг Засгийн газраас үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

3. Худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр даатгуулагчийн эрүүл мэндэд эрсдэл учруулж болох нэн шаардлагатай тусламж үйлчилгээний зардал 2024 онд 84,2 хувьд хүрч 2020 онтой харьцуулахад 2 дахин өссөн тул төрөөс хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх асуудлыг жил бүрийн төсөвт тусгах шийдвэрлэх;

4. Эрүүл мэндэд хор хөнөөлтэй бүтээгдэхүүн болох согтууруулах ундаа, тамхины онцгой татвараас эрүүл мэндийн даатгалын санд хуваарилах замаар сангийн орлогыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Эрхэм Байнгын хорооны гишүүд ээ,

Та бүхэнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг товч танилцууллаа.

Цаашид эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа санхүүжилтийн шинэчлэлийг дэмжиж, Эрүүл мэндийн даатгалын хууль, эрх зүйн орчин улам боловсронгуй болгох Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад үнэтэй санал, зөвлөмж өгч дэмжин хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Чинбүрэн сайдад баярлалаа. Одоо Үндэсний зөвлөлийн тайлан сонсохтой холбоотой хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Гишүүд танихгүй учраас босоод байгаарай. Б.Алтанхуяг Эрүүл

мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Ш.Зоригоо Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Т.Баясгалан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Б.Рагчаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Ж.Гэрэлмаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, М.Нармандах Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тамгын газрын дарга, Г.Ариунсайхан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газрын дарга, Бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ж.Нарангэрэл Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Худалдан авалт, гэрээлэлтийн газрын дарга, Ч.Гантөмөр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, Б.Янжиндолгор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын Тусламж, үйлчилгээний багц хариуцсан ахлах мэргэжилтэн, Б.Батхуяг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн мэргэжилтэн, Ц.Сарантуяа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга, Г.Ганцэцэг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны нягтлан бодогч, санхүүгийн шинжээч, Д.Отгонжаргал Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн албаны шинжээч, Б.Энхбат Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны Хяналт шинжилгээ, судалгааны мэргэжилтэн, Н.Энхцэцэг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны хууль, эрх зүйн мэргэжилтэн, Б.Нямдаваа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн. Ийм бүрэлдэхүүнд ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Тэгээд Эрүүл мэндийн даатгалын сан бол эрүүл мэндийн салбарын бид нарын яриад байгаа одоо цалин мөнгөө ч нэмье гээд байгаа. Эмнэлгийн санхүүжилт, эмийн өр авлага, бүхий л юу байдаг юм бүх асуудлын эрүүл мэндийн салбарын хамаг зангилаа асуудал гэж үзэж байгаа. Энэ дээр Байнгын хорооны гишүүд олонтой бас ярилцсан байгаа. Энэ санг шинэчлэхгүйгээр, энийг үр дүнтэй болгохгүйгээр эмч, эмнэлгийн ажлын цалинг нэмэх боломж үүсэхгүй. Эмнэлгийн чанар урт хугацаандаа сайжирна гэх боломж байхгүй. Тийм болохоор маш чухал асуудал. Тэгээд дараа жил бас хуулиараа танилцуулга сонсоно. Тэгэхээр манай гишүүд нэлээн идэвхтэй бөгөөд нарийн ширийн юм асууж, лавлаж зөвлөх байх.

Одоо тайлантай холбоотой асуулт асуух гишүүд байна уу. Нэрсээ өгөөрэй. Мөнхсайхан гишүүнээр тасалъя. Ирцээрээ дараалал нь солигдсон байна. Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэбат: 2024 оны тайлан явж байна. Би бас тодорхой хугацаанд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд ажилласан. Урьдчилан сэргийлэх маш олон компани ажлууд бас явсан. Тэгээд яг хуулиараа бол зарим ийм компани ажилласан томоохон зардлуудыг уг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас гаргах ёсгүй. Тэгэхээр энэ зардал нь бол нэг талаараа шууд эмнэлгүүд дээр очих ёстой зардлаас хуваалцаад байсан. Одоо яг энэ хэвээрээ байгаа юу, үгүй юу. Ер нь манай Эрүүл мэндийн даатгалын болон хүмүүс юу гэж үзэж байгаа юм бэ. Сая Чинбүрэн сайд зогсоосон гэсэн тээ. Компани ажлыг түр хугацаагаар нөгөө урьдчилан сэргийлэлтийг.

2 дугаарт ахмад, хүүхдүүд гээд Эрүүл мэндийн даатгалын сангийн төр хариуцна гэдэг хэсэг маань оруулж байгаа орлого нь бараг гаргаж байгаа зардлынхаа харьцаа нь бараг 7:1 харьцаатай байгаад байдаг. Тэгэхээр одоогийн энэ байгаа олон хүндрэлүүдийг давж гарахад төрөөс хариуцаж байгаа ахмад,

хүүхдүүд болон мөн дээрээс нь хавдрыг бол төр хариуцна гэдэг ийм хуулийн заалттай. Тэгэхээр яг энэ зардлуудаа бол бүрэн авч чадаж байна уу, үгүй байна уу. Тухайн үед 2024 онд бүрэн авч чаддаггүй, үндсэндээ 11 мянган төгрөгийг л ахмад, хүүхдүүдэд өгчхөөд, дунджаар 1 ахмад, хүүхдүүд бараг 1 сая орчим төгрөгийн үйлчилгээ зөрүүлээд авчихдаг. Нийт үйлчлүүлэгчийнх нь үйлчилгээнийх нь 70 хувийг авчихдаг. Тэгэхээр энэ Эрүүл мэндийн даатгалын сан маань яг энэ байдлаараа бол тухайн үед бас би байж байхдаа хэлж байсан. Яг арифметик прогрессоор буюу өсөж байгаа юм байна лээ. Жил болгон үндсэндээ бараг дор хаяж 50-аас дээш хувиар үйлчилгээ авагчдын тоонууд өссөн.

Мөн түрүүн бас хэллээ Чинбүрэн сайд. Элэг шилжүүлэн суулгах гэдэг юм уу өндөр өртөгтэй юмнуудыг хувь хүн даатгуулагчаас гарах зардлыг нь багасгасан. Ингэснээрээ нэг талаараа сайн боловч нөгөө талаараа нөгөө л даатгалынхаа санд ачаалал өгч байгаа ийм асуудал байгаа. Тухайлбал, элэгний хавдраар өвдөж байгаа элэг шилжүүлэн суулгах гэхэд үүний зардлын уг нь бол хавдрыг төр даана гэж байгаа учраас даатгалын сангаас биш, төрөөс гаргах ёстой ийм зардал. Тэгэхээр энэ тал дээр яг ямар байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Тухайн үед бас би санал өгч байсан. Тэгээд манай Эрүүл мэндийн даатгалын газар, эрүүл мэндийн яам маань яг хийж амжсан уу, үгүй юу. И-монголиагаар үзүүлсэн үйлчилгээ авч байгаа өвчтөн, даатгуулагч маань зөрүүлээд эмчилгээ үйлчилгээнийхээ талаар санал сэтгэгдлээ үздэг. Хэдэн төгрөгийн үйлчилгээ яаж авсан бэ гэдгээ харж болдог болох энэ юмыг хийгээч гэж хэлж байсан. Одоо яг энэ ажил ямар шатандаа явж байна вэ гэдэг ийм асуултыг асуумаар байна.

Б.Найдалаа: Микрофон хэд вэ. 1 дүгээр микрофон дээр хариулт өгье. Өөрийнхөө албан тушаал, нэрийг товчхон хэлчхээрэй.

М.Нармандах: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Нармандах. Гишүүний асуултад хариулъя. Урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээний санхүүжилтийг 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлээд зогсоочихсон байгаа. Одоо эрт илрүүлгийн тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн тусламж үйлчилгээ бол хийгдэхгүй байгаа гэж.

Мөн гишүүний нөгөө асуултын хувьд бол Эрүүл мэндийн даатгалын сан дээр төр хариуцах тусламж, үйлчилгээ буюу жирэмсэн эх, хүүхэд, ахмад настан гэх мэтчилэн төр хариуцах тусламж, үйлчилгээ авч байгаа хүмүүсийн зардал нь төрөөс төлж байгаа төлбөрөөсөө даваад байгаа ийм тохиолдол байгаа. Жишээлбэл, 2023 онд нийтдээ төр хариуцахаас 252,1 тэрбум төгрөг төр хариуцах иргэдийн зардал гэж өгснөөс гүйцэтгэл нь 798,1 тэрбум төгрөг буюу зөрүү нь 546 тэрбум төгрөгийн зөрүүгээр Эрүүл мэндийн даатгалын санд ачаалал авч байгаа гэсэн үг. 2024 оны хувьд бол 324,1 тэрбум төгрөгийн төр хариуцах тусламж, үйлчилгээний мөнгө шилжиж ирснээс 884,8 тэрбум төгрөгийн зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас гаргасан байгаа. Зөрөө нь 560,7 тэрбум төгрөг Эрүүл мэндийн даатгалын сан дээр ирж байгаа ачаалал болж хувирч байгаа.

Б.Найдалаа: Тодруулах уу.

М.Нармандах: Эмийн асуудлын хувьд бол бид нар Эрүүл мэндийн сайдын 611 дүгээр тушаалын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цахимжуулах үйл ажиллагааг эхлүүлээд явж байгаа. Эхний үед бол анхан шатын тусламж, үйлчилгээний маягтуудыг бол цахим системд шилжүүлээд явж байгаа. Мөн чатбот

аппликэйшн, гар утасны аппликэйшнүүдийг бас ашиглалтад оруулаад явж байгаа. Мөн тусламж авсан талаарх мэдээллийг бол цахим систем дээрээс харах боломжтойгоор тохируулга хийсэн байгаа. Хөгжүүлэлт хийсэн байгаа.

Б.Найдалаа: Эрдэнэбат гишүүн тодруулна.

С.Эрдэнэбат: Энэ дээр яг харагдаж байгаа одоо яг энэ бидний дараагийн асуудал нь 2025 оны төсөв ярьж байгаатай маш хамааралтай асуудал. Төр даах иргэдийнхээ мөнгийг 500 орчим тэрбум төгрөгийн дутуу байгаа гэсэн үг. Тэгэхээр уг нь бол 500 орчим тэрбум төгрөгийн алдагдал Эрүүл мэндийн даатгалынхаа юугаар өртгөө нэмээд, эмч, ажилчдынхаа цалинг нэмэх боломж гарах ёстой байхгүй юу. Ийм учраас одоо улсын төсөв дээр нэмэлт төр дааж байгаа юм бол энэ гарч байгаа зардлыг нь бүрэн л хариуцах ёстой. Тийм учраас энэ юун дээр бол үндсэндээ 500 орчим тэрбум төгрөгийн зөрүү гарч байна гэж байна. Тийм учраас ийм зүйл дээр бол одоо манай Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл маань тодорхой Сангийн яамныхан үндсэндээ энэ санг чинь Сангийн яамныхан л бараг удирдаж байгаа шүү дээ тийм үү. Тийм учраас энэ саналаа тавьж оруулж ирэхгүй бол дараа дараагийнхаа жилүүд дээрээ ингээд үндсэн даатгалын сан дээрээ ачаа үүрүүлээд ийм хүндрэлээ авчраад байна.

Б.Найдалаа: Асуулт биш үг хэлж дуусгалаа. Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сэтгэлгүй дарга нь яваад сэтгэлтэй дарга нь томилогдсон билүү яалаа. Эрүүл мэндийн даатгалын сангийн өнөөгийн нөхцөл байдал нэг их сэтгэлтэй, сэтгэлгүйдээ биш л дээ. Тэгээд яах вэ, бид нар микрофонгүйгээр гэдэг юм уу ингээд хоорондоо ярилцахад Чинбүрэн сайдтай ч гэсэн бид нар ярьж байсан. Ер нь Эрүүл мэндийн даатгалын сан шимтгэл төлөгчдийн шимтгэлийн орлогоор бүрддэг. Төр төрийн албан хаагчдаа ажиллуулдаг. Гэтэл төр өөрөө өөрийнхөө төрийн албан хаагчдынхаа цалин хөлс, өөрөө өөрийнхөө эзэмшилд байгаа хөрөнгө, урсгал зардлын зардлыг өөрөө үрэхгүй харин шимтгэл төлөгчдийн нуруун дээр үүрүүлчхээд байгаа юм. Тэгэхээр үндсэндээ шимтгэл төлөгчид өнөөдөр өөрсдөө эрүүл мэндийн үйлчилгээ авах ёстой атал төрийн албан хаагчдын цалин эргээд нөгөө төрийн өмчид байгаа байшин барилгын урсгал зардлыг даагаад байгаа байхгүй юу. Тэгээд яг яс юман дээрээ эрүүл мэндийн үйлчилгээгээ сайжруулж чадахгүй хүртээмж нь байхгүй ингээд үйлчилгээгээ авч чадахгүй нөхцөл байдалд хүрчхээд байгаа юм. Тэгээд зөвхөн төрийн албан хаагчдынхаа цалинг энэ шимтгэл төлөлтөөсөө сангаасаа өгөөд байгаа юм уу гэхээр үгүй. Бас хувийн эмнэлгүүдийн урсгал зардал, хувийн эмнэлгүүдийн ажилтнуудын цалин хөлсийг нь өгөөд байгаа юм шиг л маш энгийнээр илэрхийлбэл ийм системд шилжчихээд байгаа юм. Тэгэхээр нөгөө сангийн орлого нь хязгаартай, цалин хөлсөө нэмэгдүүлэхийн тулд, цалин хөлсөө авахын тулд эмнэлгүүд бол яалт ч үгүй арай илүү үйлчилгээний төрлөө нэмэгдүүлэх, үнэтэй байгаа үйлчилгээнүүдээ санал болгох зэрэг асуудлууд яваад байгаа юм л даа. Тэгээд нөгөө өгч байгаа нэхэмжлэл нь ч гэсэн бас хуурамч бичилтүүд ч гэсэн байгаа гэдгийг бол нуултгүй. Шалгалтаар ч гэсэн илэрдэг. Тэгэхээр энэ асуудлаа хэдүүлээ эргэн яаж засах вэ гэдэг л ийм асуудал байгаад байгаа юм. Тэгээд манай Чинбүрэн сайд энэ дээр яг бодлогоо хэдүүлээ хэрхэн яаж засах вэ гэхгүй бол хэчнээн дараагийн хүмүүсийг тавиад бүгдийг нь сэтгэлгүй юм гээд буцаах ямар ч боломжгүй шүү дээ. Энэ бол системийн алдаа болохоос биш тухайн удирдлагын асуудал огтоос биш.

Эрүүл мэндийн даатгалын менежментийг ч гэсэн бас нэг эргэж харахгүй бол Эрүүл мэндийн яам өөрөө энийгээ нэг талдаа бариад ингээд явах нь буруу байгаа

юм. Тэгэхээр энийг засах талаар ямар бодлого байгаа вэ гэдгийг Чинбүрэн сайдаас асууя.

Б.Найдалаа: Чинбүрэн сайд хариулна.

Ж.Чинбүрэн: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Та бас яг л голыг нь л хэлж байна. Энд бол ер нь тогтолцооны том алдаа байгаа. Үнэн. Өнөөдөр бид 2020 оны даатгалын хуулийн шинэчлэлээр гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт гэдгээр бид гүйцэтгэлийн уралдаанд эмнэлгүүдийг мордуулчихсан. Тэгэхээр гүйцэтгэл хийж байж, гүйцэтгэсэн санхүүжилтээ нэхэмжилж байж тэр мөнгийг авч байж цалин хөлс, урсгал зардал, бүх л юмаа төлөх ёстой. Хэрэгцээ шаардлага бол хязгааргүй их. Тэгээд сая бас Эрдэнэбат гишүүн хэллээ. Тэр төрөөс дааж байгаа шимтгэлийн өгч байгаа хувь, яг даатгуулагчийн төлж байгаа хувь 2 хоорондоо тэнцэж байгаа юм уу. Тусламж, үйлчилгээ авч байгаа төрөөс даадаг тусламж үйлчилгээ нь гэхэд л яг гүйцэтгэлтэйгээ таарч тэнцэж байна уу гээд ийм олон зүйлүүд бол хоорондоо уялдахгүй байгаа зүйлүүд байгаа. Мэдээж бас олон 100 мянган нэхэмжлэх сар бүр ирэхэд түүнийг хянадаг тогтолцоо мэдээж механик байдлаар шинжээч нар үзэж тэр бүх нэхэмжлэхийг бас тооцож гаргана гэдэг бол өөрөө бас их төвөгтэй, амаргүй ажил. Тийм учраас энэ дээр бас цахим шилжилттэй, хиймэл оюун ухаанд суурилсан ийм технологиуд хүртэл шаардагдаж байна. Энийг яаж засах гэж байгаа юм бэ гээд 2026 оны төсөвтэй хамт Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, сайжруулах 8 зорилт бүхий 30 үйл ажиллагааны хөтөлбөрөө бид өргөн барьсан байгаа. Засгийн газартайгаа хамт Их Хуралд ийм ажлууд хийнэ. Энэ дотор хамгийн гол хийх гэж байгаа ажил бол ерөөсөө л Эрүүл мэндийн даатгалын сан яг одоо даатгуулагчийг эрсдэлээс хамгаалдаг сан гэдэг утгаар ажилладаг байя. Эрүүл мэндийн яамны харьяа биш. Энэ бол яг биеэ даасан корпоратив институцлэгдсэн ийм байдлаар ажлаа явуулдаг даатгалын сантай болгох 1 том зорилго.

2 дахь нь даатгалын хуримтлуулж байгаа мөнгө болон төр дааж шимтгэлийг нь өмнөөс нь төлж байгаа харилцааг 3 жилийн хугацаанд ойртуулж ижил болгоно. Бодитой болгоё. Өнөөдөр бол дөнгөж 2 хувьд л хүргэж байна шүү дээ. 2 хувьд хүргэж байна. Ингээд энийгээ дараа жилээс 3 хувь руу шилжүүлэхэд ойролцоо 360 орчим тэрбум төгрөг нэмэгдэж орж ирэх ийм тооцоололтой байдаг. Ингээд тогтолцоогоо өөрийг нь биеэ даасан болгох, дээрээс нь нэг чухал байхгүй зүйл бол хяналтын тогтолцоо байхгүй байгаа. Хянаж чадахгүй байгаа гүйцэтгэл гэдэг маань зөвхөн гүйцэтгээд байх биш үр дүнтэй гүйцэтгэсэн үү, үгүй юу гэдэг л асуудал. Сая Ариунзаяа гишүүн ч гэсэн хэлж байх шиг байна. Онош давуулан тавих энэ тэр гэсэн асуудлууд хүртэл илэрсэн, гарсан зүйлүүд байгаад байгаа. Тийм учраас энэ тогтолцоо дээр илүү хяналтын тогтолцоог илүү сайжруулж өгөх, тэгээд ямар ч байсан алдаагүй, зөв шударга хийснээрээ санхүүжилт авч чаддаг, санхүүжилтээ аваад тэр нь цалин, тоног төхөөрөмжийн элэгдэл, байшин савны төлбөр, урсгал зардал энэ тэрийг бол төлөх хэмжээнд байх ийм хэмжээнд аваачих л гол зорилго агуулж байгаа. Тэгэхээр нөгөө бодитой өртөг зардлыг зөв тооцсон ийм тогтолцоо бидэнд бас дутагдаж байгаа гэдгийг бас энд энэ ташрамд бас хэлчихье гэж бодож байна.

Ингээд ер нь бол даатгалын сан 2026 онд бол санхүүгийн бол нэмэгдэл байхгүй байгаа. Одоо тэгэхээр бол нөгөө санхүүжилт хязгаартай. Эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа учраас санхүүжилтийг нэмж чадаагүй. Гэхдээ бид 2026 онд тогтолцоог нь илүү сайжруулах, алдаа гардаггүй байх, он дамнаж өр төлдөггүй байх ийм тогтолцоо руу орохыг зорьж ажиллана. Тэгэхээр бас өвчин зовлонг хүний амь

насанд тулсан өвчин тэдгээрийг бол яаралтай шийддэг байх ёстой. Төлөвлөгөөт товлолд .../минут дуусав/

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Би бас нэмж юу хэлмээр байна вэ гэхээр хөөрхий муу сумын эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтнууд гудамжаар манайд хэвтээч ээ, цалингаа тавих мөнгө хэрэгтэй байна гэж хүмүүсийг хөөж явтал нь л зовоомооргүй байгаа байхгүй юу. Тэгэхээр төрийн албан хаагчид л юм бол төр төрийн албан хаагчдынхаа цалинг өөрөө даах ёстой. Тэрнээс биш зүгээр шимтгэл төлөгчдийн нуруун дээр үүрүүлж болохгүй гэдэг л асуудлыг хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ эргэж харахгүй бол зүгээр ядаж энэ урсгал зардалд ядаж наад захын энэ цалинг нь төр өөрөө л хариуцахгүй бол шимтгэл төлөгчид уг нь бол өөрөө өөртөө эрүүл мэндийн үйлчилгээ л авчихмаар байгаа байхгүй юу. Түүнээс төрийн албан хаагчдын цалин хөлсийг шимтгэл төлөгчдийн нуруун дээр үүрүүлмээргүй байгаа юм. Яагаад гэвэл энэ бол ердөөсөө хэмжээ хязгааргүй асуудал болж байгаа учраас тэр. Ийм л байна.

Б.Найдалаа: Үг хэллээ. Тэгээд зүгээр Ариунзаяа гишүүний саяын юун дээр тодруулаад Чинбүрэн сайдаас асуухад саяын таны ярьдаг 8 зүйлтэй шинэчлэх хөтөлбөр гэж байна шүү дээ. Хөтөлбөр билүү ямар нэгэн тэр тэгэхдээ гишүүдийн гар дээр ирээгүй байгаа шүү дээ. Сая төсөвтэй хамт өргөн баригдаагүй, Засгаас арай гараагүй гэж ойлгосон зөв үү. Тэрийг бол бид нар их тэсэж ядан гэхэд хаашаа юм нэлээн юу хүлээж байгаа. Чинбүрэн сайд микрофон өгье.

Ж.Чинбүрэн: Одоо Байнгын хорооны гишүүддээ шууд цахимаар өгчихье. Бэлэн байж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Надад бас яг 2 асуулт байна. Уналт таталт, булчин суллах эмийг Эрүүл мэндийн даатгал хүүхдэд 100 хувь хөнгөлөлттэй олгож эхэлж байгаа гэдэг. Гэхдээ зарим эмүүд нь бүртгэл нь одоо болтол хөнгөлөлт нь өөр байна. Тэр асуудлыг юу болгосон бэ, яасан бэ гээд өнгөрсөн жил энийг ярьж байхад юу гэж хариулж байсан бэ гэхээр эмнэл зүйн удирдамж байхгүй байгаа юм гэж ярьсан байгаа. Тэгэхээр энэ эмнэл зүйн удирдамж гарсан уу гэдгийг би одоо энд байгаа мэргэжилтнүүдээс бас асуумаар байгаа. Яагаад гэвэл энэ маш олон хүүхдүүдэд эм нь ялангуяа уналт таталтын эмүүд бол бас таарах, таарахгүйтэй холбоотой асуудлууд гараад байдаг. Тэгээд энэ нь нөгөө хүний эмийн тунг цусанд үздэг төхөөрөмж байхгүй гээд байгаа. Тэр төхөөрөмжтэй болсон юм уу. Юу болсон бэ. Энэ дээр нэг тодорхой мэдээлэл өгөөч. Эцэг эхчүүдээс бас энэ дээр маш олон удаа асууж байгаа.

Хоёрдугаарх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гээд группт байдаг гэж ярьдаг хүмүүс. Бид нар группээс нэлээн хэдэн хүмүүсийг нь хасаж байгаа. Сүүлийн үед группээс хасаад, зарим нь шаардлагагүй буюу хувийг нь багасгаж байгаа гэсэн үг. Хүмүүс яагаад группт байх сонирхолтой байгаад группт орчих юм сан гэдэг вэ гэхээр эмийн хөнгөлөлтөө авахын тулд нөгөө унаж татдаг бол тэр эмээ хөнгөлөлттэй үнээр авахын тулд л группт байгаа хүмүүс зөндөө байгаа шүү дээ. Тэр группийн цэнхэр үнэмлэх ер нь олон юманд нэмэртэй байдаггүй шүү дээ. Жолооч бол машинаар явахад хэрэгтэй байдаг. Тэгээд эмийн хөнгөлөлт байгаа. Төрөөс эрүүл мэндийн үйлчилгээ авахад хөнгөлөлттэй байдаг. Тэгвэл эндээс эдийн засгийн хувьд хамгийн

нөлөө бүхий тэр төрийн юу нь бол эмийн хөнгөлөлт байгаа байхгүй юу. Тэгэхээр группийн хувийг нь 50 хувиас доошоо ч юм уу, 60 хувиас доошоо хасчихсан мөртөө хасчихаар нөгөө эмийн хөнгөлөлт нь дагаад байхгүй болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ер нь та бүхэн ямар зохицуулалт хийе гэж бодож байна вэ. Энийг ер нь цаашдаа яах вэ гэдгийг би тодруулж асууя гэж бодож байна. Энэ дээр ер нь нэг тийш нь болгохгүй бол группээс гармааргүй байдаг. Гэтэл цаад санаа нь энэ асуудал байгаад байна гэсэн үг.

Дараагийнх нь болохоор орон нутагт байгаа хүмүүс яаж ялангуяа эмээ авах вэ. Орон нутагт алслагдсан орон нутагт эмийг худалдан авахад бэрхшээлтэй хэцүү байсаар л байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр юу болж байна. Шинэчлэгдэж байгаа зүйл байна уу гэдгийг асууя.

Хамгийн сүүлд нь нөгөө группт орох болгондоо үзлэгт ордог хүмүүсийн дата юу болсон бэ гэдгийг би өнгөрсөн жил асууж байсан. Тэгэхээр энэ дээр та бүхэн ажиллая, анхааръя гэж ярьж байсан. Энэ дээр бас шинэ мэдээлэл юу байна. Дараа нь тодруулъя.

Б.Найдалаа: 4 асуулт байлаа. Чинбүрэн сайдаас эхлэх юм уу. Хэн хариулах вэ.
1 дүгээр микрофон.

Б.Янжиндолгор: Сайн байна уу. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Янжиндолгор.

Хөнгөлөлттэй эмтэй холбоотой асуудал уналт таталтын эм бол 2022 оны 11 дүгээр тогтоолоор хүүхдүүдэд 100 хувь хөнгөлөлттэйгөөр олгож байгаа. Эдгээр эмүүдийн хувьд бол эмийн бүртгэлд бүртгэгдээгүйгээсээ хамааруулаад хангамж хүртээмжийн хувьд бол харьцангуй хязгаарлагдмал байгаа. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дээр бол эмийн бүртгэлтэй холбоотой асуудлыг хариуцдаггүй буюу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар дээр байдаг. Гэхдээ тийм боловч эмийн бүртгэлгүй боловч нэг удаагийн импортын лицензээр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт зөвшөөрөл олгодог. Тэдгээр эмүүдийг бол Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дээр иргэдэд хөнгөлөлттэй эмээр олгож байгаа. Хүүхдүүдэд бол 100 хувиар, насанд хүрэгчдийн хувьд бол групптэй байх эсэхээс, шимтгэл төлөлтийн ямар хэлбэртэй байхаас үл хамаараад хөнгөлөлтийн хувь нь бол 70 хувь байгаа.

Групптээ иргэд хөнгөлөлттэй эм авч чадахгүй учраас группээс гарах сонирхолгүй байгаа гээд ойлгосон зөв үү. Тэгэхээр групптэй иргэдийн хувьд ч тэр, ажил хөдөлмөр эрхэлж байгаа ч хүмүүсийн хувьд ч тэр хөнгөлөлттэй эм буюу эмийн сангаас олгож байгаа уналт таталтын эмийн хувьд бол 70 хувийн хөнгөлөлттэйгөөр бүгд авна. Групптэй байхаас үл хамаарна гэсэн үг.

Б.Найдалаа: Тодруулах уу. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Тэгэхээр хүмүүс маань сонссон байх. Тэгэхээр 1 дүгээрт эмч нар энэ дээр чинь жор бичихгүй байна. Орон нутагт эмч нь авахгүй байгаад байгаа байхгүй юу. Гомдол байна. Тэгэхээр саяын мэргэжлийн тайлбарыг сонсоод үзүүлээд эмээ авах хэрэгтэй байх нь байна шүү гэдгийг бас давхар хэлье. Ер нь бол энэ группийг ... одоо энэ чинь групптэй учраас эрүүл мэндийн даатгал төрөөс

хариуцаж эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа шүү дээ. Тэгээд зардал эндээс явж байгаа. Тэгэхээр энэ дээр энэ шатлалаа ерөнхийдөө бас бодохгүй бол та бүхэн болохоор энд окэй болно шүү дээ, 70 хувь нь авдаг гээд байдаг. Яг орон нутагт ч юм уу энд тэнд яваад очихоор эмч нар энийг чинь энэ чинь энэ жагсаалтад орохгүй, би бичихгүй гээд бичихгүй байгаа асуудлууд гарсаар байгаа байхгүй юу. Тэгээд энийгээ та бүхэн салбар бүр лүүгээ нэгдсэн мэдээлэл өгч цэгцлээрэй. Энэ нөгөө эрүүл мэндийн хувьд асуудалтай, хэл яриагаа илэрхийлж чадахгүй, унаж татдаг хүмүүст энэ буруу ойлголт чинь нэмж бэрхшээл удаад байгаа байхгүй юу. Нөгөө мэдээллээ авахын тулд нааш цааш нь явуулаад л бичнэ, бичихгүй гээд ингээд байгаа учраас. Үг болчихлоо. Баярлалаа.

Б.Найдалаа: Үг байлаа. Чинбүрэн сайд тодруулж хариулах юм байна. Чинбүрэн сайдын микрофоныг өгье.

Ж.Чинбүрэн: За тэр сумын сумд байгаа эмийн сангууд бас зарим цөөн сумдуудад хөнгөлөлттэй эмийн эрхгүй байгаад байгаа юм. Яагаад вэ гэхээр хөнгөлөлттэй эм олгохын тулд сумд ажиллаж байгаа эмийн сангууд эм найруулагч, эм зүйчтэй ингээд орон тоо нь чанарын шаардлага нэхдэг учраас тэр олон боловсон хүчин байхгүй учраас өгч чадахгүй байгаа. Яг одоо бид нар яая гэж бодож байгаа вэ гэхлээр сумын эрүүл мэндийн төвөөр дамжуулан сумын тэр хөнгөлөлттэй эмүүдийг олгох энэ тогтолцоог хийх гээд ажиллаж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Баасанжаргал гишүүн асуулт асууна.

Х.Баасанжаргал: Миний асуулт маш тодорхой асуулт байгаа учраас яг тодорхой хариулаад өгөөрэй. Эрүүл мэндийн даатгалын сангийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт нь юу байдаг юм бол. Тэгээд 2024 оны тайланг харахаар яг тэр шалгуур үзүүлэлтээ хэрхэн хангасан бэ гэдгийг нь яг олоод харчихъя гэхээр харахгүй л байна л даа. Тэгэхээр яг та бүхний тодорхойлсон зорилт, шалгуур үзүүлэлт нь юу байдаг юм бэ.

Б.Найдалаа: Тодорхой асуулт байна. Чинбүрэн сайд хариулъя.

Ж.Чинбүрэн: Би 2024 оны яг зорилго зорилтуудыг бол хэлж мэдэхгүй байна. 2026 оны төсөвтэй хамт гарахдаа бид бас нэг KPI үзүүлэлттэй байхаар гаргасан. Энэ дотроо бол эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, нэг ёсондоо түрүүн тайланд 95 орчим хувь байгаа гэсэн бол энэ хамралтыг бид нэмэгдүүлэх, дээрээс нь Эрүүл мэндийн даатгалын сангийн эрсдэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, энийг 50-55 болгоно гэсэн ийм зорилт тавьсан. Сангийн зарцуулалтын нэн шаардлагатай үйлчилгээнд даатгуулагчдын эрүүл мэндийн үүдэлтэй санхүүгийн эрсдэлийг бууруулах гэдэг энэ эрсдэлийг бууруулах зорилгоо бид 13 болгож буулгана гэсэн ийм зорилт тавьсан байна. 2027 онд энийгээ 10 болгоно гэсэн ийм ерөнхий үзүүлэлт бол 2026 онд бол оруулсан юм. Тэгээд Эрүүл мэндийн даатгалын гол үзүүлэлтүүд түрүүн хэллээ. Санхүүгийн дарамтгүй болгоно гэж байна. Тэгэхээр санхүүгийн ачааллыг 1 гэр бүлийн орлогоос 15 хувиас хэтрүүлэхгүй байх их чухал. Энэ 15 хувиас хэтрүүлэхгүй байхын гол үзүүлэлт нь ерөөсөө л энэ хөнгөлөлттэй эмтэй холбоотой байдаг юм байна лээ. Тэгэхээр хөнгөлөлттэй эмийн санхүүжилт оновчтой болгох, дээрээс нь өвдөөд эмнэлэгт очиход ялангуяа яаралтай эрчимт эмчилгээ, амь тэмцсэн үеийн тусламж үйлчилгээ дээр бол цаг алдахгүй очиж амь насныхаа эрсдэлээ даалгаж чадах байх энэ тогтолцоог бас илүү сайн хийх ёстой. Тэгэхээр энэ эмнэлгийн хүрэлцээ гэдэг маань өөрөө кластерт тулгуурласан ийм том бүтэц байх ёстой. Тэгээд мэдээж

хувиараа даатгуулагчдыг даатгалдаа бүрэн хамруулах, мөн эмчилгээ нь үр дүнтэй, хамгийн чухал нь үр дүнтэй. Тийм ээ. Тэгэхлээр эрүүл мэндийн байгууллагын бас нэг том зорилго бол өвчин тусаад эндэхгүй байх чухал, нас баралтын хувийг буулгасан байх ёстой. Энэ бол ерөөсөө гол үзүүлэлт. Тэгээд нарийн тусламжуудаа аваад үзэх юм бол илүү нарийсаад үзүүлэлтүүд нь нарийсаад хуваагдчих байх. Яг 2024 онд ямар үзүүлэлт барьж байсныг манай Даатгалын ерөнхий газраас хэлээд өгөхгүй юу.

Б.Найдалаа: Үндэсний зөвлөлөөс асуусан уу Баасанжаргал гишүүн. Чинбүрэн сайд биш юм гэхэд бусад зөвлөлийн гишүүд мэдэж байгаа байлгүй. Энэ тодорхой, маш тов тодорхой зөв асуулт байна. 7 дугаар микрофоныг нээе.

Ж.Гэрэлмаа: Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Гэрэлмаа байна. Тэгээд гишүүний асуултад хариулъя. Гишүүн бол яг нөгөө засаглалын чухал асуудлыг хөндөж асууж байна. Тэгэхээр 2025 оныг хүртэл буюу өнөөдрийг хүртэл яг Эрүүл мэндийн даатгалын сангийн эсвэл Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог үнэлдэг шалгуурыг албажсан ийм шалгуур бол байгаагүй. Гэхдээ одоо Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар маань өөрөө Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг учраас яг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудад тавьдаг шалгуураар шалгагддаг байсан. Эдгээр шалгуурыг нь ингээд хараад үзэх юм бол яг Эрүүл мэндийн даатгалтай холбогдолтой тийм шалгуур үзүүлэлт их ховор байсан. Тийм учраас 2025 оны Төсвийн тухай хуульд зайлшгүй энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн гол үзүүлэлтүүдийг оруулах нь чухал юм гээд түрүүний сайдын дурдсан 5 шалгуур үзүүлэлтийг оруулсан байгаа. Тэгээд олон улсад .../минут дуусав/

Б.Найдалаа: Баасанжаргал гишүүн тодруулах уу.

Х.Баасанжаргал: За байз одоо 2025 он хүртэл манай Эрүүл мэндийн даатгалын сан яг юуны төлөө зорьж, яг ямар үзүүлэлтээр ажлаа хийсэн бэ гэж дүгнэдэг байсан шалгуур үзүүлэлт тодорхойгүй явж ирлээ л гэж би ойлголоо. Энийг та хэд маань бүгдээрээ дор бүрнээ дотроо бодно биз дээ.

2 дугаарт сая сайд хэллээ. Дээрээс нь та бүхэн энийг хараарай. Бид нарт өгсөн энэ төсөл дээр хоёрхон шалгуур үзүүлэлт тавьчихсан байгаа. Хоёрхон зорилт тавьсан. 1 зорилт дээр 1 л шалгуур үзүүлэлт. Нөгөөдөх дээр нь бас л 1 шалгуур үзүүлэлт. Жишээ нь сангийн зарцуулалтыг нэн шаардлагатай үйлчилгээнд хуваарилж, даатгуулагчийн эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлийг бууруулна гээд шалгуур үзүүлэлт нь өрхийн орлогын 10-аас дээш хувийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахдаа зарцуулсан өрхийн тоог 14 хувь байсныг 13 болгоно гэнэ. Энэ чинь тэгээд зөв юм уу. Та хэд маань энэ шалгуур үзүүлэлт дээр дахиад ажиллаач.

Б.Найдалаа: Хариулт. Микрофон 7.

Ж.Гэрэлмаа: Түрүүн дэлгэрэнгүй танилцуулах гэж байгаад минут нь дуусчихлаа. Хэдийгээр яг нөгөө шалгуур нь албажаагүй байна гэдгийг мэдээд бид нар Эрүүл мэндийн сайдын тушаалаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааг үнэлэх, урамшуулал олгох журам гэдэг юмыг явуулсан байгаа. Тэр дээр 5 шалгуур үзүүлэлт байгаа. Тэр 5 шалгуур үзүүлэлт нь юу байгаа вэ гэхээр,

1 дүгээрт нь даатгуулагчийн хамралтын хувь хэдэн хувь нь хамраад байгаа юм. Тэр дундаа хамралтад хамрагдахгүй байгаа бүлгүүдийн хамралтыг дээшлүүлэх асуудлыг тусгасан байгаа.

2 дугаарт нь нэн шаардлагатай тусламж үйлчилгээнд даатгалын зардал хэдэн хувь нь байгаад байгаа вэ. Тэрийг хэмжих үзүүлэлт байгаа.

3 дугаарт нь хамгийн чухал үзүүлэлт буюу даатгуулагч өөрөө яах гэж даатгуулж байгаа вэ гэхээр санхүүгийн эрсдэлээс хамгаалуулах гэж даатгуулж байгаа учраас даатгуулагчийн санхүүгийн эрсдэлийг хамгаалж байгаа хамгаалалтыг шалгах шалгуурыг оруулсан байгаа.

Мөн шатлал, сангийн тэнцлийн асуудал хамгийн сүүлд нь болохоор .../минут дуусав/

Б.Найдалаа: Яг үүнтэй холбоотой эд нараас асуумаар байна зүйл байсан. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.9 дээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үүрэг нь гээд байгаа байхгүй юу. Хууль дээр. Актуар тооцоонд үндэслэн гэсэн байгаа юм. Актуар тооцоо та бүхэн хийсэн үү. Хийж үзсэн үү. Хэн хариулах вэ. 1 дүгээр микрофон.

М.Нармандах: Гишүүний асуултад хариулъя. Бид нар актуар тооцооллыг 2023 онд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас манай дээр хяналт шалгалт ирсэн. Хяналт шалгалтын үр дүнгээр бол Монголд байгаа актуар тооцоолол хийж мэргэшсэн 2 хүн байдаг юм байна лээ. Энэ 2 хүнтэй нь гэрээ байгуулаад актуар тооцоолол хийлгэж үзсэн. Гэхдээ эдгээр хүмүүс юу гэж хэлж байна вэ гэхээр Эрүүл мэндийн даатгалын байгууллага маань 2018 оноос хойш үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 5 жилийн тооцоолол дээр урт хугацааны төлөвлөлт хийх боломжгүй байна гэдэг ийм асуудал ярьж байсан юм тухайн үед. Бид нар энэ жилийн төсөвт уг нь багтаагаад актуар тооцоолол хийх олон улсын сонгон шалгаруулалтыг зарлах байсан боловч төсөв мөнгө татагдсантай холбогдуулаад энэ үйл ажиллагаа хийгдээгүй байгаа.

Б.Найдалаа: Дараа тодруулъя даа. Дараагийн гишүүнийг Зулпхар гишүүн асуулт асууна.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүд, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд, яамныханд энэ өдрийн мэндийг айлтгая.

2 тодорхой асуулт, 1 тодруулга байна. Сая нөгөө тайлангаа та бүхэнд танилцууллаа. 2 дүгнэлт хийж байна шүү дээ. Энэ Эрүүл мэндийн даатгалын сан бол үндсэндээ уг нь эрсдэлийн сан боловч өөрөө эрсдэлд орчихсон. Тэгээд энийг эрсдэлээс нь гаргахын тулд бид Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиа бол өөрчлөхөөс аргагүй. Өөрөөр хэлбэл энийг оновчлох ёстой гэдэг ийм дүгнэлт хийж байна л даа. Тэгэхээр миний асуулт бол Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдээс, сайдаас бол биш шүү гэж байгаа юм. Та бүхэн энэ мэргэжлийн удирдлагыг нь хэрэгжүүлж байгаа хүмүүс учраас яг энэ Эрүүл мэндийн даатгалын удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааг оновчлох чиглэлээр, боловсронгуй болгох чиглэлээр хуульд яг ямар ямар өөрчлөлт хийх шаардлагатай гэж ойлгож байгаа юм бэ. Тэрийг та бүхэн бидэнд хэлээдхээч. Тэгж байж цаашаа явах юм байна гэж.

2 дахь зүйл сая Эрдэнэбат гишүүн ч гэсэн ярьж байна л даа. Энэ төрөөс хариуцдаг Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцдаг тодорхой нийгмийн бүлгүүд байгаа юм. Тэр хүүхэд, ахмад настан, жирэмсэн эхчүүд гэдэг ч юм уу. Гэхдээ энэ бол нөгөө эрүүл мэндийн үйлчилгээ талаасаа бол хамгийн эрсдэлтэй бүлэг шүү дээ. Тэгээд авч байгаа үйлчилгээ нь их өндөр мөртөө өгч байгаа шимтгэл нь бага байна гэсэн ийм зүйлийг та бүхэн яг энэ удаагийнхаа тайлан дээр 2 дахь дүгнэлт болгочхож. Их зөв. Эндээс бол 500 тэрбумын бас асуудал гарчхаад байна гэдгийг ч гэсэн бид нар ярьж байна. Хэрвээ энэ шимтгэлийг жишээ нь нэмэгдүүлэх ёстой бол төрөөс хариуцаж байгаа шимтгэлийг хэдээр нэмэгдүүлэх ёстой гэдэг ийм одоо эсвэл ёстой биш л дээ яах вэ, ямар нэгэн байдлаар тооцоолол байгаа бол тэрийг та бүхэн бас хариулаач ээ гэж байгаа юм. Энэ дээр та бүхэн бол ярьж байгаа байх. Зөвлөл дээр угаасаа ярьдаг юм чинь.

3 дахь Чинбүрэн сайдаас зориуд асууж байгаа юм. Чинбүрэн сайд бол энэ даатгалын тогтолцоотой холбоотой гол үндсэн асуудлын нэг бол хяналт нь өөрөө сайн ажиллаагүй юм гэж байна л даа. Өөрөөр хэлбэл тэндээс бол гүйцэтгэлээр санхүүжилт авдаг. Гэхдээ энэ гүйцэтгэлээр санхүүжилт өгөхдөө хяналт нь бол асуудалд орчихсон юм гээд. Тэр хяналттай холбоотой асуудлыг тэгэхээр цаашдаа хуульд оруулах өөрчлөлтөөр оруулж ирэх гээд байна уу. Эсвэл энэ бол төрийн захиргааны төв байгууллага, цаашлаад Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өөрийнх нь чиг үүрэг шүү дээ. Тэр чиг үүргээрээ энийг хэрэгжүүлж болохоор байгаа юу. Аль нь зөв юм бэ. Алинаар нь та бүхэн хийхээр бас төлөвлөж байгаа вэ гэсэн ийм 2 асуулт байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Хариултыг Чинбүрэн сайдаас эхлэх үү. Чинбүрэн сайд.

Ж..Чинбүрэн: Тэгэхлээр бид 2021 он, 2022, 2023, 2024, 2025 он гээд бас нэлээдгүй жилийг өнгөрөөсөн. Энэ хугацаанд бол Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцоонд гарсан өөрчлөлт нэлээдгүй бас өөрийнхөө хувь нэмрээ оруулж ажиллаж чадсан. Бүр ч муу байсан гэж бол хэлэхгүй. Тэгэхээр нөгөө сангийн тэнцэл гэдэг зүйл бол үнэхээр ерөөсөө биелэхгүй алдагдаж байгаа. Тэгэхээр энэ тэнцлийг бүрдүүлэх зүйл бол ерөөсөө энэ хуулиараа засаж залруулах л зүйл байгаа. Тухайлах юм бол ажил хийж байгаа иргэн хувиасаа, өөрөөсөө цалингаасаа 2 хувийг, ажил олгогч нь 2 гээд нийтдээ 4 хувийг бүрдүүлж байж энэ даатгалын санд татвараа төлж байгаа. Хуримтлалаа бүрдүүлж байгаа. Тэгтэл бид төр дааж байгаа, шимтгэлийг нь төлж байгаа иргэдийнх болохлоор дөнгөж ердөө саяхан л 2 хувь дээр очиж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хуулиар нь бүр 4 хувь гэдгийг оруулж өгөхөд энэ бол нэлээн шударга, зөв зарчим руу орчихно.

Төрөөс дааж байгаа тусламж, үйлчилгээтэй ярихад бол тусламж, үйлчилгээний гарсан зардал, гүйцэтгэл 2 хоорондоо бас барьдаг л байх хэрэгтэй. Төр даана гэж хэлчхээд та нар эмчлээд байгаарай тэр тусламж, үйлчилгээг чинь би төлнө шүү гэж хэлж байгаа шүү дээ. Тийм учраас энэ тогтолцоо өөрөө их шударга байх хэрэгтэй. Тэгэхээр гүйцэтгэл өөрөө бодитой байхын тулд таны сая хэлдэг хяналтын тогтолцоо өөрөө их найдвартай байх ёстой. Энэ гүйцэтгэл бодитой, ийм 900 тэрбум төгрөг гарсан шүү, энэ яг бодитой шүү гэдгийг л ямар ч эргэлзээгүй хийхийн тулд хяналтын тогтолцоо өөрөө хэрэгтэй. Түрүүн хэлдэг Эрүүл мэндийн яам өөрийнхөө харьяанд даатгалын санг байлгана гэдэг маань өөрөө нэг гараараа худалдан аваад, нөгөө гараараа худалдаад байгаа л гэсэн үг шүү дээ. Тэгэхлээр ийм тогтолцоо бол болохгүй. Тусдаа байх. Тэрэнтэй адилхан хяналтын тогтолцоо бас биеэ даасан хяналтын тогтолцоо бол байдаг юм байна. Жишээлбэл БНСУ-д бол тусдаа хяналтын тогтолцоо байдаг. Тухайн хяналтын тогтолцоогоороо гүйцэтгэлээ

баталгаажуулж, тэр нь бодитой болсон гэдгээ баталгаажуулж, тэгээд санхүүжилтээ авдаг ийм тогтолцоо. Тэгэхээр бид гүйцэтгэлийг хянадаг энэ тогтолцоог тусад нь гаргах ийм бас нэг хуулийн заалт бас хэрэгтэй байгаа. Тэгээд энэ дээр би түрүүн хэлдэг нөгөө 8 зорилт, 30 үйл ажиллагаа гэдэг дотор энэ нэг биеэ даасан том сэдэв байгаа. Энийг яаж хийх нь зүйтэй вэ гэдгээ боловсруулаад, тэгээд энийг мэргэжлийн Байнгын хороодоороо бас оруулж, тэгээд бол хууль өргөн барьчихсан байгаа шүү дээ зарим гишүүд. Тэр хуультай холбоотой энэ зүйлүүд бас яригдаж хөндөгдөх байх гэж бодож байгаа юм.

Б.Найдалаа: Хариулт болсон уу. Дахиад зөвлөлийн гишүүдээс асуусан асуулт байгаа. Микрофон хэд вэ. Хэн хариулах юм. Микрофон 3. Нэрээ хэлээрэй та.

Б.Алтанхуяг: Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Алтанхуяг. Зулпхар гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн энэ тогтолцоог шинэчлэх асуудал бол Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл дээр удаа дараа бас бид нар өмнөх сайдын үед ч тэр, шинэ сайдын үед ч гэсэн ярьж байгаа. Ялангуяа энэ тогтолцооны шинэчлэлийн хүрээнд бол сая Чинбүрэн сайд хэллээ. Нэг гараараа төсөв зарцуулдаг, нэг гараараа төсөв баталдаг ийм асуудал байгаа. Тогтолцоог боловсронгуй болгохын тулд бол өнгөрсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд бол өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн холбогдох зүйл заалтын хүрээнд бол үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Өнгөрсөн онд Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 2 ч ажлын хэсгүүдэд бас тодорхой төлөөллүүд маань орж ажилласан. Энэ тогтолцоог сайжруулахлаар ямар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ гэж. Энэ дээр бол өнгөрсөн жил бол Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс бол энэ бол Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд бол эрүүл мэндийн .../минут дуусав/

Б.Найдалаа: Микрофон 3-ыг нээе. Гүйцээж хариулъя.

Б.Алтанхуяг: Бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах нь зүйтэй юм байна гэдэг асуудал дээр Үндэсний зөвлөл дээр бол удаа дараа яригдсан.

2 дахь асуудал тэр төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний асуудал болон төрөөс шимтгэлийг нь хариуцаж байгаа иргэдийн үндсэн 2 тусдаа асуудал байгаад байгаа юм. Энэ дээр 2024 онд гэхэд төр шимтгэлийг нь хариуцан төлдөг даатгуулагч бол даатгуулагчдын нийт эзлэх хувьд харьцуулж үзэхэд бол 70 хувь, шимтгэлийн орлогод эзлэх хувь нь бол 27, зардал талдаа бол 77,2 хувь байгаа юм. Шимтгэлийг нь хариуцах. Нөгөө талдаа энэ төр хариуцах тусламж, үйлчилгээ гэж бас байгаа. Ялангуяа эмзэг иргэдэд хамтын төлбөрөөс бүрэн чөлөөлсөн. Үүнтэй холбоотойгоор жил болгон энэ чөлөөлөлтийн дүн бол нэмэгдэж байгаа юм. Давхар. 2 дахь нь шимтгэлийн хувь хэмжээ маань бол яг өнөөдөр ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажил олгогч 2 хувь, даатгуулагч 2 хувь гэдгээс адилхан яг тийм тогтолцоогоор явахгүй 2 хувиар явж байгаа. Дээр нь дахиад төр .../минут дуусав/

Б.Найдалаа: 1 минут дахиад гүйцээе. Микрофон 3.

Б.Алтанхуяг: Төр хариуцах тусламж, үйлчилгээ дээр дахиж нөгөө яаралтай, дээр нь нярай, жирэмсэн, хавдар гэх мэтчилэн энэ тусламж, үйлчилгээнүүд дээр төр хариуцах үйлчилгээнүүд маань өөрөө бас энэ зардлын гүйцэтгэл нь 2024 оны байдлаар 550 орчим тэрбум төгрөгт гарчхаад байгаа учраас энэ тогтолцоог бол зайлшгүй авч үзэх шаардлагатай байгаа. Улсын Их Хурлын даргын захирамжаар

байгуулагдсан 2 ажлын хэсэг дээр бол Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд 2024 оны 10 болон 11 дүгээр саруудад ч гэсэн хэлэлцүүлгүүд дээр энэ асуудлыг бол тавьсан байгаа. Ингэж байж нэг талдаа төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний орлогыг зардалтай нь дүйцүүлэх замаар бас нөгөө талдаа энэ сангийн тэнцлийг авч үзэх зайлшгүй шаардлага гээд урган гараад байгаа.

Б.Найдалаа: Зулпхар гишүүн тодруулна.

С.Зулпхар: Алтанхуяг гишүүн ээ, одоо бид их тийм 2 талаас их зөв юм ярьж эхэлж байгаа юм байлгүй гэж ойлголоо. Тэгэхээр би ингэж ойлголоо, бид ингэж ойлголоо шүү. Цаашдаа хуулийн өөрчлөлтөөр бол Эрүүл мэндийн сайд бол энэ мэргэжлийн удирдлага хэрэгжүүлдэг Эрүүл мэндийн даатгалын зөвлөлийн дарга байхгүй гэдэг ийм шинэ тогтолцоо руу орно гэж ойлголоо. 1 дүгээрт энэ зөв үү гэж байгаа юм. Би хариултаа зориуд авахын тулд. Дараа нь хууль ингэж орж ирэх юм байна шүү гэж.

2 дахь зүйл бол тэр хяналттай холбоотой, тэр үйлчилгээтэй холбоотой зүйлүүд байх юм байна. Гол юм бол тэр төрөөс жишээ нь үйлчилгээг нь хариуцаж байгаа зүйл дээр тэрнээс гадна шимтгэлийг нь хариуцаж байгаа нийгмийн бүлгүүд дээрээ шинэ төрлийн жишээ нь шимтгэлийн хувь эсхүл ямар нэгэн байгуулалт орж ирэх юм байна гэж ойлголоо. Зөв үү.

Б.Найдалаа: Микрофон 3 хариулъя.

Б.Алтанхуяг: Зулпхар гишүүний бас тавьж байгаа асуудал зөв.

Б.Найдалаа: Хариулт болсон уу Зулпхар гишүүн ээ. Баярлалаа Мөнхсайхан гишүүн асуулт асууна.

Т.Мөнхсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нэг зүйл бас тодруулаад хэлчихмээр санагдаад байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгийг хаана, яаж, хэрхэн хуваарилах вэ гэдгийг чинь Эрүүл мэндийн сайд огтоосоо мэддэггүй шүү дээ. Эрүүл мэндийн яам ч мэддэггүй. Улсын Их Хурлаас томилдог энэ Үндэсний зөвлөлөөр хамтын шийдвэр гаргаж, энэ хуваарилалтыг хийдэг байхгүй юу. Жишээлбэл, улсын эмнэлэгт хэдэн төгрөг хуваарилах уу, хувийн хэвшилд хэдийг хуваарилах уу гэдгийг Улсын Их Хурлаас байгуулагддаг, томилогддог Үндэсний зөвлөл шийддэг. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань бас зөв ойлголттой байх нь зөв байх.

2024 онд шинэ Засгийн газар байгуулагдаад, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаатай сайдаар томилогдоод танилцаад, даатгалын сангийн үйл ажиллагаатай танилцахад одоогийн үүсэж байгаа нөхцөл байдлаас хэд дахин илүү хүнд нөхцөл байдалтай ийм санг л хүлээж авсан шүү дээ. 200, 300 тэрбум төгрөгийн эмнэлгүүдэд өртэй. Оны 11, 12 дугаар сарын төсөв мөнгийг урагш нь татаад санхүүжилтээ хэрэглэчихсэн. 11, 12 сард тусламж, үйлчилгээ зогсох хэмжээнд хүрчихсэн тийм санг хүлээж авсан. Энэ дээр нэлээн цогц арга хэмжээнүүдийг авч, бид нар энэ даатгалын санхүүжилтийн үр ашигтай зарцуулалтыг нэмэгдүүлж, шаардлагагүй тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхгүй байх, сайдын багцаас хэмнэлт хийх гаднын зээлийг буцалтгүй тусламж болгож Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх гэх мэтчилэн цогц арга хэмжээг авч байж бид нар 2024 оны тусламж, үйлчилгээг тасалдуулахгүй давсан. Тэгээд 2025 оны даатгалын сангийн төсвийг 200 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 онд үүссэн байсан энэ өр төлбөрийг 100

хувь барагдуулсан. 2025 оны эхний улиралд бүгдийг нь барагдуулсан. Оны эцсийн санхүүжилтээс урагш нь нэг ч төгрөг татаж хэрэглээгүй. Бүх юм хуваарилалтын дагуу явж байсан. 2024 онд хувийн хэвшилд зарцуулагдах санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 268 тэрбумаар тогтоосон байсан. Нэгэнт тогтоосон, гарсан шийдвэрийн дагуу 2024 онд санхүүжүүлсэн. 2025 оныхыг 163 болгож маш их хэмжээгээр багасгасан. Тэгээд энэ багасгасан хэмжээгээр эргээд улсын эмнэлгүүдийн санхүүжилт маань яагаад нэмэгдэхгүй байна. Өнөөдөр яагаад ямар ч өр зээлийг нь бүгдийг нь тэглэчихсэн, оны эцсээс нь санхүүжилт авч татаж хэрэглээгүй байхад өнөөдөр нөхцөл байдал ийм хүнд байдалд орчхов. 1 дүгээрт.

2 дугаарт өнөөдрийн энэ үүссэн нөхцөл байдлаас гарах ямар цогц арга хэмжээнүүд авч байна. Одоо ямар ч байсан тэр 8 төрлийн арга хэмжээнүүд авах гэж байгаа гэж байна. Энэ арга хэмжээгээ аваад явахад чинь ирэх оны төсөв мөнгөнд нөлөөлөх байх. Тэгэхээр энэ жил, одоо үүсэж байгаа энэ хүндрэлтэй нөхцөл байдал даатгуулагчийн нуруун дээр санхүүжилтийн эрсдэл ирчхээд байгаа энэ нөхцөл байдлаас яаж гарах гэж байна. Зарим эмнэлгүүд эмч, эмнэлгийн ажилчдынхаа цалин мөнгийг тавьж чадахгүй хэмжээнд хүрэх гэж байна. Энэ нөхцөл байдлаас яаж гарах гэж байна гэдэг энэ зүйлүүд дээр тодорхой хариулт хэрэгтэй байна.

Дээрээс нь Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөнөөс нэлээдгүй хувь нь хөнгөлөлттэй эмд зарцуулагддаг. Энэ хөнгөлөлттэй эмүүдийг бид нар нэгдсэн худалдан авалтаар авах юм бол энэ оны хувьд 50-60 тэрбум төгрөгийн хөнгөлөлт хийх, энийгээ эргээд тусламж, үйлчилгээ дээр зарцуулах боломжтой байсан. Ингээд бид нар 24 нэр төрлийн эмийг 1 эх үүсвэрийн худалдан авалт хийгээд, эхний ээлжид 2-2,5 тэрбум төгрөгийн хэмнэлтийг хийж эхлээд байсан. Одоо энэ эмүүд маань хэчнээн тоо ширхэгт хүргэж байна. Энэ бодлого явагдаж байна уу. Цаашлаад чанартай эмийг боломжийн үнээр авах бодлого маань хэр үргэлжилж байна. Энэ дээр тодорхой хариулт .../минут дуусав/

Б.Найдалаа: Хариултыг Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Мөнхсайхан гишүүнтэй яг л одоо би танаас яг наад санааг чинь л асуугаад байгаа. 316 тэрбумыг нь тэглэххээд одоо өргүй ажиллана шүү гээд тоо хязгаар тавиад өгчхөөд байхад дахиад 160, дээрээс нь ахиад хувийн хэвшлийнхэн 80 тэрбум гаргах гээд ингээд байж байгаа байхгүй юу. Одоо сар болгон ийм санхүүжилтээр ажиллана гэсэн дүрэм хэлж өгөөд байхад санхүүгийн сахилга батгүй байгаа асуудал нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргыг солих шалтгаан болсон. Бод л доо. Ингээд өрийг нь төлчихсөн, ямар ч өргүй болчихлоо. Одоо 2,5 их наядаас 300-г нь хасчихсан 2.2-т багтаад ажиллаарай гээд байдаг. Тэгээд хуваарилалт хийгээд өгчихсөн. Улсын эмнэлэг нь тэдийг зарцуулаарай, хувийн эмнэлэг нь тэдийг зарцуулаарай. Хувийн эмнэлгүүд нь 8 сард 160 тэрбумаа ашиглаад дуусчихсан. Дахиад дараалаад 40, 40 тэрбумаар нь гаргах гээд сууж байгаа юм. Дахиад 80 тэрбум төгрөгийн өрөнд орох гэж байсныг нь зогсоочихлоо.

Хөнгөлөлттэй эмтэй холбоотой асуудлыг бас нэмж хариулна биз. Аудитын дүгнэлтээр процессын алдаа байна гэсэн ийм дүгнэлт гарсан. Тийм учраас бид дэлхийн зөвшөөрөгдсөн ОУБ Юнисеф-ээр дамжиж, Юнисеф-ийн эм борлуулдаг платформоор дамжуулж нэгдсэн худалдан авах үйл ажиллагаа үргэлжлээд явж байгаа. Тэнд байхгүй эмүүдийг үйлдвэрлэгч компаниудаар үнэ харьцуулалтаар худалдан авч, шаардлага хангасан эмүүдийг Монголд оруулж ирнэ. Мэдээж процесс бол өөрөө цаг хугацаа их ордог. Та мэдэж байгаа сайд байсан хүн. Нэлээн цаг

хугацаа орж байгаа. Тэгэхдээ ажлууд бол үргэлжлээд явж байгаа. Нэгдсэн худалдан авах үйл ажиллагааг хийх нь бол өөрөө маш зөв, чанартай эмийг боломжийн үнээр авах том гаргалгаа. Тэгэхээр энэ дээр бол ямар ч зөрчилдөх зүйл байхгүй. Нэгдсэн худалдан авалтаа үргэлжлүүлнэ.

Б.Найдалаа: Хэддүгээр микрофон байна. Нэмж 1 дүгээр микрофон.

М.Нармандах: Нэмэлт мэдээлэл өгье. Эрүүл мэндийн даатгалын сангаас 159 нэр төрлийн 670 худалдааны нэршлийн эмийг эмийн үнийн хөнгөлөлтөд хамруулаад явж байгаа. Үүнээс 1 эх үүсвэрийн 18 төр нэр төрлийн эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцаад явж байгаа. 18 нэр төрөл дээр бол нэмж нэр төрөл бол нэмэгдээгүй. Зүгээр нэмэлтээр 3 нэр төрлийн эмийг дахиж татан авалтаар авахаар бол төлөвлөөд ажиллаж байгаа. Ерөнхийдөө Эрүүл мэндийн даатгалын сангийн хэтрэлт маань юунаас үүдээд байна гэхээр Эрүүл мэндийн даатгалын тухай хууль дээр ч тэр, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол дээр ч тэр амь тэссэн үеийн тусламж, үйлчилгээ болох яаралтай тусламж, үйлчилгээг аливаа хязгааргүйгээр санхүүжүүлэх ийм хууль .../минут дуусав/

Б.Найдалаа: Мөнхсайхан гишүүн тодруулж асууя.

Т.Мөнхсайхан: Өнгөрсөн жил 2024 оны Засгийн газрын 100 хоногийн хугацаанд багтаад бид нар шинэ бодлого хэрэгжүүлээд, 18 төрлийн маш чанартай эмийг хямд үнээр оруулж ирээд явчихсан байсан шүү. Тэгэхэд энэ хийж хэрэгжүүлж байсан бодлогыг өргөжүүлж байгаа мөртөө одоо 100 хоног байтугай болж байхад энэ дээр нэмж эмүүд оруулж ирээгүй, ард иргэдэд хүрэх чанартай эмийг энэ дээр асуудал шийдээгүй байна гэдэг бол дэндүү удаан байна шүү.

2 дугаарт би танаас яг тодорхой ямар бодлогууд хэрэгжүүлэв гэж асуусан. Би танаас бодлого асуухаар та өөдөөс хүн яриад байх юм. Ингэхээр чинь бид нар яаж урагшлах юм бэ. Бид нар цогц тийм дорвитой бодлого арга хэмжээнүүд авч явна уу гэхээс биш 1 хүний асуудал яриад асуудал шийдэгдэх ийм зүйл биш шүү дээ. Бид нар энэ салбарынхаа санхүүжилтийг сайн нэмэгдүүлж байж амжилтад хүрнэ шүү сайд аа.

Б.Найдалаа: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр цоорхой шанага шиг болчихоод байгаа юм. Мөнгө хийгээд дээрээс нь хийгээд нөгөө цоорхой шанагаар чинь доошоо мөнгө нь урсаад байгаа учраас эхлээд цоорхойгоо нөхье. Энэ эхний ажил явж байгаа шүү. Цоорхойгоо нөхөөд цоордоггүй, гоождоггүй, алга болдоггүй мөнгөтэй болчихье. Өнөөдөр бид 2026 оны төсөв хэлэлцэж байгаа. Энэ дээр та бүхэн, та өөрөө гишүүний хувьд хүртэл санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, энэ хуулийн төсөлд саналаа оруулах бүрэн эрх нь нээлттэй байгаа. Миний хувьд бол, Засгийн газрын хувьд бол эхлээд цоорхой саваа битүүлж авна л гэдэг ийм том зорилго 2026 ондоо хийж байгаа. Үүний эхний ажиллагаа нь тэр хөтөлбөр гаргасан. 2 дахь ажиллагаа нь хүнээс хамааралтай цоорхойг эхлээд алга болгочихье. Тийм учраас энэ ярихаас өөр арга байхгүй.

Б.Найдалаа: Баярлалаа. Мөнхсайхан гишүүн боссон тээ. Бум-Очир гишүүн асуулт асууна.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Эрүүл мэндийн даатгалын сангийн гол асуудал миний ойлгож байгаагаар сангийн мөнгийг яаж хүргэх вэ. Сангаа яаж мөнгөтэй байлгах вэ. Ирээдүйд бидний хүсэл мөрөөдөл бол сан маань бүр нөөцтэй, хуримтлалтай баймаар байгаа юм л даа. Энэ ард нь бол мэдээж та бүхэн мэдэж байгаа. Хүний эрүүл мэнд, амь насны тухай асуудал байгаа. Тэгэхээр энэ бидний хүсэж мөрөөдөөд байгаа ирээдүйд нөөцтэй, хуримтлалтай болох тэр хэмжээнд хэзээ яаж хүрэх юм бэ. Сая сайд хэлж байна. Цоорхой байгаа хэмнэе. Өмнөх сайд хэлж байна. Хэмнээд болоод байсан, одоо яагаад болохоо больчихож байгаа юм гэх мэтчилэн. Тэгэхээр 1 дэх зүйл нь бол ямар ч байсан тэр цоорхойнуудаа арилгах, хэмнэх тухай асуудал байх байх.

Дараагийн нэг зүйл Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрч байгаа эх үүсвэрийг яаж нэмэгдүүлэх боломжтой юм бэ. Даатгал төлөхгүй байгаа, хамрагддаггүй хүмүүс байгаа. Улсаас төлж байгаа. Энэ хүмүүсээ даатгалд оруулах, жишээ нь хувиараа бизнес эрхэлдэг ч юм уу, орлого нь тодорхойгүй малчид байх уу, оюутнууд гэх мэтчилэн. Хүүхдүүд, өндөр настнуудыг ярихаа больё тийм ээ. Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын сангийн энэ орлого хуримтлуулж байгаа зүйлийг яаж цаашид нэмэгдүүлэх вэ гэдэг асуудлыг бодлогоор бид яаж шийдэж авч явах ёстой юм бэ. 1 дүгээрт.

Энэ дээр нэг зүйлийг бас тодруулмаар байна. Энэ эрүүл мэндэд ноцтой хохирол учруулаад өвчлөлийг нэмэгдүүлж байгаа хүнсний бараа бүтээгдэхүүнүүд байгаа. Давс, чихэр, тамхи гэх мэтчилэн. Онцгой албан татвар авч байгаа. ДЭМБ-аас улс орнуудад тавьж байгаа, манайд ч гэсэн тавьж байгаа зөвлөмж бол тэндээс авч байгаа онцгой албан татварыг Эрүүл мэндийн даатгалын сан дээр татаж, даатгалын сангаа санхүүжүүлэх ийм боломж, бололцоо байдаг гэдэг ийм дэлхийн олон улсын туршлагыг яриад байдаг. Миний ойлгож байгаагаар манайх бол тэгэхгүй байгаа болов уу. Хэрвээ тэр өвчлөл чихрээс болоод, газтай ундаанаас болоод нэмэгдээд байгаа бол тэр дээр нь татвар тавиад, тэр онцгой албан татвар маань эргээд тэндээс гараад байгаа өвчлөлийг арилгахад юм уу, анагаахад чиглэгддэг байх ёстой болов уу гэж бодож байна л даа. Тэгэхээр энэ чиглэлийн зохицуулалтууд, бодлогууд ер нь ямар шат дараатай яаж хийгдэх вэ. Бид ингээд жилийн жилд жилийн эцэст Эрүүл мэндийн даатгалын сан маань мөнгөгүй болчихлоо гээд ингээд яриад суугаад байх уу. Энэ байдлаасаа яаж гарах юм бэ. Орлогоо яаж нэмэгдүүлэх юм. Цоорхойнуудаа яаж одоо нөхөх юм. Энд урт болоод дунд хугацааны шийдэл, боломж юу байна вэ гэдгийг та бүхэн маань тайлбарлаад өгнө үү.

Б.Найдалаа: Чинбүрэн сайдаас эхлээд хариулъя.

Ж.Чинбүрэн: Чухал сэдэв энд бас яригдлаа. Шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн хамралтыг нэмэгдүүлэх нь өөрөө бас энэ даатгалын сангийн нэг томоохон хэсэг байгаа. Энд малчин, оюутан, хувиараа бизнес эрхлэгч нар гэж. Орлогын эх үүсвэргүй, орлого багатай иргэдийг бол төрөөс шимтгэлийг нь даах байдлаар хүүхэд, өндөр настан, групп, тэгээд жирэмсэн эмэгтэй, ял эдэлж байгаа хүн, цэргийн алба гээд энд бол төрөөс шимтгэлийг нь даачхаж байгаа юм. Яг өөрөө шимтгэлээ төлдөг иргэдийн хамрагдалт ердөө малчны хувьд 38 хувьтай. Оюутнууд 70 хувьтай. Хувиараа бизнес эрхлэгчид 44 хувьтай. Тэгээд эдгээр иргэд шимтгэлээ төлөхдөө яадаг вэ гэхээр өвчин зовлон ойртоод ирэх юм уу, эсвэл эмнэлэгт үзүүлэх шаардлага гарахаар гэнэтхэн төлөөд эхэлдэг. Тэгээд тусламжаа авахаараа орлого 23 орчим тэрбум төгрөг бүрдүүлдэг, зардал нь 119 тэрбум. Тэгэхээр энэ нөхцөл байдлыг арилгах нь өөрөө их чухал бас асуудал байгаа. Тэгэхээр бид нарын нөгөө

яриад байгаа 8 зорилгын 1 томоохон зорилго хэсэг нь бол шимтгэлээ өөрөө хариуцсан иргэдийг Эрүүл мэндийн даатгалтай гүйцэд тогтмол хамрагддаг байх энэ бодлогын асуудал бас чухал хэсэг эзэлж байгаа шүү. Энийг ингэж оруулж, зүгээр нөхөн төлөөд л орчихдог байдлыг бид өөгшүүлээд байх тусам энэ хамрагдалт ерөөсөө нэмэгдэхгүй юм байна лээ. Тэгэхээр энэ тусдаа нэг бие даасан ийм бодлого байгаа.

Б.Найдалаа: 2 дахь асуулт байсан байх.

Ж.Чинбүрэн: Онцгой албан татвараар архи, тамхи, дээрээс нь чихэрлэг ундааны татварууд орж ирдэг. Энийг бол төвлөрүүлэх үйл ажиллагаа бас л яг хууль нь байгаа боловч энэ бодитой хэрэгжиж өгөхгүй байгаа. Энэ бол Эрүүл мэндийг дэмжих санд төвлөрч нийгмийн эрүүл мэндийн чиглэлд нөгөө эрүүл мэндийн боловсрол олгох, буруу дадал зуршлаас арилгахад зарцуулагдах ёстой ийм санхүүжилт. Зүгээр бид энэ төлөвлөгөө дотроо бас орж байгаа зүйл бол нэгэнт бид эрүүл мэндийн татварыг иргэддээ ачаалал болгож нэмэхгүйн тулд баялгийн санг эрүүл мэндэд зарцуулж болох ийм гаргалгаа байгаа. Тэгэхээр энийг бас ийм хуулийн гаргалгааг бас бодож, нэг ёсондоо Эрүүл мэндийн даатгалын татварын хувийг нэмэгдүүлэхэд баялгийн сангаас иргэн бүр тэрийг нь ашиглах, хуваарилах энэ боломжийг олгох тухай бас энэ асуудлыг бас тэр 8 зорилт дотор орчихсон ярьж явж байгаа. Энэ бол 3 жилийн дотор хэрэгжээд, тэгээд хууль болох нь хууль болоод, тогтоол болох нь тогтоол болоод, хэрэгжүүлэх институцийг бэхжүүлэх зүйл нь болоод ингээд явах юм.

Б.Найдалаа: Бум-Очир гишүүн тодруулж асууна.

Д.Бум-Очир: Баярлалаа. Онцгой албан татвараас яг эрүүл мэндийн санд татаж зарцуулж, төвлөрүүлж болох хэчнээн төгрөг цуглардаг юм бол улсын төсөв дээр. Тэрийг зүй ёсоор нь Эрүүл мэндийн даатгалын сан дээрээ татаж авах ажлыг манай Байнгын хороо ч тэр, Их Хурал ч тэр, Засаг ч тэр хариуцаад явах ёстой болов уу гэж бодох юм. Тэгээд тэр чинь логикоороо бол тэнд зориулж байгаа юмыг зориулалтаар нь л ашигламаар байгаа байхгүй юу. Бид нар улсын төсвөөс янз бүрийн мөнгө нэхэх гэхээсээ илүү тэнд зориулах ёстой мөнгө нь орчхоод байна шүү дээ. Тэрний тоог нь мэдмээр байгаа юм. Тэгээд тэр тоо нь одоо энэ Эрүүл мэндийн даатгалын сан дээр нэхэгдээд, дутагдаад байгаа тэрийгээ авчраад авъя л даа. Энэ чинь бид зориулах ёстой мөнгө нь тэнд өөр юманд яваад байх шиг байна. Тэгвэл л энэ эрүүл мэндийн салбар энэ сан маань тэр мөнгөө нэхэж хөөцөлдөж авч болдоггүй юм уу. Сангийн яам мэддэг юм уу, Ерөнхий сайд мэддэг юм уу. Хэн нь мэдээд өгдөггүй юм.

Б.Найдалаа: Энэ асуулт уу Бум-Очир гишүүн ээ. Энэ дээр хариулчих Үндэсний зөвлөлийн гишүүн байна уу. Эсвэл байр сууриа илэрхийлэх. Байхгүй байна уу. Тэгвэл дараа өөр Байнгын хорооны хурал дээр тодруулъя. Сангийн яамнаас тодруулмаар байна.

Д.Бум-Очир: Баярлалаа. Би 2 товчхон асуулт байна. Тов тодорхой. Өнгөрсөн 4 жилд Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн талаар, сайжруулах талаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Азийн хөгжлийн банкнаас техникийн туслалцаа аваад, нэг томоохон судалгаа хийсэн юм байна лээ. Тайлан. Тэрний тайлан хаана байгаа вэ. Тэрийг хэрэг болохоор юм байна уу, үгүй юу. Тэгээд тэрийг хэрвээ байгаа бол гишүүдэд явуулаад өгөөч.

2 дахь нь дампуурсан банкнуудтай холбоотой Капитал банкнаас нь баахан авлага байгаа даа. Хөрөнгүүд ирсэн байсан. Тэгээд та бүхний тайлан дээр 35,6 тэрбум төгрөгийн хөрөнгийг түрээстэй холбоотой үр ашиггүй зарцуулсан, үр ашиггүй түрээсэлсэн ямар нэгэн тийм дүгнэлт байна. Энэ яг юу болсон. Хэдэн төгрөгийн акт тавигдсан юу юм. Бодвол тэр Энхтайван найрамдлын ордонтой холбоотой юм шиг байна. Энэ дээр яг тов тодорхой Үндсэн зөвлөлийн гишүүд хариулаад өгөөч.

3 дахь нь хуульд Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 4-өөс доошгүй тогтооно гээд заачихсан байгаа. Тэгээд та бүхний актуар тооцоо хийсэн байна уу, хийгээгүй байна уу. Ер нь зүгээр Эрүүл мэндийн даатгалын шимтгэл 4 байх нь зөв байна уу. 3 байх нь зөв байна уу. 6 баймаар байна уу. Хэд баймаар юм. Хэд байвал оновчтой болох гээд байгаа юм. Та бүхний тооцоо санал бодлоор бол гэсэн ийм 3 асуулт байна. 1 номер.

М.Нармандах: Банкны өр авлагын асуудлаар хариулт өгье. Эрүүл мэндийн даатгалын сан дээр Капитал банкны нийтдээ 136,1 тэрбум төгрөгийн өр төлбөр байснаас яг өнгөрсөн жилийн буюу 2024 оны тайлан гарах үед 75,9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Үндэсний аудитын газраас санхүүгийн аудит хийсэн, гүйцэтгэл нийцлийн аудит хийсэн. Эдгээр аудит болгон дээр нь өгч байгаа албан шаардлага, зөвлөмжүүд нь юу вэ гэхээр энэ даатгалын сангийн өр авлагаа барагдуул гэдэг асуудлаар дандаа зөвлөмжийг өгдөг.

2024 оны хувьд бол Энхтайван найрамдлын ордныг түрээсэлж байсан түрээслэгч нь өөрөө нас барчихсан. Бид нар холбогдох хууль хяналтын байгууллагаар явахад одоо эрх хүлээн авагч бо одоо тодорхойгүй байна гэдэг шүүхийн шийдвэр гарснаас болоод энэ 106 сая төгрөгийн түрээсийн орлогын асуудал дээр одоо шүүхийн шийдвэртэйгээр ингээд явж байгаа. Аудитаас болохлоор эзэн холбогдогчийг нь олж төлүүлье гэдэг ийм албан шаардлага энэ тэрийг бол өгсөн байсан. /минут дуусав/

Б.Найдалаа: Шитгэлийн 4 хувь. 3 дугаар микрофон.

Б.Алтанхуяг: Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл дээр 2025 оны 5 сарын 16-нд Даатгалын ерөнхий газраас 2024 онд Эрүүл мэндийн даатгалын санд хийсэн актуар тооцооллын тайланг бас ирүүлсэн. Энэ дээр хамгийн 1 дүгээрт бол төр хариуцах иргэдийн шимтгэлийн хувь хэмжээг 3 болгох талаарх энэ актуар тооцоолол нь орлого болон зардал талдаа бас 1 дүгээрт боломж байна гэдэг ийм тооцоо ирсэн.

2 дугаарт энэ төр хариуцаж байгаа тусламж үйлчилгээний зардлуудын харьцааг ойртуулах, энийг ялангуяа төсөв хэлэлцэхэд энэ асуудлыг зайлшгүй оруулах шаардлагатай гэдэг асуудал.

3 дугаарт бас нэг зүйлийг тодотгож хэлэх хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд ялангуяа манай нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний зардал жил болгон өсөж байгаа. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч байгаа хүний тоо жил болгон өсөж байгаа. Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо маань бас энэ 2024 онд 26,3 сая болоод өсчихсөн. Энэ маань өөрөө бас нөгөө талдаа энэ тохиолдлын тоо .../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулж дуусгая. 3.

Б.Алтанхуяг: Тохиолдлын тоонууд маань өсөж байгаа нь өөрөө энэ даатгалын санд бас нөлөөлөл үзүүлж байгаа. Нэгэнтээ даатгуулагч тусламж, үйлчилгээг авчихсан бол тэр даатгалын гэрээтэй байгууллагуудаар даатгалын ерөнхий газраас санхүүжилтийн процесс нь хийгдээд явж байгаа ийм л дүр зураглал. Тэгэхээр энэ бол ганцхан өвдсөн болгоныг эмчлээд гаргана гэхээсээ илүү бас нөгөө талдаа даатгалын үндэсний зөвлөл дээр ялангуяа урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн асуудал энэ эмнэлэгт ирж тусламж, үйлчилгээ авахгүй тэр урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээн дээр ямар бодлогын арга хэмжээ вэ гэдгийг бас ярилцаж байгаа.

Б.Найдалаа: Та тэр нөгөө 4 хувийг хариулчихгүй юу. 4 хувь дээр та хэдийн санал ярьдаг юм юу байдаг юм. 4 багадаж байна, нэгдэж байна.

Б.Алтанхуяг: 4 дээр бол ямар нэгэн өөрчлөлтийн талаар энэ бол нөгөө албан журмын даатгал учраас даатгуулагч 2 хувь, ажил олгогч 2 хувь гээд 4 хувь дээр бол энэ оны 2024 оны хэлэлцүүлгийн үед бол тусгагдаагүй. Ямар ч байсан төр хариуцах тусламж, үйлчилгээний иргэдийг 3 хувьд хүргэх, төр хариуцах тусламж, үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх гэсэн энэ 2 асуудлыг л тавьсан байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Та бүгдийн санал, бодлыг сонссон юм. Гишүүд асуулт асууж дууслаа.

2024 оны Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тайланг хэлэлцэж байгаатай холбоотой үг хэлэх гишүүд нэрсээ өгье. 4 гишүүн байна. Рэгдэл гишүүнээр тасалъя. Эрдэнэбат гишүүн үгээ хэлнэ.

С.Эрдэнэбат: Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн журмыг шинэчлээд, хааяа нээлттэй хуралддаг баймаар байна. Одоо Чинбүрэн сайд ч гэсэн өөрөө сайд биш байхдаа нээлттэй баймаар байна гээд байсан. Одоо сайд болчихоод өөрөө энийгээ хэрэгжүүлэх хэрэгтэй. Тэгэхгүй бол иргэд чинь мэдээлэлгүй байна. Их Хурлын гишүүд рүү түмэн янз бүрийн асуулт, санал, танин мэдэхүйн зүйл явж байна. Тийм учраас үнэхээр тэр байгаа байдлаа иргэд нь бас сонсог. Энэнээс айж зугтаагаад, ихэнх хүмүүс нь хааяа ярихаараа дампуурчихсан энэ тэр гээд янз бүрээр ярьдаг. Энийг бас захиж хэлмээр байна. Энэ тал дээр анхаарч ажиллаарай.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд ч гэсэн хааяа шаардлагатай хууль тогтоомжийн хэрэгцээ байвал мэргэжлийн Байнгын хорооны гишүүддээ хандаад, хамтарч ажилламаар байна. Тэгэхгүй бол хэдүүлээ жилдээ нэг тайлан тавих үед л нэг уулздаг. Тэгээд маш товчхон хүү, хаа гээд л өнгөрдөг байж болмооргүй байна. Асуудал бол гадаа бол бас нэлээн их байна шүү дээ. Тийм учраас энэ тал дээр бол Эрүүл мэндийн зөвлөлийн гишүүд минь анхаарал санаачилгатай ажиллаарай. Бас олон газраар явж өмнөх өмнөх эрүүл мэндийн зөвлөлийн гишүүдийг бодох юм бол газар дээр нь хамгийн их явж ажиллаж байгаа үндэсний зөвлөл байгаа гэж би бодож байгаа. Одоо энэ дээрээ харин бодлогын асуудлуудаа үндэсний зөвлөлийн дарга, гишүүд бол бас оруулж ирэх ёстой гэдгийг бол хэлмээр байна.

Даатгал дээр түрүүн Найдалаа гишүүн бас чухал юм асуулаа. Ер нь манай Эрүүл мэндийн даатгалын хувь чинь ингээд аваад үзсэн бас тийм өндөр хувь бол биш юм байна лээ шүү дээ. Германд гэхэд 14 хувь байдаг юм байна лээ. Одоо манайх төр хариуцна гэхээр 2 хувь, тэгээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээ тавьчихсан. 3 хувь болгоё гээд оруулаад ирье гэдэг дээрээ энэ жил ч гэсэн оруулаад

ирэхэд болохгүй юм байхгүй шүү дээ. Тэрийгээ харин тэр сайдын хэлж байгаагаар тэр эрүүл мэндийн баялгийн сангаас оруулах уу, яах уу. Тэр бол төрийн шийдэх асуудал. Тэгэхгүй бол хүрэхгүй байгаа санг хүргэх гэж үзээд, одоо тэгээд хассаар байгаад сүүлдээ бараг юм үлдэхгүй байдалтай л болох гээд байна л даа. Ирэх жил энэ байдлаар урсгал зардал дээр бол юм оруулж ирээгүй юм байна. Цалин нь яах юм. Зарим тусламж үйлчилгээнүүд нь яах юм.

Хамтын төлбөр гэсээр байгаад нөгөө даатгал төлж байгаа хүмүүсээс нь бүгдээс нь эмнэлэгт очихоор нь мөнгө авна гэдэг юм руугаа л орох гээд байгаа юм уу гэдэг л ийм ойлголт байгаад байна шүү. Тийм учраас энэ эрүүл мэндийн юун дээр анхаараарай. Дээрээс нь бас нэг тодорхой судалгаанууд гаргаж өгмөөр байна. Улсын эмнэлгүүдээс хэчнээн эмч нар гарсан бэ. Хэчнээн сувилагч нар гарсан бэ. Мэргэжлийн эмч нар маань хаашаа нүүдэллэж байна гэдэг дээр бол хамгийн их санаа зовж байгаа зүйл байна. Хувийн хэвшлийн салбар луу явж байна уу. Өөр салбар луу явж байна уу. Гадаад руу урсаж байна. Сувилагчийн хувьд бол бараг 2 гараа өргөөд буугаад өгчихсөн байгаа шүү дээ. Цаашдаа бол энэ бол зогсохгүй юм шиг байна лээ. Тэгэхээр энэ дээр тодорхой санал бол хэрэгтэй байна бид нарт.

Дараагийнх нь энэ аптек гээд би намайг байх үед л хэлж байсан юм. Хөвсгөл аймагт явах үеэр 7 суманд Эрүүл мэндийн даатгалын гэрээгүй, иргэд яадаг вэ гэхээр бараг 100км-ийн цаанаас аймгаасаа очиж хөнгөлөлттэй эмээ авдаг. Тэгээд сая ингээд санал тавьсан чинь маш өндөр шаардлага тавьчихсан. Сумд тэдэн метр квадрат, ийм ийм гээд тавьчихсан. Тэгэхээр зарим талаараа яг энэ бодит манай энэ хөдөөгийн нөхцөл байдалд таарсан тийм юу хийхгүй бол Улаанбаатар хотын өндөр стандарт шаардлага тавиад, бүхэл бүтэн аймгийн бараг тал сум нь Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй эмээ авч чадахгүй хэдэн жил ч болчихсон юм. Энэ тал дээр бол яг тодорхой ажил хийж, санал өгөөрэй гэдгийг бас хэлмээр байна.

Тэгээд эрүүл мэндийн дарга нарыг томилохтой холбоотой асуудал дээрээ бас анхаараарай. Тэгэхгүй бол дандаа ер нь улс төрчдийн хамааралтай хүмүүс, сүүлдээ би, чи гээд хэрүүл болдог. Эмнэлгийн байгууллагууд 1 даргаас болоод тарж бутардаг. Тийм учраас энэ тал дээр бол Чинбүрэн сайд, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд ч гэсэн энэ өгч байгаа санхүүжилтийнхээ араас цаана нь юунд зарцуулж байна гэдгийг нь үзээрэй. Эмч нь мэддэггүй, сувилагч нь мэддэггүй, хамт олон нь мэддэггүй. Зөвхөн дарга нь мэддэг гэдэг ийм юм бас яваад байх шиг байна лээ. Тэгээд энэ тал дээр анхаарч ажиллаарай гэдгийг хэлье. Амжилт хүсье.

Б.Найдалаа: Баярлалаа. Рэгдэл гишүүн үг хэлнэ.

Д.Рэгдэл: Тайлантай танилцсан. Тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газраас Үндэсний зөвлөлийн тайланд бас үнэлэлт, дүгнэлтээ өгсөн байна лээ. Харсан. Тэгэхээр миний ойлгож байгаагаар бол зөвхөн өнөөдөр сонсож байгаа юм биш ээ. Ер нь манай Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо буруу байгаа юм. Дандаа алдагдалтай байгаад байдаг. Удирдлагын тогтолцоо үндсэндээ бас зохимжгүй хийгдчихсэн. Тэгэхээр энийг засаж явах ёстой юм байгаа юм. Тэгэхээр энэ чинь 3 талт харилцаанд орж байгаа 3 субъект харьцангуй ойролцоо эрх мэдэлтэй байх ёстой юм. Манай тогтолцоогоор Эрүүл мэндийн сайдын 2 карманд 2 хэсэг л орчихсон. Энэ талд нь тусламж, үйлчилгээ буюу эмнэлэг, энэ талын карманд нь сан. Нөгөө иргэн дунд нь ганцаардчихсан. Ийм л юм яваад байгаа юм. Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын сангийн удирдлагыг томилдог тогтолцоогоо ядахдаа өөрчлөх нь зүйтэй. Удирдах зөвлөлөөсөө томилдог юм уу, эсвэл сайд нь Удирдах зөвлөлийн

дарга байх нь буруу юм шиг л харагдаад байгаа. Энэ тогтолцоо энэ хууль, эрх зүйн орчиндоо өөрчлөлт оруулаад, зоригтой явах ёстой. Энэ дээр чинь алдагдал үүсгэдэг 1 гол шалтгааныг бас тэр тайланд хэлсэн байгаа юм. Энэ төрөөс шимтгэл төлдөг хүмүүс орлогын 27 хувийг бүрдүүлчхээд, зарлагын 77 хувь нь тэндээс тэд нарт олгогдоод байна гэдэг нь энэ буруу. Сая Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн хэллээ. Энэ төрөөс даадаг тэр 2 хувийг чинь нэмж байж, ядахдаа энэ 77 хувийн зарлагын ихэнхийг нь нөхдөг л байж байж үүний чинь алдагдал бодитойгоор буурна. Тэгэхгүйгээр ийм тогтолцоо чинь угаасаа оршин тогтнох арга байхгүй.

Дараагийн нэг өөрчлөлт бол хувийн Эрүүл мэндийн даатгалыг хөгжүүлэх ёстой юм байгаа юм. Дэлхийн жишгээр бид нар явж байх учиртай байдаг шүү дээ. Зөндөө газар л байдаг. Тэгэхээр үүнийг эрх зүйн орчныг нь сайжруулаад, байгуулаад ингээд явбал бас хувийн хэвшлийн оролцоог энд ашиглах бүрэн боломжтой салбар.

Үндэсний зөвлөлийн тайланг өнөөдөр хэлэлцэж байгаа бол үндсэндээ ер нь утга агуулга бараг байхгүй 2026 оны улсын хөгжлийн төлөвлөгөө батлагдчихсан. Үндсэндээ 2026 оны төсвийн хүрээ бол өдийд аль хэдийн батлагдчихсан байдаг. Зүгээр энэ жил жаахан тодотголоос болоод одоо ингээд явж байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ тайланг 2205 оны 1 дүгээр улиралдаа хэлэлцэж дуусаад, дараа дараагийн улсын төлөвлөгөө, дараа 2025 он, 2026 оны төлөвлөгөө, 2026 оны төсөв рүү оруулах асуудлыг ярьж байх ёстой юм байгаа юм. Одоо бид нар өнөөдөр хэлэлцээд л өнгөрнө. Энэний чинь аль руу нь ч энэ даатгалын сангийн орлого зарлагыг өөрчлөх асуудлыг оруулаад ерөөсөө явахгүй. Өөрөөр хэлбэл 2024 оныхыг бол бид нар 2025 оны эхний улиралд хэлэлцээд дуусчихсан, дүгнэчихсэн, ямар зовлон байна, тэрийг нь төсвөөр шийдэх боломж юу байна гэдгийг Их Хурал төсөөллөө авчихсан байх ёстой юм. Энийгээ өөрчлөх хэрэгтэй. Энэ хугацаагаа өөрчил. Өнөөдөр бол яах вэ нөгөө шувуухай тавьдаг л юм болж байна л гэж. харамсалтай нь би тэгж харж байна. Одоо улсын хөгжлийн төлөвлөгөөнд ямар ч юм оруулах боломж байхгүй. Одоо даатгалын сангийн төсвийг чинь Засгийн газар боогоод аваад оруулаад ирчихсэн. Боогоод ирчихсэн. Зарлагыг нэмэгдүүлэх, орлогыг нэмэгдүүлэх боломж Их Хуралд маш бага. Тэгээд энэ тэр дээрээ жаахан анхаараад, эрх зүйн орчиндоо сайжруулалт хийгээд яваасай л гэж хүсэж байна. Түүнээс одоо Удирдах зөвлөл сайн ажиллаж, уу ажиллаж гэж хэлэх тийм бодитой мэдээлэл бол надад байхгүй байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Зулпхар гишүүн үг хэлнэ.

С.Зулпхар: Бид өнгөрсөн жил ч гэсэн яг хэлэлцсэн. Өнгөрсөн жил бас тодорхой асуудлууд байсан. Тухайн үед асуудал хариуцсан сайд нь бол тодорхой бас шийдлүүд танилцуулаад, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тулгамдаад байсан тодорхой жишээ нь асуудлуудыг даван туулах тийм арга замуудыг бас хэрэгжүүлсэн. Гэхдээ энэ бол яах вэ зүгээр хэн сайд байхаас, эсвэл ямар хүн сайд байхаас шалтгаалаад энэ сан дээр ямар нэгэн асуудал үүсээд байгаа юм бол биш. Энэ сан нь угаасаа тэр хэлээд байгаа тогтолцоотой уялдсан, тэрнээс гадна тогтолцоогоо бид бүрэн хэрэгжүүлж чадахгүйгээс болоод л ийм асуудал үүсчихсэн байгаа шүү дээ. Хамгийн энгийнээр хэлэх юм бол энэ үйлчилгээг авдаг эмнэлгийн удирдлагууд чинь Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны талаар бол эрүүл мэндийн эмнэлгийн менежментийн талаар нэг их айхтар мэргэшсэн хүмүүс биш байдаг ийм тохиолдлууд байдаг. Үүнээс болоод асуудал үүсэж байгаа. Тэрнээс гадна манай өөрийн соёлын орчинд байж байгаа зүйлүүд бол байгаа шүү дээ. Одоо бие биеэ сайн мэддэг учраас тэрэнд нь энэ тэрээ гэсэн янз янзын асуудал гарч байна гэж. Тэр жичдээ асуудал байхгүй. Гэхдээ энэ бол одоо нэгэнтээ ингээд бид тогтолцоогоо ахиад боловсронгуй болгоно гэж байна. Тогтолцоо муу тогтолцоо бол

биш. Энэ бол шилжсэн нь өөрөө зөв гэдгийг олон улсын байгууллага дүгнэчихсэн. Манай Эрүүл мэндийн яам болон эрүүл мэндийн удирдлагыг хэрэгжүүлдэг төрийн захиргааны байгууллага ч гэсэн энийгээ дүгнэчихсэн шүү дээ. Энэ бол шилжих ёстой гэдгээ бол хэлчихсэн. Нөгөө талдаа бол илүү оновчтой боловсронгуй болгохтой холбоотой бидэнд байгаа сорилтуудыг та бүхэн их тодорхой хэлчихлээ.

Цаашдаа бол энэ Эрүүл мэндийн даатгалын сан бол цэвэр мэргэжлийн удирдлагатай байх ёстой. Энийг анх ч ярьж байсан. Гаднын байгаа туршлага нь ч тийм байсан. Гэхдээ бид бол хуулиа ингээд баталчихсан. Тэр хуулийг сайд нар нь хэрэгжүүлсэн учраас өнөөдөр сайд нарыг нь буруутгах бол биш. Энэ тогтолцоог нь ер нь ахиад саяын байдлаар оновчлох ёстой гэдэг дээр бол санал нэгдэж байх шиг байна. Тэгэхээр хууль орж ирэх юм байна гэж ойлголоо. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл харьцангуй мэргэжлийн болчихсон. Тэр үндэсний зөвлөлийн дэргэд бас мэргэжлийн холбоод ажиллаж байгаа. Мэргэжлийн хороод ажиллаж байгаа юм. Мэргэжлийн хороод нь энэ тооцооллыг нь хийгээд оруулж ирээд, тэндээс шийдвэр гаргаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зүйл рүүгээ цаашдаа явахаас өөр арга байхгүй. Тэгэхгүй жишээ нь магадгүй захиргааны байгууллагын саналыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь санал болгоод, тэрийгээ хэлэлцээд шийдвэр гаргаад явдаг байх юм бол энэ нь өөрөө бол бас ахиад л эрсдэл дагуулна гэж байгаа юм. Явцад нь бас улс төрийн шийдвэр бол гарч байсан. Энэ нийгмийн даатгалын сан дээр ч гэсэн гарч байсан, Эрүүл мэндийн даатгалын сан дээр ч гэсэн гарч байсан. Тэр гарч байсныг бол бид нар сайн мэдэж байгаа шүү дээ. Бид бол урьдчилсан сэргийлэх үзлэг гээд ерөөсөө улс орноороо компаничилсан ажил хийчихсэн. Энэ чинь бол санд маш том ачаалал өгсөн. Энийг цаашдаа бол гаргахгүй байх талаас нь хуульчлах ёстой. Уг нь бол хуульчилчихсан байгаа боловч тэр хуулийг хэрэгжүүлээгүй бол яах ёстой вэ гэдгээ цаашдаа илүү сайн бодох ёстой.

Нөгөө нэг зүйл бол энэ сан бол эрсдэлийн сан учраас энэ сангаас үйлчилгээ авах гэж байгаа хүмүүс бол эрх тэгш байх ёстой. Эрх тэгш байх ёстой гэдэг нь бага төлчхөөд, их хэмжээний үйлчилгээ аваад байгаа тэр төрөөс шимтгэлийг нь хариуцдаг нийгмийн бүлгүүд байна шүү дээ энэ асуудлыг ахиад тооцоолол хийгээд, маш тодорхой эрх тэгш байх зарчмын үүдэн дээрээс энэ шимтгэлийнх нь асуудлыг нь төр хариуцдаг юм уу, бусад хэлбэрээр ямар нэг зохицуулдаг юм уу, тэр менежментийг нь бас олох ёстой. Тэгж байж энэ бол явна. Тэгэхгүй бол энд ирээд жишээ нь зөвлөлийн гишүүд, эсвэл яамныхан эсвэл агентлагийнхан нь ирэхээр нь зэрэг тэд нар буруутай юм шиг л байнга хараад байдаг. Ямар нэгэн байдлаар нөхдүүдийн хариуцах ажил мөн боловч бүхэлдээ цаана байгаа асуудлаа бид нар шуурхай шийдэж авахгүй бол ирэх жил өдийд бид нар яг ингээд яриад сууж байна. Ирэх жил яг ийм л тайлан хэлэлцэж байна. Тэгэхээр тэрнээс урьдчилсан байдлаар шуурхай бид нар энэ хуулийг нь оруулж ирээд, тэгээд батлаад өгье. Тэр хуулийнхаа дагуу харин жишээ нь мэргэжлийнхээ удирдлагыг хэрэгжүүлээд явах зүйлээ бол та бүхэн мэд. Цаана байгаа тогтолцоогоо илүү боловсронгуй болгож, энийг ажиллуулах зохион байгуулалтаа бас хийе. Тэгээд тэрнээс гарсан үр дүнг бол бид нар ирэх жил өдийд ахиад ярьж байх ёстой. Сайн үр дүн гарах байх гэж найдаж байна. Гарах ч ёстой гэж бодож байна сайд аа. Энэ бол таны өөрийн чинь бас байнга ярьж байсан манлайлал үзүүлнэ, манлайлах ёстой гэж таны хэлж байсан зүйл учраас ийм үр дүн гарах ёстой гэсэн хүлээлттэй байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Баатархүү гишүүн үгээ хэлнэ.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ер нь эрүүл мэндийн асуудал ярихаар ажлын хариуцлагын асуудлыг би хэлэх ёстой юм байна гэж

бодлоо. Олон удаа ажиглалаа. Энэ салбарыг удирдаж байсан хүмүүс хоорондоо яг тухайн асуудлаараа дандаа өөр байр суурь илэрхийлээд байдаг. Тэгэхээр энэ бол хувь хүмүүсийн зөрчил биш, Монгол Улс эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлого, стратеги, баримтлах чиглэл гэж юм байхгүй байгаа мэт харагдаж байна л даа. Тэр чиглэлээ баталсан бол тэнд нь ямар сайд байна хамаагүй, тэр бодлогоо хэрэгжүүлээд л явах ёстой шүү дээ. Өмнөх сайд өөр юм ярина. Одоо байгаа сайд өөр юм ярина. Дараагийн сайд өөр юм ярьдаг. Сайдаас хамааралтай эрүүл мэндийн салбар болсон байна. Энэ олон удаа ажиглагдаж байгаа шүү энэ Байнгын хороон дээр. Тэгээд салбарынхан ерөөсөө хоорондоо ойлголцохгүй байна. Эрүүл мэндийн салбараар мэргэшсэн Улсын Их Хурлын гишүүн өнөө өглөө бас өөр мэдэгдэл хийгээд л явж байна. Тэгэхээр салбарынхан эхлээд дотроо ойлголцохгүй бол хоорондоо ийм ойлголтын зөрүүтэй юм оруулж ирээд, тэгээд ажил дээрээ, тэгээд Их Хурал дээрээ төсвөө батлуулж чадахгүй хэмжээнд очих эрсдэлтэй шүү гэж би бодож байна. Дараагийн зүйл боловсролынхоо тогтолцоотой бас эрүүл мэндийн салбар юмаа уялдуулах хэрэгтэй. Би яг тоо аваад үзэхэд Монгол Улсад Ерөнхий эмч нар маш их хэрэгтэй байна. Хэт нарийсчхаад байна. Тэгээд анхан шат буюу энэ өрхийн эмнэлгүүдээ чанаржуулах, тусламж, үйлчилгээг нь өргөжүүлэх, энэ чиглэлд бодлогоо илүү анхаарал хандуулах хэрэгтэй. Монголын өрхийн эрүүл мэндийн тогтолцоо бол маш өвөрмөц тогтолцоо шүү. Орон нутаг, улсын төсөв, нөхөрлөл 3 нийлж ажилладаг ийм өвөрмөц тогтолцоо байдаг.

Тэгээд дараагийн асуудал бол энэ эмийн чанарт онцгой анхаарах хэрэгтэй. Бид нар эмийн хөнгөлөлтийг тойрч яриад байна. 1 талдаа зөв, нөгөө талдаа Монгол хүн эрүүл байхын тулд урьдчилан сэргийлэх, өвдөхгүй байх, өвдсөн бол хамгийн чанартай үйлчилгээ авдаг ийм тогтолцоо руу орохгүй бол улсын эмнэлгүүд чинь өнөөдөр шинжилгээний хариу гаргах ийлдэсгүй сууж байна шүү дээ. Манайх энэ шинжилгээг хийхгүй ийлдэс дууссан. Гол гол эмнэлгүүдээр чинь. Манайх даатгалын сангаас мөнгөө авч чадахгүй хэцүү байна. Тэгээд хаана хаанаа өрийн гинжин холбоо үүсчихсэн ийм байдалтай байна. Тэгээд Эрүүл мэндийн сайд манлайлаад салбарынхантайгаа ярилцаад, Их Хурал руу 1 бодлого оруулж ир. Тэгэх юм бол Байнгын хороо дэмжээд явна. Хуулийн өөрчлөлт хийнэ гээд суугаад байх юм. Одоо өргөн бариач ээ. Иргэд хэлээд байна шүү дээ. Та нар зөв юм яриад байх юм. Наадхаа хий л дээ гээд байгаа байхгүй юу. Одоо бид нар хэрэгжүүлэх хэрэгтэй байна. 30 жил ярьж байна шүү дээ. 30 жил тойрч ярьж байна. Одоо хэрэгжүүлцгээе.

Тэгээд үнэхээр манай Байнгын хорооныхон салбарынхан бодлогоо энэ хамгийн зөв юм гэхэд дэмжихэд бэлэн байгаагаа илэрхийлье. Тэгээд амжилт хүсье. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Би бас 2, 3 юм хэлье. Ер нь ингээд гишүүдийн ярьж байгааг ч харсан, манай салбарын байж байгааг ч харсан эмч нар бол хэлж байна. Одоо бид нар эм бичихээсээ илүүтэй, мөнгө санхүү бүтээгдэхүүн бодож байна гээд. Тэр бол олон эмч хэлсэн. Тэр бол гарцаагүй тийм болчхоод байгаа. Өөрөөр хэлбэл бид нар буруу байна л гэсэн үг. Эмч хүн оношоо биш, хэдэн төгрөгийн ямар аппарат, ямар эмчилгээ, юу билээ гэж бодож эхэлж байна гэж байгаа чинь аюул байгаа юм. Тэгэхээр энэ тогтолцооны шинэчлэл бол зайлшгүй байна. Тогтолцооны шинэчлэл. Жишээлбэл түрүүн би асуусан тэр актуар тооцоо хийсэн үү гээд байгаа нь актуар тооцоо заавал хуульд заачихсан байгаа ч гэсэндээ тэрийг хийлгэх гээд байгаадаа биш, хуулийн үзэл санаа нь өөрөө энийг чинь зүгээр 1 дарга шийдэхгүй, захиргааны байгууллага шийдэхгүй. Та хэд Эрүүл мэндийн даатгалын тооцооллыг хийгээд, аль нь ашигтай, аль нь ашиггүй, алийг нь зөв бэ, явал сан зөв ажиллах вэ гэдгийг тооцоорой л гэж байгаа болохоос заавал өгсөн актуар гэсэн үг бас биш гэж бодож

байгаа. Тэгэхээр яг актуар тооцоо хэлэхэд төсөв гэж ярихаас илүүтэй цээжээр ч гэсэндээ энэ даатгал нь зөв, буруу гэж хэлэх үүрэг нь үндэсний зөвлөл та бүхэнд байгаа байхгүй юу. Тэгээд ингээд харахад бол 2021 онд хуулийн өөрчлөлтөөр нэлээн том шинэчлэл хийх нь хийчихсэн байгаад байгаа юм. Гэхдээ хэрвээ Үндэсний зөвлөл иймэрхүү байдлаар идэвх сул ажиллах юм бол ямар ч тогтолцооны шинэчлэл хийсэнтэй ялгаа байхгүй. Харин ч бараг хариуцлага нь сайдаасаа холдоод, тэгсэн хэр нь сайд нь, яам нь, захиргааныхан шийдвэрийг нь гаргадаг. Эцсийн дүндээ зөвлөл нь ингээд яг гишүүд хэлж байгаа үнэн шүү дээ. Зөвлөл нь баталгаажуулдаг. Хариуцлагыг нь тарамдуулдаг болчихоод байна. Жишээлбэл Эрүүл мэндийн даатгалын шимтгэл 4 хувь гэж байна. Энийг бол зөвлөлийнхөн бол 3,5 баймаар байгаа юм. 3,89 баймаар байгаа юм. 4,9 баймаар байгаа юм. 15 баймаар байгаа юм ч гэдэг юм уу ямар нэгэн ийм бодлого, шийдэлтэй баймаар байгаа байхгүй юу. Тэгж байж араас нь тэгвэл ингээ, ингэж өөрчилье, ингэвэл энэ хуулийг ингээ, бүтцийг ингээ гэсэн санаа төрнө. Тэгэхээр яг хамаг найдвар Үндэсний зөвлөлийн гишүүд та бүхэнд байгаа юм байна шүү. Тэгэхээр энэ дээрээ идэвх санаачилгатай ажиллаад, ялангуяа манай Байнгын хороонд яг салбарын сайд нар байсан 2, 3 ч гишүүн байна. Зөвлөлийн гишүүн байсан хүмүүс байна. Тэгээд яг гишүүдтэй ярьж байхад бид бүгдээрээ санал нэгдсэн байгаа. Эрүүл мэндийн даатгалын сангийн менежмент, үр ашгийг дээшлүүлэхгүйгээр эрүүл мэндийн салбарын шинэчлэл байхгүй, ийм юм байхгүй, эмч байхгүй, цалин байхгүй. Тэгэхээр энэ бол хамгийн чухал асуудал гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ дээр зөвлөлийн гишүүд маань өөрсдийнхөө яг үүргийг хуулиар заасан үүрэг болон олноос ингээд итгэл найдварыг бодож байгаад арай өөрөөр ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд байнгын хороотойгоо илүү ойрхон ажиллаад зөвхөн жилд 1 тайлан тавьдаг биш, одоо ажиллаж байгаа тогтолцоог шинэчлэхийн төлөө та бүхнийг оруулсан гэж ойлгоод байгаа. Яг тэр тогтолцооныхоо нэг эд эс нь болчихсон, зүгээр тайлан хамгаалагч нар болчихоод суухыг бид нар харахыг хүсэхгүй байна. Тэгэхээр энэ дээр байнгын хороотойгоо хамтарч ажиллаарай гэж хүсэж байна.

Чинбүрэн сайд бас түрүүн тэр 8 зүйлээ яах вэ, нөгөө яг өргөн барьж, бид нарт ирээгүй байна лээ. Сая явуулчихсан байх. Тэрийг бол бид нар үнэхээр сайн ажиллаад, дээр нь баяжуулаад, яг бодитой тогтолцооны маягийг нь ул суурьтай шинэчлэл болгомоор байна. Жишээлбэл танилцаагүй болохоор хэлж чадахгүй байна. Гэхдээ Эрүүл мэндийн даатгалын сан руу баялгийн сангаас мөнгө өгөх тухай энэ бол байж болох байхгүй юу. Ер нь эмчийн цалин ч байна уу, багшийн цалин ч байна уу яг Монгол Улс шийдье гэсэн юмаа эртхэн бодлогоороо баталчихмаар байгаа юм. Багш нарын цалинг, эмч, ажилтны цалинг нэмнэ гэсэн бол нэмнэ. Мөнгө бол олдоно. Мөнгийг хаанаас ч олж чадна. Ганцхан тэр нь жишээлбэл, Эрүүл мэндийн даатгалын сангаа шинэчлээд нөгөө таны түрүүний ярьдаг шүүр шанагаа нөхөхгүй бол харин ч бүр аюул болоод явчих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр Байнгын хорооны гишүүн бид нар бас албан болон албан бусаар ярилцсан байгаа. Эрүүл мэндийн даатгалын сангийн шинэчлэлийг улс төрийн хувьд манлайлан ажиллахад бэлэн байгаа. Тэр нам харгалзахгүйгээр, энэ дээр маш шуурхай ажиллахад бэлэн байгаа шүү. Та бүхэн маань харин ойрхон ажиллаад, мэдээллээ сайн өгөөд, шийдлээ оруулаад ирээрэй.

Эцэст нь түрүүн би асуусан шүү дээ. Азийн хөгжлийн банкны тайлан байгаа. Тэр тайлан хаана байгаа вэ. Тэрийг би тодруулж асууя гэсэн мартчихаж. Тэрийг бид нар луу явуулаадхаарай. Баярлалаа.

Гишүүд үг хэлж дууслаа. 2024 оны Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа.

17.32 цаг.

Дараагийн асуудал.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2-т Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, гишүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно гэсэн байгаа. Тэгэхээр манай байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд энэ асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудад танилцуулъя. П.Наранбаяр Боловсролын сайд, Л.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Даваацэрэн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ц.Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Б.Төгөлдөр Эдийн засаг хөгжлийн яамны Хөгжлийн төсөөлөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, П.Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Өлзийсайхан Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч. Сангийн яамнаас М.Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, С.Тулга Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Ц.Мөнхзул Гэр бүлийн бодлогын газрын дарга, Ю.Отгонбилэг Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Д.Жаргалсайхан Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Г.Батдорж Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, В.Батчимэг Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, А.Амгаланзаяа Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга. Эрүүл мэндийн яамнаас Д.Отгонбаатар Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга, Б.Туяа Стратеги төлөвлөлтийн газрын даргын ажлыг түр орлон гүйцэтгэгч, Д.Баярболд Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын даргын ажлыг түр орлон гүйцэтгэгч, Ш.Энхтуяа Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтсийн дарга, С.Жаргалсайхан Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Анхан болон лавлагаа, шаталтын тусламжийн хэлтсийн дарга, Н.Хүрэлбаатар Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Л.Мөнхцэцэг Санхүү, даатгалын хэлтсийн дарга, Я.Болормаа Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах шинжээч. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас М.Нармандах Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Г.Ариунсайхан Нэхэмжлэлийн хяналтын газрын дарга, Ч.Гантөмөр Санхүү, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Б.Батхуяг Бодлого төлөвлөлтийн газрын төсвийн мэргэжилтэн. Эдгээр албан тушаалтанд хүрэлцэн ирсэн байна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой гишүүд асуулт асууж болно. Асуулт асуух гишүүд байна уу. 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Асуулт асуух гишүүн байхгүй байна. Асуулт асуух гишүүд одоо оруулаад үз дээ. Техник талаас нь шалгана уу. 3 гишүүн байна. Бейсен гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Байнгын хорооны гишүүд түрүүн Өргөдлийн байнгын хороо дээр асуусан. Манай төсвийн хүрээний мэдэгдэл дээр 2026 оны үйл ажиллагааны хөтөлбөр дээр төсвийн урсгал зардлыг 24 болгож бууруулна гэдэг ийм заалт байгаа. Нөгөө талд нь цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмнэ гэдэг заалт байгаа. Бүр боловсролын салбарын ажилчдын цалинг тэргүүн ээлжид авч үзнэ гэдэг заалт байгаа. Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлнэ гэсэн заалт байгаа. Тэгэнгүүт ганцхан төсвийн 24 хувийн урсгал зардлыг барина гэсэн заалтыг нь барьж орж ирээд, ямар ч урсгал зардал нэмэх боломжгүй. Цалин боломжгүй, тэтгэвэр боломжгүй, тэтгэмж боломжгүй гэдэг иймэрхүү юугаар, тэтгэвэр бол 6 хувь гэдэг байдлаар оруулж ирсэн. Нийгмийн даатгалын хуульдаа өмнөх оны инфляцын түвшнээс доошгүй гэдэг ийм заалт байгаа. Одоогийн байдлаар инфляц 8,8 хувьтай байна. Тийм учраас хуулийн тодорхой шаардлагыг дордуулаад оруулж ирж байна.

2 дугаарт төсвийн урсгал зардлын дээд хэмжээ 30 хувь бол байгаа. Хуулиар байгаа. Тэгэхдээ үйл ажиллагааны төлөвлөгөөний 1 заалтыг барьж орж ирээд, Засгийн газар нь өөрөө ч гэсэн цалин хөлс нэммээр байна. Даанч 24 хувийн хөгжлийн заалт байгаад байгаа гэдэг юм яриад байх юм. Тэгээд энийгээ та бүгд маань жилийн ажлын хөгжлийн төлөвлөгөө дээр байж байгаа олон заалтуудаасаа ганцхан заалтыг нь чухамхүү дагаж мөрдөнө гээд л барьж орж ирээд байгаа чинь ерөөсөө ойлгохгүй байгаад байна. Тийм учраас энийгээ та бүгд маань болиоч ээ.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг ойлгож байна. Ийм л үнэлэлт дүгнэлт өгөх байх. Тийм учраас хэрвээ та бүгд маань өөрсдөө энийгээ өөрчлөх байдлаар зарчмын хувьд оруулж ирэхгүй бол зарчмын зөрүүтэй саналыг оруулах шаардлагатай болж байна. Түрүүн Өргөдлийн байнгын хороон дээр бас яригдсан. Тийм учраас энэ тал дээрээ та бүгд маань яг нэг байр сууриа хэлээч. Сангийн яам. Тэр бусад заалтуудыг нь орхичоод, ганцхан тэр төсвийн хүрээний мэдэгдэл дээр ирэх жил, тэрний дараагийн 2 жил бас яг энийгээ барих юм байна. Тэгэхээр нөгөө талд нь болохоор иргэд цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжээ нэмүүлнэ. Жил болгон инфляцын түвшинтэй уялдуулж нэмнэ гэдэг заалтууд байгаа. Тийм учраас нэг төлөвлөгөө дээр байгаа 3, 4 хоорондоо уялдаа холбоотой заалтыг 1-ийг нь сугалж авч үзэнгүүтээ оруулж ирж байгаа чинь одоо манай Байнгын хороогоор бол үндсэндээ хүмүүс юу харж байна вэ гэхээр цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж яах гэж байна вэ гэдгийг л 1 номерт харна.

Сая эрүүл мэндийн салбар дээр гэхэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ дээр ямар ч мөнгө нэмж тавиагүй байна шүү дээ. Тэгэхээр ийм мухардал руу аваачаад ингээд тавьчихаар ерөөсөө манай Байнгын хороо юм ярихаар ихэнх гишүүд асуух байх. Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нөгөө төрийн албан хаагчийн тэтгэмжээ хүртэл талыг нь аваачаад тастаад тавьчихсан. Тэгэхээр ийм боломжийг гаргаж ирэх боломж байна уу та хэд өөрсдөө. Нөгөө талаар энийг заавал энэ 24 хувийг барихгүй байвал яах юм.

Б.Найдалаа: Сангийн яамнаас хариулах уу. Энэ 24 хувийг та бүхэн асуултыг нь ойлгосон уу. Сангийн яамнаас микрофон хэд вэ. 8. Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Цалин нэмэх, нэмэхгүйтэй холбоотой асуудал бол ерөнхийдөө бүх хуулийн хүрээнүүддээ бол бас хязгаарлагдаж байгаа асуудал бий. Энэ 24 хувьдаа бас хязгаарлагдаж байгаа. Мөн нийт зарлагадаа хязгаарлагдаж байгаа асуудал байгаа. Гэхдээ том зургаараа харах юм бол энэ бас орлоготойгоо Монгол Улсын төсөв бол уягдаж явдаг. Нөгөө хөнжлийнхөө хэрээр гэдэг шиг хэр хэмжээний орлого олж байна гэдгээр, өөрөөр хэлбэл манай мөрдөж байгаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар бол суурь зарлага буюу дотоод эдийн засгаасаа олж байгаа татварын болон татварын бус орлого маань өөрөө 2 хувийн ашигтай байгаад, энэ ашгаараа бид нар зээлээ, үндсэн төлбөрөө төлөх ийм хуулийн заалттай байгаад байдаг. Тэгэхээр ирэх жилийн хувьд бидний хувьд олж болох орлого маань болбол 31,6 их наяд төгрөг байна гэж үзсэн байгаа. Тэгэхээр энэ орлогодоо болбол 2 хувийн ашгаа хийгээд тооцохоор одоогийн энэ зарлага гарч ирчхээд байгаа. Суурь зарлага маань. Тэгэхээр энэ дүндээ л бид нар энэ асуудлыг бол шийдэхээс өөр аргагүй болчхож байна гэсэн үг. Тэгэхээр цалин нэмэх асуудал байхын тулд бид нар 1 дүгээрт бол эдийн засгийн боломжоо харж тооцох хэрэгтэй болов уу гэж бодож байна.

Ер нь яах вэ зүгээр өмнөх Байнгын хороо дээр бас цалин нэмэхтэй холбоотой асуудлыг инфляц талаас нь бол бас нэлээн бодлого талаас нь тайлбарласан. Гишүүд ч асууж байсан. Монголбанкныхны хийсэн судалгаагаар бол нийтдээ 1,4 сая иргэд ажил хөдөлмөр эрхэлж байгаагаас бол яг төсвөөс цалин хөлс авч байгаа нь бол 220 гаруй мянган хүн байна. Төрийн өмчит компаниудаас бол 50-аад мянга байна. Тэгэхдээ энэ 220 мянган хүний цалинг хэрвээ бид нар зардал өндөр байх үед нэмэгдүүлсэн тохиолдолд бол 10 хувиар нэмэхэд инфляцад 4,4 хувиар бол нөлөөлж байна гэдэг ийм судалгааг Монголбанк хийсэн байна лээ. Тэгэхээр зардлаа бууруулж байгаад өөрөөр хэлбэл бид нар зохистой түвшинд хүрч байгаад, тэгэхдээ нэмэхдээ бол бас огцом байдлаар нэмэхгүйгээр ингэж нэмж явах нь бол зүйтэй юм байна гэдэг ийм зүйл бол харагдаж байна лээ. Тэр судалгаагаар. Баярлалаа.

Б.Найдалаа: Эрдэнэбат гишүүн хариулт болсон уу. Тодруулах уу. Тодруулж асууя.

С.Эрдэнэбат: Тэгэхээр та хэд маань соёлтой аргаар л үгүй гээд байна л даа. Эсвэл тэр хүмүүстээ чадахгүй гэдгээ л хэлчих хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүй бол зарим амаараа болохоор уг нь нэммээр байна. Тэгэхдээ төсвийн хайчин галд байна. 24 хувь гээд заачихсан юм гэдэг байдлаа яриад байгаа юм. Нөгөө талаар эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн энэ мөнгө чинь яг үнэндээ урсгал зардал, төсвийн урсгал зардалд бол орохгүй байхгүй юу. Тусдаа даатгалын сан ер нь бол. Харин тэр өөрөө хариуцаж байгаа хэсгийнхээ, татаас өгч байгаа хэсгийгээ тэр урсгал зардалдаа оруулж явах ёстой. Та хэд яг өнөөдөр бол нийгмийн даатгалын бүх тэтгэврийг төсвөөс мөнгө гаргаад өгч байгаа юм байхгүй шүү дээ. Энийг чинь Монгол Улсын нийт даатгал төлж байгаа хүмүүс маань мөнгөө өгөөд, эв санааны нэгдлийн зарчмаараа тэндээс аваад явж байгаа. Тийм учраас нэг ийм тоо тавьчаад, тэгээд ийм юм хэлээд байна л даа.

Б.Найдалаа: Саяын тэгэхдээ цалин нэмэхтэй холбоотой асуудал араас нь дараагийн асуудал дээр жинхэнэ төсөв хэлэлцэхээр орох байх. Энэ бол төсвийн хүрээний мэдэгдэл болохоор гишүүд бас анхаараарай. Баатархүү гишүүн асуулт асууна. Баатархүү гишүүн асуултаа татлаа. Бейсен гишүүн алга байна.

Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо дэгээрээ зарчмын зөрүүтэй саналуудаар танилцаж, санал хураах байгаа.

Дэгийн дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. 2 зүйлтэй хууль байгаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байгаа юу. Энд ирүүлчихсэн байгаа. Эрдэнэбат гишүүн болон Мөнхтуяа гишүүн нараас зарчмын зөрүүтэй санал энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гаргасан байгаа.

Би төслийг танилцуулъя. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

Зарчмын зөрүүтэй санал гаргасан Мөнхтуяа гишүүн. Энэ хуулийн 1.3-д байгаа Засгийн газрын өрийн нийт хэмжээг 51 их наяд 200 тэрбум байгааг 51 их наяд 690 тэрбум болгож өөрчлөх. Дараагийнх нь 2.1 дүгээр зүйл дээр байгаа нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 31 их наяд 600 тэрбум байгааг 32 их наяд 90 тэрбум болгох. Дараагийнх нь 2.2 дээр байгаа нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 32 их наяд 980 тэрбум байгааг 33 их наяд 470 тэрбум болгож өөрчлөх. 2.4 дүгээр зүйл дээр байгаа нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээг 29 их наяд 552 тэрбум байгааг 30 их наяд 42 тэрбум болгож өөрчлөх ийм санал гаргасан байна. Дэгийн дагуу санал гаргасан гишүүн тайлбар хийдэг. Бусад гишүүд асууж, үг хэлдэггүй. Мөнхзаяа гишүүний микрофоныг нээе. Энэ саналаа тайлбарлана уу та.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Жавхлан сайд байхгүй байгаа юм байна. Уг нь сайд нь байвал уг нь зүгээр байх юм.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 4 сарын 2-ны өдрийн 158 дугаар тогтоолоор 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарласан. Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 5 сарын 29-ний өдөр батлан гаргасан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн 2 дугаар зүйлийн Хүний хөгжлийн бодлогын 2.1.18-д багш, ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг тэргүүн ээлжид сайжруулна гэж заасан байгаа ч Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2026 оны Төсвийн тухай хуулийн төсөлд боловсролын салбарын багш, ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр төсөв хөрөнгө маш хангалтгүй туссан байгаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах үндэслэл болж байна. Тэгээд энд нөгөө сая Найдалаа дарга уншчихсан байгаа. 6.1.1-д нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх, Засгийн газар хуулийн төслийг өргөн барихдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2026 оны зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8341 ам.доллар нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 133,7 ам.доллар байхаар тооцсоноо дурдсан байна. Ер нь бол ингээд мөнгө байхгүй гэдэг үгээр бид нарын ам таглаад ингээд сурчихжээ. Тэгэхээр энэ дээр бид нар бас энэ болохгүй байгаа юмыг нь засаж бас болно шүү дээ Их Хурлын гишүүд санаачилга гаргаад. Тэгээд энэ Өргөдлийн байнгын хороон дээр ч ярьсан. Энэ удаагийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр ч яригдаж байна. Тэгэхээр энэ 2 Байнгын хорооны гишүүд нийлээд, миний энэ зарчмын зөрүүтэй саналуудыг дэмжээд өгөх юм бол багш, эмч, ахмадын тэтгэврийг нэмэх ийм боломж гарц байна гэдгийг би энэ

саналдаа тусгасан юм. Тэгээд та бүхэн бас үүнтэй танилцаж болно. Би бас хэвлээд өгч болно гэж энэ Байнгын хорооныхоо гишүүдэд хэлмээр байна. Тэгээд миний асуултад хэн хариулах вэ. Сангийн сайд нь байхгүй байна шүү дээ.

Б.Найдалаа: Баярлалаа. Дэгийн дагуу холбогдох яам, мэргэжлийн байгууллагаас хариулах ёстой. Микрофон 4. Нэрээ хэлээд хариулаарай.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Гишүүний асуултад хариулъя. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр үндсэн оруулж ирж байгаа 9 макро тоон дотор бол урсгал зардлын хувь хэмжээ бол байхгүй. Гэхдээ өнгөрсөн онд батлагдсан 2026 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр бол 24 хувь гээд заачихсан байгаа. 24 хувь гэдэг маань одоогийн тооцооллоор төсвийн төсөл дээр 24,6 их наяд орчим төгрөг болж байгаа. Яг яригдаад байгаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг зарлагыг нь аливаа хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр, зарлагын хязгаар дотор нь зохицуулж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Зардлыг нэмэгдүүлэхийн тулд бас саяын гаргаж байгаа санал бол орлогоо нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна. Өнгөрсөн оны сүүлээс эхлээд гадаад, дотоод нөхцөл байдал бол муудсан. Өнгөрсөн хугацаанд хаврын чуулган саяын энэ чуулганы эхнээс эхлээд энэ асуудлаар олон гишүүн холбогдох мэргэжлийн байгууллагууд бол энэ санал дүгнэлтээ хэлсэн. Дөнгөж өчигдөр зарласан Азийн хөгжлийн банкны Монгол Улсын эдийн засгийн төсөөлөл дээр ч гэсэн энэ оны төсвийн төсөөллийг 0,3 нэгжээр эдийн засгийн өсөлтийг бас бууруулж тооцсон байна лээ. Тэгэхээр бидний хувьд бол энэ төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцохтой холбоотой макро төсөөллийг ямар нэгэн байдлаар шууд нэмэгдүүлэх боломжгүй гэж үзэж байгаа. Зардлыг нэмэгдүүлэх нь бас төсвийн хүрээний мэдэгдэл дээр заасан тэнцлийн эерэг байх гэсэн зарчмыг бас алдагдуулахаар байгаа. Жишээлбэл сая Сангийн яамнаас тайлбарласан төсвийн суурь тэнцэл бол орлого, зарлага дээрээ бол үндсэн эдийн засаг дотроосоо олж байгаа орлогын бодит орлогын хэмжээ, зарцуулах зарлагын дээд хязгаараар нь тааруулаад 2 хувийн ашигтай байхаар тулгачихсан байгаа. Хэрвээ зардлын өсөлт нь үүнээсээ зөрөх юм бол 2 хувийн ашигтай байна гэдэг маань өөрөө бас зөрчигдөнө. Төсвийн тусгай шаардлага бас зөрчигдөх эрсдэлтэй байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: Орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээ хоёулаа буурч байгаа учраас энэ нөгөө төсвийн хуулийг бол зөрчихгүй. Яг хууль дотроо яваад байгаа байхгүй юу. 24 хувь гэж байгаа учраас бид нар энийг 30 руу оруулах боломж байгаа шүү дээ. Тэгэхээр тэр 30 дотор 6 хувь байгаа шүү дээ. 6 их наяд гэсэн тооцоо. Тэгэхээр эндээс 1 их наяд төгрөгийг тэтгэвэр, цалин юмнууддаа оруулах боломж байгаа гэж хараад байгаа байхгүй юу. Энд ерөөсөө хууль зөрчсөн юм байхгүй. Тэгээд үнэхээр бүр болохгүй юм бол юу өр зээлээ тавиа. Азийн хөгжлийн банкнаас 150 сая долларын өр зээл тавиад, баахан барилга барина гэж яриад байгаа шүү дээ. Тэгвэл өр зээлээ тавиад, энэ багш нарынхаа цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжээ нэм л дээ. Заавал болохгүйг нь барьж аваад байх юм. Өрөө тавиад, зөндөө их байшин барилга, зам гүүр бариад байгаа юм чинь одоо өр тавьж, эмч, багш, ахмадууд чинь гадаа жагсаад байгааг хараад байгаа биз дээ та нар.

Б.Найдалаа: Саяынх дээр нэмж илүү тодруулж өгөх мэдээлэл, тоо, хариулт байгаа юу. Байгаа юу, байхгүй байж болно. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асууя. Хэн байгаа билээ. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2 дугаар микрофон нэрээ хэлээрэй.

Н.Ууганбаатар: Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн. Одоо орж ирсэн байгаа төсвийн орлого болон зарлагатай холбоотой дүн бол бид нарын хаврын өгч байсан төсөөллөөс аль аль нь бол жоохон буурсан байгаа юм. Бид нар бол хавар орлогыг бол 33 орчим их наяд байх болов уу гэсэн ийм төсөөлөлтэй байсан. Тэнцвэржүүлсэн орлогыг. Одоо бол хавар мөн бид нарын баталсан төсвийн хүрээний мэдэгдэл дээр бас 33,4-өөр батлагдсан байгаа. Одоо бол 31,6 болчихоод байгаа. Тэгээд үндсэн шалтгаан нь бол эдийн засгийн түүхий эдийн зах зээл дээр болж байгаа циклийн асуудал байгаа. Тэгэхээр 31,6-аас дээш нь өсөх бол жоохон хэцүү болов уу л гэж бодож байна. Энэ төсөвлөсөн орлогыг. Тэгээд орлого нь өсөхгүй болохоор зарлагаа нэмчихээр дахиад л нөгөө тэнцлийн дүрэм дээр очоод зөрчил үүснэ л дээ яалт ч үгүй.

Б.Найдалаа: Баярлалаа. Мөнхтуяа гишүүн тодруулах юм уу. Дахиад 1 тодруулж асууж болно.

Ц.Мөнхтуяа: Энэ нөгөө өмнө нь төсөөлсөн байсан 31,6 гэж яриад байна. Энэ дээр чинь бид нар 490 тэрбум төгрөг л нэмж байгаа шүү дээ. Ер нь бол 490 тэрбум төгрөгөө нэмээд, энэ орлого, зарлага 2 чинь ерөөсөө их айхтар хол зөрөөд байх юм байхгүй гаргаж байгаа юм. Энийг чинь эдийн засагчдаар тооцоо судалгааг нь гаргуулж байж бид нар ярьж байгаа шүү дээ. Тэрнээс би дураараа зохиогоод тоо яриад байгаа юм ерөөсөө байхгүй. Тэгэхээр энэ Сангийн яамныхан энэ дээрээ дахиад хараад, хянаад өгөх боломж ер нь байна уу. Тэгээд одоо энэ тэтгэвэр, цалинг нэмэгдэхийг хүлээсэн хүмүүс чинь гадаа ингээд энэ өвөлжин жагсах юм уу. Хүнээ бодохгүй та нар өөр юманд болохоор мөнгө зарцуулаад байдаг байж, хүн рүү чиглэсэн яг цалин хөлстэй холбоотой юм дээр болохоор болохгүй гэдэг үгээр ингэж мянган үгний таглаа болгож битгий хаагаад байгаач л гэж би хүсээд байгаа юм. Болгоё гэвэл болно шүү дээ энийг чинь. Өр зээл тавих болохоороо та нар өр зээл өчнөөн тэрбум, их наядаар/минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа тайлбар тодруулга болсон. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс сая Сангийн яамных шиг юм ярих нь жоохон зохимжгүй байна. Энэ чинь хуультай. Улс төрийн асуудал биш. Зүгээр яг энэ зарчмын зөрүүтэй санал яг төсвийн хуулийн тусгай шаардлагуудыг хангаж байна уу, хангаагүй байна уу, болох юм уу, болохгүй юм уу гэдгийг тодорхой хөндлөнгөөс хэлчихмээр байна. Энэ дээр тодорхой хэлэх юм байна уу. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Хэд вэ 2 номер. Тийм, үгүй л гэж хэлэх хэрэгтэй байна.

Н.Ууганбаатар: Тийм ээ, Найдалаа дарга аа, бид нар албан ёсоор нөгөө энийг огт хэлэлцээгүй шууд шинээр орж ирж байгаа асуудал учраас одоо шууд дүгнэлт гаргах бол боломжгүй байна. Бид яах ёстой яах вэ гэхээр энэ зарчмын зөрүүтэй гарсан бүх саналууд дээр Их Хурлын чуулган дээр угаасаа дүгнэлтээ танилцуулах үүрэгтэй.

Б.Найдалаа: Ойлголоо. Ямар ч байсан асуулт, хариулт, тодруулга, нэмэлт тайлбар дууссан. Одоо дэгийнхээ дагуу саяын Мөнхтуяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжих эсэх дээр санал хураалт явах ёстой. Гишүүд санал хураалтад бэлдье. Хуруугаа уншуулаарай. Зүгээр энэ хооронд хэлэхэд Мөнхтуяа гишүүний цалин нэмэхийг зөвхөн багш нарынх биш, эмч нарын цалин нэмэхийг манай Байнгын хорооны гишүүд бүгд дэмжиж байгаа. Гэхдээ яг нэмэх арга нь төсвөөр тоглож нэмэх биш, цаана нь бодлого байх ёстой. Агуулга байх ёстой. Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам гэхээсээ илүү энэ салбарын яамд нь хариуцах ёстой шүү. Бид нар салбарын яамтай нь ажиллая гэж бодож байгаа.

Тэгээд энэ дээр бид нар тодорхой ярьсан зүйл ч байгаа. Ингээд тусгай ажиллана. Тийм болохоор энэ бол яг төсвийн хүрээний мэдэгдэлтэй зууралддаг, яг үүгээр шийддэг асуудал биш гэсэн бодолтой байгаа. Тэгээд санал хураалтад бэлэн үү. Мөнхтуяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. Байж байгаарай. Санал хураалтдаа бэлдье эхлээд. Одоохон дахиад хэлье. Яг нөгөө түрүүн би тоо уншсан шүү дээ. Тэр тоог дахиж уншихгүй бол болох уу.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төслийн талаарх Мөнхтуяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураана. Мөнхтуяа гишүүний гаргасан саналыг дэмжье. Саяын тэр том том их наяд гэсэн тоонуудыг нэмж, хасах тухай санал шүү дээ. Та бүхэнд бас байгаа. Тоог нь харж байна уу. Санал хураалтдаа бэлдье. Хуруугаа уншуулаад. Бэлэн бол санал хураалт. Энийг техник талаасаа шалгая. Дахиад эхэлье. Гишүүд хуруугаа уншуулсан уу. Техник өнөөдөр жоохон гацаатай л байна даа. Уншихгүй байна уу. Техникийн алба шалгаарай. Санал хураалтад бэлэн болъё. Тэгэхдээ энийг жич хэдүүлээ өөр шийдлээр шийдэх ёстой гэж бодож байна. Одоо хуруугаа хийгээд үз дээ гишүүд ээ. Санал хураалтад бэлдье. Одоо болж байх шиг байна. Санал хураалтдаа бэлдээрэй. Жижигхэн техникийн асуудал гарлаа. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтдаа бэлдье. Бэлэн үү.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төсөлд зарчмын зөрүүтэй санал гаргасан Мөнхтуяа гишүүний саналыг түрүүн би уншсан, гишүүдэд танилцуулсан байгаа. Дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 11 гишүүн буюу 47,8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Дараагийн зарчмын зөрүүтэй санал Эрдэнэбат гишүүнээс гаргасан байгаа. Эрдэнэбат гишүүн зарчмын зөрүүтэй саналаа өөрөө тайлбарлана. Эрдэнэбат гишүүний микрофон өгье.

С.Эрдэнэбат: Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл оруулж ирэхдээ манай энэ төсөл дээр бас асуудал байна. Урсгал зардал гэдгийг оруулж ирээгүй мөртөө нийгмийн халамжийн зардал гээд ингээд ороод ирчихсэн. Тэгээд энэ дээр санал өгөх гэхээр үндсэндээ урсгал зардал гэдэг зардал байхгүй учраас миний оруулах гэж байгаа саналыг боломжгүй гэж юм яриад байна л даа. Тэр бүтцийнх нь хувьд та хэд урсгал зардал дотор чинь энэ нийгмийн халамж чинь бүгд орно шүү дээ. Ганцхан халамжийн зардал гэдэг юмыг халти оруулж ирсэн. Тийм учраас би санал хураалгахаас өмнө энэ төсөл оруулж ирж байгаа хүмүүс энэ оруулж ирж байгаа хуулийнхаа бүтэц дотор урсгал зардал гэдэг багана нэмээд, тэгээд би тэр дээр чинь санал хураалгах гээд байна л даа. 24,1 хувь гэж байгаа гээд байгаа шүү дээ. Тийм үү. Одоогийн өргөн мэдүүлснээр. Гэтэл Төсвийн хууль дотор бол 30 хүртэл хувь урсгал зардлын дээд хязгаар байна гээд хууль нь байгаа. Бид нар юун дээр тээглэгдчихээд байна вэ гэхээр жилийн ажлын төлөвлөгөө дээр 24 хувьд ерөнхийдөө барина. Түүнд зорино гэхчихсэн юмаа оруулж ирчхэнгүүтээ хатуу хууль мэтээр оруулж ирээд байгаа. Тийм учраас сая бол Мөнхтуяа гишүүн бол арга ядаад л орлого нэмж үзэх гэж байна шүү дээ. Тэгэхээр хэдүүлээ ийм аргаар биш, тэр төсвийнхөө урсгал зардал гэж байгаа 24 хувиа дээш нь нэмье. 24.1 болгож болсон юм бол яагаад тэгвэл 25, 26 болгож болохгүй байгаа юм бэ. Тэгэхээр ийм байдлаар энэ санал хураах боломж олгооч ээ. Тэгэхгүй бол энэ дээр 1 хүснэгт тавьчихаад, сая санал оруулах гэсэн чинь урсгал зардал гэдэг багана байхгүй учраас таны саналыг хураахад болохгүй байна гээд ийм юм яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр Сангийн яам болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс оруулж ирж байгаа хуулийн

төсөл дээрээ урсгал зардал гэдэг баганаа нэмээд тавьчхаач ээ. Тэгээд Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн дээд хэмжээ гээд тавьчихсан байгаа байхгүй юу. 1 зардлыг нь сугалаад авч ирээд. Тийм учраас энэ төсөв өөрөө ойлгомжтой байх үүднээс урсгал зардал гэдэг баганыг тэр нийтдээ хэд байгаа билээ тэр мөнгөн дүнг нь тавиад, тэр төсөвт эзлэх хувь 24 гэдэг хувийг нь миний хувьд тэр төсвийн 30 хувь хүртэл байгаа учраас одоо байгаа дараагийн орж ирэх гэж байгаа, гишүүдийн асуух гэж байгаа санал тавих гэж байгаа зүйл бүгд үүнтэй холбоотой. Төсөв дотроо зардал хэмнэх боломж бол байхгүй. Тийм учраас тийм санал хураах боломжийг эхний ээлжид та бүгдээс тодруулж асуучхаад тэгээд саналаа хэлье.

Б.Найдалаа: Эрдэнэбат гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал хуулийн хүрээнд боломжтой эсэх талаар Сангийн яам болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс товчхон тодорхой хариу өгнө үү. Сангийн яам микрофон 4.

И.Батхүү: Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд зүйл дээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл гээд 9 үзүүлэлтийг нь заагаад өгчихсөн байгаа. Тэгэхээр хуульд заасан үзүүлэлтийг нэмж, хасах гэдэг дээр тайлбар, санал хэлэх боломжгүй байгаад байна.

Б.Найдалаа: Тэгэхээр хэрвээ яг тодорхой хуулийн заалт зөрчиж байгаа бол бид нар энд санал хурааж болохгүй. Тэгэхээр Эрдэнэбат гишүүн ойлгомжтой байх. Нэмж тодруулж хэлэх юм уу, эсвэл саналаа татаж авах юм уу. Эрдэнэбат гишүүн тодруулж үг хэлнэ.

С.Эрдэнэбат: Үгүй ээ, тэгээд та хэд оруулж ирж байгаа төсвийг хэлэхээрээ жилийн ажлын төлөвлөгөөнд байгаа 24 хувь гэдэг энэ шаардлагадаа нийцүүлж бид нар оруулж ирсэн гээд хэлээд байгаа юм. Тэгэхээр тэрийг чинь би өөрчлөх гээд байна шүү дээ. Хуульдаа байгаа дээд боломжоо ашигла. Тэгэхээр гишүүдийн санал бол маш ойлгомжтой буюу урсгал зардлаа заавал огцом бууруулж тэгээд өөрсдөө нэмэх боломжгүй гэдэг ийм саналыг нэг талаараа хэлээд байгааг чинь бид нар Нийгмийн бодлогын байнгын хороо 24 биш 25, 26 хувь болгож байгаад ядаж цалин, тэтгэвэр дээрээ нэмэх орон зай үүсгэе гээд байгаа юм. Тэгэнгүүт дотооддоо хэмнэ гээд тэр Эдийн засаг, хөгжлийн хүн яриад байна л даа. Дотооддоо гүйлгэ гээд. Тэгээд дотооддоо ямар гүйлгэх боломж байгаа юм гэхээр тэрийг хэлэхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр үндсэндээ бол бид нарын бүх саналууд үүний дараа ямар ч нэмэр байхгүй. Энэ 24 хувийн төсвийн хүрээнийхээ шаардлагыг үндсэн гол концепц нь ерөөсөө л 24 хувийн төлөвлөгөө байгаа учраас л гээд байгаа шүү дээ.

Б.Найдалаа: Баярлалаа. Тэгэхээр Эрдэнэбат гишүүний гаргасан саналын агуулгын талаар бол бид нар Төсвийн тухай хууль дараагийн асуудал дээр хэлэлцээд явна. Ямар ч байсан энэ бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тодорхой заалт зөрчиж байгаа учраас зөрүүтэй байгаа учраас бид нар санал хураах боломжгүй байна.

Дэгийн дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж байгаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа гишүүн байгаа юу. Алга байна.

Тэгэхээр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд манай байнгын хорооноос танилцуулах ёстой байгаа. Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг би уншъя.

18.14 цаг.

Дараагийн асуудал.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-д төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр Төсвийн болон бусад Байнгын хороо төсвийн төсөлтэй танилцаж, хуралдаанаар хэлэлцэнэ гэж заасан байгаа. Үүний дагуу манай Байнгын хорооны хамаарах асуудлаар хэлэлцэнэ.

Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудад танилцуулъя. Хэлэлцэж байгаа асуудал ойролцоо, яг хариуцаж байгаа албан тушаалд ижилхэн учраас энд байлцаж байгаа ажлын хэсгийн албан тушаалтанд яг хэвээрээ байгаа.

Гишүүдээс хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асуух нэрсээ өгье. Ганхүлэг гишүүнээр тасалъя. Баасанжаргал гишүүн асуултаа асууна.

Х.Баасанжаргал: Төсөв дээр боловсролоос асуух гэсэн юм. Энэ төсөв дээр 10 дугаар хуудсан дээр мэдээллийн технологийн үйлчилгээ 2025 онд 447 тэрбум байж байгаад 2026 онд 18,2 гээд хувь нь 3900 хувиар энэ зардал өссөн байна. Мэдээллийн технологийн үйлчилгээний зардал. Өсөлтийн хувь нь 3979,6 хувь гээд. Энэ яг ямар зардал ингэж өсөж байгаа юм бэ. Ямар учиртай зардал вэ. Үүний цаана ямар утга учир, ямар үр ашиг, ямар үр дүнг харж байгаа вэ гэдэг асуулт.

2 дугаарт энэ насан туршийн боловсролын гүйцэтгэл үр дүнгээр олгох санхүүжилт буурчээ. Үүний бас учир шалтгааныг хэлж өгөөч.

3 дугаарт энэ мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтыг дэмжих сан гэж байдаг юм байна. Энэ сангийн бас хөрөнгө 4,1 тэрбум гэх юм уу өссөн байна. Тэгээд яг энэ мэргэжил болон техникийн боловсрол сургалтыг дэмжих сангийн зориулалт юу байдаг вэ гэсэн ийм асуултууд байна.

Тэгээд түүнээс гадна нийтдээ Боловсролын сайд дээр нийтдээ 5 судалгааны хүрээлэн байна. Монгол судлалын хүрээлэн, Эдийн засгийн хүрээлэн, Соёл урлаг судлалын хүрээлэн, Хүнсний эрдэм шинжилгээ судалгааны хүрээлэн, Хот бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэн гээд Боловсролын сайд дээр яагаад ийм шал өөр чиглэлийн ийм 5 хүрээлэн байдаг юм бол. Тэгээд үүний төсөв гээд харахлаар бас л багагүй хэмжээний төсвүүд байгаад байх юм. Тэгээд яг энэ Боловсролын яамны төсөвтэй холбоотой ийм асуулт.

Хамгийн сүүлийн асуулт. Би танай өгсөн өөр нэг танилцуулга слайд дээр хувийн сургуулиудад олгох хувийн ерөнхий боловсролын сургуулиудад олгох төсвийн хөрөнгөөс олгох нөхөн олговор юу гэх вэ, татаас 60 тэрбум гэж байсан. Тэр чинь яг энэ төсөв дээр байгаа энэ хүснэгт дээр харагдахгүй байна. Тэгэхдээ эсвэл өөр аль хэсэг дээр харагддаг вэ. Тэр дүнгээ та нар тодорхой хэлээд өгөөч. Танилцуулга дээр өмнөх 7 хоногт Байнгын хорооны гишүүдтэй уулзсан танилцуулга слайд дээр хамгийн хойд талын слайд дээр 60 тэрбум гэж байсан. Тэрийгээ тайлбарлаач.

Б.Найдалаа: Наранбаяр сайд хариулах уу. Наранбаяр сайдын микрофон.

Б.Наранбаяр: Тэгэхээр цахим үйлчилгээний зардлууд ингээд өсөж байгаатай холбоотой энэ асуудлыг хөндөж байна. Тэгэхээрээ бид бол цахим шилжилт, боловсролын гол шилжилтүүдийн шинэчлэлүүдийн 1 байгаа. Үүнтэй холбоотойгоор сургуулиудын интернэт хэрэглээний зардлыг бол олгож явж байгаа. Үүнтэй холбоотойгоор өссөн байгаа. Ер нь бол бид бас энэ цахим шилжилттэй холбоотойгоор “мэдлээ” гэж сургуулийг цахим орчинд байгуулж байгаа. Түүнээс гадна цахим контентуудыг боловсруулж ийм үйлчилгээг хүргэдэг. Тэгэхээрээ багшийн дутлыг арилгахын тулд бас алслагдсан сумдад бас энэ цахим байдлаар хичээл үзэх ахлах сургуулиуд ялангуяа хичээл үзэх ийм боломжийг нь олгож байгаа юм. Өнөөдөр 20-оод мянган контент бий болчихсон. Тэнд бас давхардсан тоогоороо энэ жил бол хүүхдүүд нэмэгдээд 30 мянга гарчихсан ийм боловсролын үйлчилгээг үзүүлж байгаа.

2 дугаарт нь мэргэжлийн боловсрол 4,1 тэрбумаар өссөн. Энэ сан бол ерөөсөө 6 гол үйл ажиллагааг явуулдаг. Түүний 1 нь болохоороо мэргэжлийн боловсролын салбарт суралцаад төгсөж байгаа хүмүүс төгссөнийх нь дараа нь бас 1 удаагийн буцалтгүй тэтгэлгийг олгож байгаа. Урьд нь бол сар болгон олгодог байсан нь өөрөө бүртгэлийн болоод энэ олгохтой холбоотой зөрчлүүд үүсгэсэн учраас ямар ч байсан төгсөхөд нь бол олгоно гээд. Тэгэхээр бид элсэлтээ энэ илээс нэмж эхэлсэн. Төгсөж байгаа хүүхдүүдээ нэмж байгаатай бас холбоотой ийм нэмэгдлүүд бас орж ирж байгаа юм. 20 мянган хүүхэд элсдэг байсныг 26 мянга болгож нэмэхээр тооцсон байгаа. Тэгэхээр энэ төгсөлттэй холбоотой бас иймэрхүү зүйлүүд бас нэмэгдэж байгаа.

Хүрээлэнгүүдийн тухайд бол яг манайд энэ чинь нөгөө Боловсролын яамыг анх 2024 онд шинжлэх ухаанаас нь салгаж байгуулсан. Боловсрол, шинжлэх ухааны яам гэж байсан бол Боловсролын яам болсон. Тэр шинжлэх ухааных нь хүрээлэнгүүд бол академийн харьяанд байдаг. Бүх хүрээлэн бол Эдийн засаг, хөгжлийн яамны харьяанд очсон. Их сургуулиудад байдаг ийм хүрээлэнгүүд бол манай дээр байдаг. Тэгэхээр энэ болохоор бид бас их сургуулиудад байгаа энэ хүрээлэнгүүдээ бол дэмжээд ингээд явж байгаа. Таны яг энэ дурдсан зарим яг манайд шууд хамааралтай нь бол дандаа их сургуулиуд дээр байгаа л хүрээлэнгүүд шүү.

Насан туршийн боловсролын хувьд энэ төсөв дээр гарсан бууралтын тухайд бол ер нь бол Хэмнэлтийн тухай хуулиараа л хувь хэмжээг бууруулсантай холбоотойгоор буурсан. Бид бас энэ судалгааны их сургууль болгохтой холбоотойгоор энэ хүрээлэнгүүдийг бас дэмжиж явж байгаа гэдгийг өмнөх асуултад нь хариулъя.

Хувийн сургуулиудын 61 тэрбум байх ёстой. Тэр бол энэ жил .../минут дуусав/

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Энэ боловсролын ерөнхий хууль дээр төрийн болоод төрийн бус өмчийн сургуулиудыг ялгахгүйгээр, тэнд суралцаж байгаа Монгол Улсад боловсрол эзэмшиж байгаа, суралцаж байгаа ийм хүүхдүүдэд бол хувьсах зардлыг олгодог. Энэ дүрэм журмынхаа хуульд заасан үүргийнхээ дагуу олгож байгаа ийм зүйл.

Танд бас тайлбарлаж хэлэхэд 70 мянга гаруй хүүхэд хувийн сургуульд суралцаж байна. Эдгээр хүүхдүүдийн Үндсэн хуулиар сурч боловсрох эрхийг нь хангахын тулд хувьсах зардлыг бол олгодог. Энэ дээр 10 сая төгрөгөөс дээш төлбөртэй сургуульд бол хувь хувьсах зардлыг огт олгодоггүй. 1 саяас дээш болоод ирэхээрээ итгэлцүүр нь буурай буураад 50, 60 70, 80 хувиар ингээд буураад явчихдаг. Өөрөөр хэлэх юм бол олгож байгаа хэмжээ нь бол төрийн өмчийн сургуулиас 2 дахин буураад, 2, 3 дахин буураад явчихдаг ийм учиртай. Ингэж бас энэ боловсролд хөрөнгө оруулахыг бол төрийн зүгээс дэмжиж байгаа .../минут дуусав/

Б.Найдалаа: Баасанжаргал гишүүн тодруулж асууна.

Х.Баасанжаргал: Энэ мэдээллийн технологийн үйлчилгээний зардал 3900 хувиар өссөн энэ тайлбарыг би яг энэ мэдээллийн технологийн үйлчилгээ дотроо ямар ямар багц үйлчилгээ, хаана хаанахтай гэрээ байгуулаад гэдэг энэ мэдээллийн задаргааг би авмаар байна. 1 дүгээрт. Сургуулиудын интернэт зардал гэж тайлбарлаж байх шиг байна. Тэрний мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар авъя.

2 дугаарт Их сургуулиудын дэргэдэх хүрээлэнгүүд гэж би бол ойлгохгүй байна. Яагаад гэвэл ШУТ сангийн дэргэдэх Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн гээд эд нар чинь бол дахиад тусдаа байгаад байгаа юм. Энэ судалгааны хүрээлэнгүүдээс гадна дахиад энэ Монгол судлалын хүрээлэн, Эдийн засгийн хүрээлэн, Соёл урлаг судлалын хүрээлэн гээд би ерөөсөө яг тэрийг чинь ерөөсөө ойлгохгүй байгаа байхгүй юу. Ямар чиг үүрэгтэй байгууллагууд ийм судалгааны хүрээлэнгүүд ингээд ямар ч боловсролын байгууллагатай хамаарахгүй хүнс эрдэм шинжилгээ судалгааны хүрээлэн гээд ингээд байгаад байдаг юм бэ гэдэг дээр л гайхаад байна л даа. Тэгэхээр энэ дээрээ та бас тодруулаад өгөөрэй. Сүүлийн тэр асуулт гол нь хувийн сургуулиудад .../минут дуусав/

Б.Найдалаа: Наранбаяр сайд. Зардлын яг аль хэсэг дээр бичигддэг вэ гэж байна. Хувьсах зардал. Наранбаяр сайдын микрофоныг нээе.

П.Наранбаяр: Тэгэхээр ойлголоо. Энэ цахим зардал дээр Монгол Улсад өнөөдөр цахим үйлчилгээ үзүүлж байгаа, цахим сургалтыг үзүүлж байгаа Эдүтэн, Персон зэрэг хөтөлбөрүүдийн лицензийнх нь төлбөрүүд бас шингэж орсон байгаа. Түрүүнд дурдсан. Жишээлбэл Монгол судлалын хүрээлэн гэхэд бол яг МУИС-ийн харьяанд байдаг, Засгийн газрын тогтоолтой хүрээлэн байгаа. Монгол судлалыг дэлхийд хөгжүүлэх, Монгол судлалыг дэмжих ийм зорилготой, МУИС-ийнхаа харьяанд байдаг учраас Боловсролын яамныхаа харьяанд явж байгаа. Түрүүнд бас яригдсан зарим нэг хүрээлэн бол яг ШУТИС-ийнхээ харьяанд байж байгаа. Тэгэхээрээ бид МУИС-ийн дэргэд болоод ШУТИС-ийнхээ дэргэд байж байгаа энэ хүрээлэнгүүдийг судалгааны их сургууль болж хөгжүүлэхэд нь зориулж дэмжлэг үзүүлж байгаа юм. Энэ судалгааны их сургууль болж хөгжинө гэдэг чинь энэ

хүрээлэнгүүд нь бэхэжнэ. Тэр хүрээлэн дээрээ магистраа сургаад, докторантаа сургаад явна. Хамтарсан судалгаа инновацаа хийгээд явна гэсэн ийм л юм байгаа юм. Бусад яг академийн харьяа хүрээлэнгүүд бол бүгдээрээ яг Эдийн засаг, хөгжлийн яам руугаа шилжсэн байгаа.

Б.Найдалаа: Баасанжаргал гишүүн нэмж тодруулах уу. Болсон уу. Хувьсах зардал ямар ангилалд ордог вэ. Тэрийг товчхон хэлээд өгөөч. Тэгээд цаг дууссан учраас дараагийн гишүүн асуулт асууна. Хувьсах зардал. Тодорхой хэлчих. Микрофонд хэлчих. Хувьсах зардал арай жоохон ерөнхий юм биш үү. Баасанжаргал гишүүний асуугаад байгаа нь арай өөр юм асуугаад байх шиг байх юм. Болсон уу. Хариулт болох уу Баасанжаргал гишүүн. Яамнаас ирээд тодорхой мэдээлэл өгчхөөрэй. Цаашаа явъя. Эрдэнэбат гишүүн асуултаа асууна.

С.Эрдэнэбат: 1 дүгээрт ирэх жил эрүүл мэндийн тоног төхөөрөмж дээр тухайлбал MRI, компьютер томограф гэх мэтчилэн зүйл дээр зарим хүмүүс мянган км-ээс явж ирж үзүүлж байгаа. Алслагдсан аймаг бүс нутгууд. Энэ дээр ямар тоног төхөөрөмжүүд байна вэ.

2 дугаарт хэчнээн хүн орон сууцны моргейжийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах вэ. Хаана, хаана. Хэдэн төгрөг байгаа вэ.

3 дугаарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардалд хуулиараа төсөвт байгууллагууд нийт зардлын 0,5 хувиа байлгана гэж заасан. Энэ төсвийн хуулийн заалт төсвийн үзүүлэлтүүд хангагдаж байгаа юу.

4 дүгээрт Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн даатгалын сангийн мөнгө хэдэн төгрөг байгаа вэ. Юунд зарцуулж байгаа вэ. Зориулалтын дагуу зарцуулж чадаж байна уу. Үгүй байна уу асуумаар байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хэчнээн төгрөг зоосон бэ. Хуучин 1 аймагт, 1 тэрбум төгрөг тавиад, тэгээд хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ гэдэг байдлаараа тавиад байдаг байсан. Энэ хэвээрээ юу. Нэмэх боломж байна уу. Үүний үр дүн юу байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Мөн боловсролын салбарт цалин хөлс, орлогыг нэмэгдүүлэхэд салбарын сайд бол 560 орчим тэрбум төгрөг байвал 25 хувь энэ тэр гэж байгаа. Үйлдвэрчний эвлэлийн шаардлага энэ тэр бол бараг 3 сая гараад явчихсан. Жилийн ажлын төлөвлөгөө дээрээ хүрэх үр дүн дээр нь 3 сая 500 гээд тавьчихсан юм байна лээ шүү манайхан өөрсдөө. Тэнгэрийн тоо тавилаа гээд байсан. Бид нар өөрсдөө батлахдаа тэгээд баталчихсан. 2026 онд 3,5 сая төгрөгт хүргэнэ гээд тавьчихсан байж байгаа.

Дээрээс нь эрүүл мэндийн ажилчдын цалин хөлсийг нэмэх талаар энэ салбарын яам хэдэн төгрөг тавьсан юм бэ. Та хэд ямар санал Сангийн яаманд хүргүүлсэн юм. Сангийн яам энийг нь дэмжээгүй хасчихсан юм уу, эсвэл дотроо зохицуулна гэдэг байдлаар ярьж байгаа юм уу. Энэ эрсдэл гарвал хэн хариуцах вэ. Эрүүл мэндийн зарим байгууллагууд чинь ч төлбөр авна гэдэг байдлаа зарлаад эхлэх гээд байна. Эхэлчихсэн явж байна зарим нь. Тэгэхээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ажилчдын цалин хөлс, эрүүл мэндийн эм тариа, үйлчилгээний хязгаарлалтууд яаж хийгдэхээр төлөвлөж байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Дээрээс нь бас манайх чинь андуураагүй бол соёлын салбарыг бас хариуцаж байгаа. Соёлын салбарт тухайлбал, спортын салбарт ихэнх 10 жилийн хүүхэд санал

хүсэлт их ирдэг юм. 10 жилийн суурь спортын хүүхдүүд тэмцээн, уралдаан наадамд оролцоход ер нь ямар ч дэмжлэг байдаггүй юм шиг байна лээ. Ерөнхийдөө бол яах вэ, олимп гэдэг байдал руугаа бол явдаг. Тэгэхээр энэ тал дээр ер нь мөнгө байна уу. Өвлийн спортыг дэмжих тал дээр хөрөнгө мөнгө тавьсан зүйл бол байна уу гэдгийг асуумаар байна. Хүүхдийн хоолны мөнгөн дээр хасчихсан байна гэдэг ийм санал ирсэн байна лээ. Энэ цэцэрлэгүүдийн үйлдвэрчний эвлэлийн холбооноос. Хүүхдийн хоолны мөнгөн дээр хассан зүйл байна уу. Инфляц чинь өсөөд хоолны өртөг нэмэгдэж байгаа энэ тал дээр хэдэн төгрөг тавигдсан юм бэ гэдгийг асуумаар байна.

Б.Найдалаа: 3 яамнаас асуулаа. Чинбүрэн сайд эхлэх үү. Чинбүрэн сайдаас эхэлье.

Ж.Чинбүрэн: 2026 он бол бас нэлээн сорилтыг давах ийм жил байгаа. Тийм учраас бид бас төсвийн хязгаар дотроо багтаж саналуудаа өгсөн. Мэдээж салбарын зорилго бол өндөр хэмжээнд ажилчдынхаа цалин хөлсийг нэмэх, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтыг бүгдийг нь л нэмье л гэсэн том зорилго тавьж байгаа. Тэр дотроо бас Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулж эмнэлгийн ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх ийм зорилго бол 3 их наяд давсан санхүүжилтийн санал орсон. 2026 онд бодитой төсөвт орсон дүрс оношилгооны тоног төхөөрөмж дотор бол энэ ЭХЭМҮТ-ийн MRI аппарат бол орсон байгаа. Бусад арай өртөг багатай тоног төхөөрөмжүүд нийтдээ 41 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авах ийм байдалтай төсөвт орсон.

Бид гаднын зээл тусламж, нэн хөнгөлөлттэй зээл тусламжаар дамжуулан харин 21 аймгийн эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийг сайжруулах тоног төхөөрөмж 2 жилийн хугацаанд хийхээр өнөөдөр зөвлөх баг ажиллаад эхэлчихсэн. Нийтдээ 21 аймгаар яваад ямар ямар тоног төхөөрөмжүүд хэрэгтэй байгааг судлаад гаргаж байгаа. Ингээд энэ Азийн хөгжлийн банкны төсөл батлагдвал 21 аймагтаа эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, тэр дотроо бас зүрхний шигдээс, харвалтаас сэргийлэх катлаб гэж нэрлэдэг ангиографик гэж бид ярьж сурсан ийм тоног төхөөрөмжүүдтэй, тэгээд дотор нь тэрийг агуулах шаардлагатай байшингуудыг нь хүний нөөц, тэгээд явдаг эмнэлэг буюу 150 гаруй ambulance худалдан авах ийм төсөл бичээд өгчихсөн. Энэ 2 жилийн хугацаанд хийгдэх ёстой.

Б.Найдалаа: Даваацэрэн дарга. Дараа нь Мөнхзул дарга. 6 дугаар микрофон.

Б.Даваацэрэн: Гишүүний асуултад хариулъя. 2026 онд биеийн тамир, спортыг дэмжих чиглэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлгүүд байгаа. Төсвийн төсөлд 21,9 тэрбум төгрөг тавигдсан байгаа. Үүнээс үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагаа 1,5 тэрбум, бусад спортыг дэмжих нь 426,3 сая төгрөг. Дотоодод зохиогдох олон улсын уралдаан тэмцээн 2,5 тэрбум төгрөг төсөвт тавигдаад явж байгаа.

Б.Найдалаа: Товчхон хариулахгүй бол минут маш бага байгаа. Та нэмээд хариулчих. Болчихсон уу. Тэгвэл Нийгмийн хамгааллын яамнаас Мөнхзул дарга хариулах уу. Та хариулахгүй юм уу. Батжаргал дарга. Өөрийгөө танилцуулаад микрофон 9. Товчхон хариулахгүй бол цаг байгаа юм байна шүү. 2 минут.

Б.Батжаргал: Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 2026 оны төсвийн төсөлд 69 тэрбум төгрөгийн зардал гаргахаар тусгасан. Энэ зардалд бол үйлдвэрлэлийн ослын улмаас тахир дутуу

болсон хүмүүсийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж, тэжээгчээ алдсаны тэтгэмж, богино хугацааны тэтгэмжүүд, нөхөн сэргээх төлбөрүүд, портезийн зардлууд, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал болон бусад зардал гэсэн ийм зардлуудыг төсөвлөсөн байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Эрдэнэбат гишүүн хариулт болсон уу. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан. Микрофон 5 уу.

З.Бауыржан: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар Бауыржан байна. 2026 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 117 тэрбум төгрөг төсөвт тавигдчихсан байгаа. Өнгөрсөн жилийн байдлаар 130 тэрбум төгрөгийн 2025 оны байдлаар төсөвтэй байсан. Энэ маань хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гарааны бизнесийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн жижиг дунд бизнесийг дэмжих, зорилтот бүлэг рүү чиглэсэн хөтөлбөрүүд хэрэгжихээр төлөвлөөд ажиллаж байгаа.

Б.Найдалаа: Эрдэнэбат гишүүн тодруулна.

С.Эрдэнэбат: Үйлдвэрлэлийн осол, мэргэжил сангийн үлдэгдэл хэд вэ гэж асуусан. Дээрээс нь 1 зүйлийг тодруулж Боловсролын яамнаас асууя. Боловсрол, шинжлэх ухааны ҮЭХ-ноос хийсэн шаардлага дээр Боловсролын салбар цомхотгол хийхгүй байх гэгчихсэн байна лээ. Одоо яг хэдэн хүнийг цомхотгох нөгөө 9 хувийг Боловсролын яам нь хамрагдаад, хэдэн хүн цомхотгох болчихоод байгаа юм бэ. Бид нар чинь Боловсролын салбар цомхотгол хийхгүй гэж ойлгож баталсан чинь хийнэ гэдэг байдлаар шаардлага ирчихсэн байгаад байдаг. Дээрээс нь ахмадын тэтгэврийг 6 хувь гээд тавьчихсан. Инфляц 8,8 хувь гэж байгаад байдаг. Тэгээд яагаад энэ хуульд тавигдсан шаардлагыг биелүүлэхгүйгээр Сангийн яам маань 6 хувь гэж инфляцыг өөрсдөө доош нь болгож оруулж ирээд байгаа юм бэ. Оны сүүлээр магадгүй инфляц өсөөд 10 руу болчихвол үлдсэн 4 хувийг нь хэн өгөх вэ. Төсвийн тодотгол хийх юм уу, яах юм.

Б.Найдалаа: Сангийн яамнаас асуулт. 8.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Тэтгэвэр нэмэх асуудлаар сүүлийн 2 жил бол өмнөх жилд 1 удаа бол 4 сарын 1-ээс тухайн жилийн бас энэ зорилтот инфляцын түвшнээр нэмсэн байдаг. Мөн 1 сард нь 100 мянган төгрөгөөр тогтмол дүнгээр нэмсэн байдаг. Бид бол төсвийн боломждоо тааруулаад ийм байдлаар оруулж ирсэн. Засгийн газрын хувьд энэ инфляцыг нам доогуур түвшинд барих ийм зорилго тавьж байгаа. Энэ зорилт руугаа явж байгаа гэж хэлье.

Б.Найдалаа: Тодруулах юм уу. Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Үгүй ээ, яах вэ зорилт тавьж байгаа нь бол сайн хэрэг. Гэхдээ бодит байдал чинь өөр байгаа. Хууль дээр өмнөх оны инфляцын түвшнээс доошгүйгээр гээд тавьчихсан байгаа байхгүй юу.

Б.Найдалаа: Баярлалаа энэ бол үг байлаа. Мөнхтуяа гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхтуяа: 2026 оны төсөвт реформын шинжтэй 1 ч гоц гойд зүйл алга. Тэгээд хүний хөгжил рүү чиглэсэн төсөв гэж худлаа яриад байгаа юм. Тэгээд бүр аргаа бараад, зарчмын зөрүүтэй санал гаргахаар хуруугаа уншуулсан гишүүд нь гараад явчихаар санал дэмжигдэхгүй уначхаж байгаа юм. Үнэхээр харамсалтай

байна. Тэгээд цалин тэтгэвэр нэмье гэсэн сэтгэл зүрхтэй хүмүүс ер нь цөөхөн байдаг юм байна. Харж байхад. Тэгээд Сангийн яамныхан нь бол дандаа болохгүй л гэдэг үг урдаас хэлж байна. Төсвийн тухай хуулиараа 30 хүртэл болно гээд цагаан дээр хараар биччихсэн байдаг. Гэтэл өнөөдөр энэ Их Хурлын тогтоол нь хуулийнхаа дээр байдаг юм уу. Төсвийн тухай хуулийнхаа дээр нь байдаг юм уу. Би тэгж ойлголоо өнөөдөр. Тэгээд хуулиас давсан тогтоолууд гараад байдаг юм шиг байна. Тийм үү. Дандаа ард иргэд рүү чиглэсэн юмыг хааж боосон, боомилсон ийм тогтоолууд гаргаад, ард иргэд нь ядуу хоосон, улных болгоод ингээд сууж байдаг. Өөрсдөө болохоор ерөөсөө санаа зовсон юмгүй. Асуулт асуунгуут дандаа болохгүй, бүтэхгүй гэдэг л хариу авч байна. Үнэхээр асуухаас ч бараг дургүй хүрч байна. Яг үнэндээ. Түрүүн Өргөдлийн байнгын хороон дээр Лувсанжамц гишүүн хэлсэн шүү дээ. 107 төрийн өмчит компани байна. Эд нарыг татан буулгахад өчнөөн тэрбум их наяд төгрөгийн боломж гарч ирнэ. Дандаа ах нарын ах дүү, хамаатан садан цалинжаад сууж байгаа тэр компаниудыг дампууруулаад байж байгаа гэж хэлсэн шүү дээ. Үнэн шүү дээ. Тэгээд тэр алт, нүүрс, зэс хаашаа яваад байгаа юм. Тэр мөнгийг хэнд зарцуулдаг юм. Хэдэн хулгайч нар нь хувааж аваад идчихдэг юм уу. Цалин нэмье гэнгүүт бүгд байхгүй болохгүй гэх юм.

Тэгээд Боловсролын сайдаас би ганц асуулт асууя. Боловсролын ерөнхий хууль дээр багш нарыг орон сууцжуулна гээд заачихсан. Ямар ч тодорхойгүй. Яаж орон сууцжуулах юм шалгуур байхгүй. Энэ 2026 онд хэдэн багшийг орон сууцад оруулах юм. 2025 онд хэдэн багш орон сууцад орсон юм. Ямар ч тоо байхгүй. Хэмжих нэгж байхгүй. Шалгуур байхгүй, худлаа тунхаг төдий юм тавьчхаад, түүгээрээ хүн хуураад суугаад бүр сурчихсан. Одоо ийм замбараагүй, зохисгүй байдлаа зогсоомоор байна шүү дээ бүгдээрээ. Хаана хаанаа. Тэгээд 1 асуулт асуунгуут дандаа болохгүй гэдэг хариу авсаар байгаад асуухаас ч бараг нуруу хавтайлцдаг боллоо. Үнэхээр хангалтгүй ажиллаж байна энэ Засгийн газар. Ажлаа хий л дээ та нар. Ажил хийнэ гээд л ажиллаж байгаа юм байгаа биз дээ.

Дан хаасан заалт. Түрүүн Эрдэнэбат гишүүн хэлж байна шүү дээ. Тэр 24 хувь гээд л заачихсан. Тэр нь тэгээд тогтоол шүү дээ. Хууль биш. Хууль дээрээ 30 гэж байхад тогтоол гаргаад 24. Ингэж ард түмнээ хааж боож байх ямар хэрэгтэй юм бэ. Тэгээд Их Хурлын гишүүн юм асуунгуут дандаа болохгүй, бүтэхгүй. Мань мэт шиг жагсаалтын шинэ гишүүдийг нь доош нь хийдэг юм уу эсвэл. Бид нар ард түмнийхээ төлөөлөл гэж сонгогдсон гишүүнийхээ хувьд ард түмний төлөө л юм ярьж байгаа шүү дээ. Хувийн эрх ашиг энд нэг ч яриагүй. Тэр төрийн өмчит баахан компаниудаа татан буулгаад энэ эмч, багш, тэр ядарсан иргэдийнхээ амьдрал ахуйг сайжруул л даа. Заавал тэд нар тэгээд даргын ах дүү нар компанийн захирал гээд идэж уугаад, өөрсдөө баяжаад сууж байх ёстой юм уу ер нь. Бүгдээрээ одоо үнэнтэйгээ л нүүр тулж ярья. Худлаа тойруулаад, хэдэн тоог хойно, урд нь оруулж ярьсаар байгаад, хорвоогийн өдөр хоногийг аваад, ингээд л амьдрал үргэлжилж байна. 4 жил ингээд дууслаа. Дандаа худлаа ярина. Хийж байгаа юм байхгүй. Тэгээд сайхан реформ хийнэ. Хүний хөгжил гээд заачихсан. 2026 оны бодлогын баримт бичиг гээд. Тэгээд хүний хөгжил рүү чиглэсэн юм юу байгаа юм. Юу ч байхгүй. Боловсролын салбарын төсвөөс 1 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв баталчихсан, 2025 оноосоо, 2024 оноосоо ухарчихсан. Тэгээд энийг хөгжлийн реформ гэж хэлэх үү. Үнэхээр харамсалтай байна нээрээ.

Б.Найдалаа: Баярлалаа. Мөнхтуяа гишүүн үг хэллээ. Саранчулуун гишүүн. Уучлаарай. Багшийн орон сууцны талаар асуулт Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээр Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Үнэхээрийн энэ салбарт багш нарыг орон сууцаар, ялангуяа 5, 10 дахь жил дээрээ багшилж байгаа багш нарыг, мөн залуу багш нарыг бас орон сууцаар дэмжих нь туйлын чухал байгаа. Тантай бол санал нэг байна. Тэгэхээр энэ дээр жишээлбэл нийслэл болоод бусад орон нутгийн байгууллагуудын дэмжлэгээр бас багш нарт олгосон ийм орон сууцны мэдээллүүдээс харж байхад нийслэлд бол 43 багш гэр бүлд, нийтдээ 86 багшид жишээлбэл ипотекийн зээлийг нь олгоод орон сууцад оруулсан 43 өрх гэсэн үг ийм бас тоон мэдээ байна лээ. Бид бас эндээсээ ипотекийн зээлийг багш нарт олгоход бас ямар боломж байна гээд судалж үзсэн. Танд нэг тоо хэлье. Өнөөдрийн 2025 оны 5 дугаар сарын Монголбанкны мэдээллээр бол зээлийн үлдэгдлийг нь харахад 8,2 их наяд төгрөг байна. Үүнээс бол 80м2-аас дээш талбайтай орон сууцны 8421 зээлдэгчид 1.8 их наяд төгрөгийн орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийг олгочихсон байна. 80м2-аас дээш. Тэгээд 150м2-аас дээш талбайтай орон сууцад бол 516 тэрбум төгрөгийн зээлийг 1380 зээлдэгчид олгочихсон байгаа юм. Тэгэхээр үүнийгээ бол анх удаа орон сууц худалдан авч байгаа, бага, дунд орлоготой ийм энгийн төрийн албан хаагч хүмүүстээ зориулж эхэлье. Багш нартаа зориулъя гэвэл боломж байна гэж харж байгаа юм. Тэгэх юм бол бид бас энэ дээрээ цаашдаа жилдээ 1 мянга орчим багшид ипотекийн зээл олгох боломж байна гэж харж байгаа. Үүнийгээ бас саналаа Засгийн газар дотроо хэлэлцүүлэхээр Ерөнхий сайдад, бусад яамдад хүргэсэн байгаа. Иймэрхүү байдлаар бид ипотекийн зээлийг хэрвээ олгож эхлэх юм бол энэ бол багш нарыг бодитой дэмжих ийм дэмжлэг болно гэж харж байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Тодруулж асууна Мөнхтуяа гишүүн.

Ц.Мөнхтуяа: Тэгээд ер нь бол багш нарын цалинг, бусад төрийн албан хаагчдын цалинг ч гэсэн ер нь нэмэх сонирхол байхгүй юм байна гэдэг нь бол ойлгомжтой байгаа шүү дээ. Өнөөдөр яриад байгаа асуудал биш. Би бол энэ асуудлыг 8 жил ярьж байгаа. Бүр аргаа бараад Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл санаачлаад өргөн барьсан. 7 сард. Тэгээд энэ хуулийн төслийг маань хэлэлцэхгүй. Миний ард барьсан хүмүүсийн хуулийн төслийг хэлэлцэхээр аваад байгаа байхгүй юу. Найдалаа дарга манай Байнгын хорооны дарга шүү дээ. Тэгэхээр энийг бас хэлэлцэх асуудал дээр та бас дэм болж өгнө шүү гэдгийг бол танаас хүсье.

Тэгээд энэ Боловсролын ерөнхий хууль батлагдсанаар энэ нөгөө тээг саад болоод байгаа нэлээн олон асуудлуудыг шийдэх боломж хуулиар гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэн дээр бас манай энэ гишүүд бас сайн дэмжлэг болж өгөөч ээ гэдгийг хүсмээр байна. Тэгээд ингээд ард өгсөн хуулиуд нь хэлэлцэгдээд, миний аль .../минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Энэ бол асуулт биш тийм ээ Мөнхтуяа гишүүн ээ. Зүгээр яг нөгөө холбоотой асуудал болохоор 1 асуулт байна. Энд Чинбүрэн сайд байна. Наранбаяр сайд байна түрүүний төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байхад цалингийн асуудал боссон. Тэгээд 1 ийм асуулт байна. Манай гишүүд бүгдээрээ энийг асуух гэж байгаа. Мөнхтуяа гишүүний яриад байгаа чинь яг энэ. Багш нарын цалинг нэмэхийн тулд төсөвтэй зууралдаад нэгэнт боочихсон, өргөн барьчихсан төсвөөс бол энд тэндээс нь хөдөлгөөд бол юм гарахгүй. Тэгэхээр энэ болбол төсвийн юм уу, Сангийн яамны асуудал биш байгаа. Салбарын яамны бодлогын асуудал. Өөрөөр хэлбэл Засгийн газрын бодлогын асуудал. Эмч нараас эмнэлгийн ажилтнуудаас асар их санал ирж байгаа. Багш нараас бол ирээд удаж байгаа. Ахмадуудаас ч байгаа. Агуулга нь адилхан. Ингэж болох уу ингэвэл яадаг

юм. Боловсролын яам Засгийн газар дээр ярьж байгаад, Эрүүл мэндийн яам Засгийн газар дээр ярьж байгаад ирэх 5-6, 7 жил Багшийн хөгжлийн хөтөлбөр ч юм уу тэгж батлаад, эмч, эмнэлгийн ажилтны хөтөлбөр гэж батлаад, тэр дээрээ цалинг нь тэд болгоно гээд тодорхой заагаад, дүнтэй. Жил болгон ингэж явна гээд. Тэгээд тэрийгээ Засгийн газрынхаа хурлаараа эсвэл хэрэгтэй бол Их Хурлаар батлуулчих. Өөрөөр хэлбэл Монгол Улс багш нарынхаа цалинг, эмч нарынхаа цалинг нэмэх бодлоготой болчихъё. Тоотой болчихъё. Тэгэх юм бол бие биеэ хянаана. Тэгэх юм бол жагсах шаардлагагүй болно. Тэгэх юм бол уулзахаараа цалин яриад, тэгсэн хэр нь хүүхдийн сургалтын чанар ярьдаггүй. Эмч, эмнэлгийн үйлчилгээний чанарын тухай биш, цалингийн тухай ярьдаг. Эсвэл эмч, багш нар хаана нэгтээ явж ажиллах тухай боддог баймааргүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бодлого нь байхгүй болохоор бид нар төсөвтэйгөө зууралдаад байх юм бол хоосон тоо яриад, хоорондоо хэрэлдээд, жагсаад ямар ч үр дүнгүй, улсаараа мухардаад сууж байгаа юм. Тийм болохоор асуулт байна. 2 сайдаас асууя. Манай Байнгын хорооны гишүүд бас ярьж байсан юм. Энийг яг тодорхой хариулж өгөөч. Яг тийм хөтөлбөр баталъя. Батлахад юу нь болохгүй байна. Мөнгө, төсөв байхыг битгий ярь. Тэрийг бол Сангийн яам дээр нааш цааш болгодог зүйл болохоос биш, салбарын яам бол салбарынхаа улсын хөгжлийг л ярих ёстой. Хөгжлийн бодлого ярьж байна бид нар. Хэрвээ багш нарын цалинг нэмэхэд мөнгө дутаад, дутна гэж би бодохгүй байна. Бодлого нь байхгүй болохоос мөнгө нь байхгүй ердөөсөө биш шүү. Тэгэх юм бол дараа дараагийн хөрөнгө оруулалтын ач холбогдлыг бид нар хүссэн, хүсээгүй бодохоос өөр аргагүй болно. Тэгэхгүй бол өмнөхөөрөө ингээд урсаад явж байя. Энэ удаадаа тийшээ, тийшээ зам барьчихъя. Тэр, тэр байшин барьчихъя. Тэгээд мөнгө байхгүй юмыг чинь нэмэх боломжгүй. Иймэрхүү байдлаар торгоож явахгүй байна. Тэгэхээр 2 сайдаас тодорхой асуух зүйл байна. Энэ зөвхөн миний асуулт биш. Олон хүн асууж байгаа. Эмч, багш нарын цалинг иймэрхүү байдлаар урт хугацааны бодлого, тоотой дүнтэй нь батлаад, тэрийгээ мөрдөөд, тэрийгээ хянаад явбал яасан юм бэ. Энэ боломжтой юу. 2 сайд хариулах юу. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Найдалаа даргын асуултад хариулъя. Тэгэхээр энэ боломжтой гэж бодож байгаа. Тэгж явах ч ёстой гэж харж байгаа. Тийм учраас бас цалин нэмэгдүүлэх 3 жилийн төлөвлөгөөг бид боловсруулах ажлын хэсгээ байгуулаад өнөөдөр Засгийн газарт өргөн барихаар ажиллаж байгаа. Ер нь бол 3 жилээр нь хараад ирэх юм бол бас төлөвлөж байгаа Сангийн яамныхандаа ч гэсэн амар болно. Эдийн засаг, хөгжлийн яамныханд ч гэсэн амар болно. Бас үүнтэй холбоотойгоор ер нь ДНБ болоод төсвийн зарлага дотор боловсрол эзлэх энэ хувь хэмжээг бас нэг хэсэгт нь тогтвортой өсгөх ийм бодлого барьчихмаар байгаа юм. Өнөөдөр бид бол ДНБ дээр 4,1 хувь байхаар тооцсон явж байгаа юм. Төсвийн зарлага нь 14,7 хувь руу. Тэр нөгөө хөрөнгө оруулалт нь 2 дахин нэмэгдчихээр 7 хувь руу орж байгаа юм. Тэгээд энийг уг нь бол олон улсын хэмжээнд Инчоны тунхаглалаар өгсөн зөвлөмжид бол Монгол Улс элсээд орчихсон байгаа. Тэгээд энэ дээр бол төсвийнхөө зарлагынхаа 20 хувийг л боловсролд зарцуулаад байвал олон асуудал шийдэх юм байна л гээд байгаа юм. Энэ тоо бол бодитой, үнэн. Үнэхээрийн 20 хувь руу бид оруулаад, энийгээ хэрэглээд, зөвхөн боловсролдоо зориулаад эхлэх юм бол энэ салбарын олон ужиг болсон асуудлуудыг, тэгш хүртээмжийн, тэр сургуулийн барилгын, мөн багшийн дутлыг хүртэл, энэ цалингийн асуудлыг хүртэл цогцоор нь шийдэх боломж бол байгаа юм. Тэгэхээр бид бас энэ 3 жилийнхээ цалин өсгөх төлөвлөгөөгөө бас үүнтэй уялдуулж явах ёстой гэж харж байгаа. Тэгэхээр энэ бусад салбаруудтайгаа зохицох, яг бусад, ялангуяа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цалин барьж байгаа, бодлого барьж байгаа хүмүүстэйгээ зөвшилцөж ярилцах ийм шаардлага байгаа гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ ажил бол эхлээд явж байна. 3 жилийн төлөвлөгөө гаргаад тавьчихсан байхад таны хэлдэг

яг үнэн. Ингээд зөвхөн цалин тойрч, зөвхөн үүнээс өөр асуудал ярихгүй болчих хэмжээндээ хүртэл ийм нөхцөл байдалд бид ороод байхгүй. Нэгэнт ярьчихсан бол энийгээ хэрэгжүүлээд явахаа шаардаад л явна. Нэгэнт тохирчихсон бол үүнийгээ энэ зорилгодоо хүрэхээр хамтдаа л явна. Ийм л болоод эхэлнэ. Ингээд ирэх юм бол түрүүнд ярьсан энэ тоогоо жоохон ярилцаад хөдөлгөж чадах юм бол бид бол асуудлаа шийдэхэд ямар ч асуудалгүй болох ийм л болно. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Чинбүрэн сайдын саналыг сонсьё.

Ж.Чинбүрэн: Эрүүл мэндийн салбар, Боловсролын салбарыг бодох юм бол арай жоохон өөр. Бид гүйцэтгэлийн санхүүжилтээр буюу Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд суурилсан, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо гэдэг систем байгаа. Энэ систем бас ажиллаж болдог юм гэдгийг бид бас Ковид цар тахлын үед 14 хоног эмнэлгийн ажилчид өвчтөнтэйгөө цуг карантинд ороод, тэгээд 5-7 сая хүртэл цалин аваад байж болж байсан. Тэгэхээр энэ бол бүрэн боломжтой. Гагцхүү бид даатгалын тогтолцоог өөрийг нь, даатгалын тэнцлийг өөрийг нь зөв болгох, алдагдалгүй болгох, хуримтлал нь хангалттай хүрдэг байх энэ тогтолцоог хийх гээд байгаа. Нөгөө сая яриад байгаа төсөвтэй цуг бариад байгаа 3 жилийн том зорилго биеллээ олоход бид бол дээд талын хязгаар тавихгүй. Харин доод хязгаар тавина. Доод хязгаар тавина. Дээшээ гүйцэтгэсэн, хийснээрээ хэд ч хүртэл авах боломжтой байх ийм тогтолцоо руу орох, бидэнд хийж үзсэн боломж байгаад байгаа юм.

Дээрээс нь энэ бид нарын бас энэ ковид .../минт дуусав/

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Алдаа юу байна вэ гэхээр олон нийтийг хамарсан халдварт өвчин дээр даатгалын сангийн санхүүжилтийг зарцуулсан нь өөрөө том алдаа. Тэгээд тэр алдаагаа нөхөж чадахгүй байсаар байгаад энэ байдал хүндэрчихсэн. Тэгэхлээр бид бас нэг томоохон шинэчлэл хийж байгаа, энэ 2026 оны төсөвт орж байгаа зүйл бол нийгмийн эрүүл мэндийн ажилчдын цалинг жишээлбэл Халдварт өвчтөн судлалын үндэсний төвийн цалинг төсөв дээр тавьж өгсөн шүү дээ. Гүйцэтгэл дээр биш. Тэгэхээр олон нийтийг хамарч байгаа өвчин дээр энэ даатгуулагчдын мөнгийг зарцуулах нь өөрөө буруу гэдэг энэ шинэ зарчмаа хэрэгжүүлж эхэлж байгаа. Тэгэхлээр үе шаттай, шат болгоноор асуудлыг шийдээд явах ийм бүрэн боломж байгаа. Тийм учраас энэ төсөвтэй хамт барьж байгаа энэ хөтөлбөр маань энэ даатгалыг зөв болгоод, даатгал өөрөө эрүүл мэндийн тогтолцоогоо аваад явчихдаг. Энэ нь тэгээд дээрээс нь олон үнэтэй төмөр худалдаж авах шаардлагагүй болно. Тэр даатгалын гүйцэтгэлээр эрүүл мэндийн байгууллагууд нь өөрсдөө санхүүжилтээ аваад, цалин хөлс, эмнэлэг бүх л юмаа хийх энэ зөв тогтолцоо руу орох юм.

Б.Найдалаа: Баярлалаа. 2 сайд саналаа хэлсэнд баярлалаа. Бид нар манай Байнгын хороо дээр ярьж байгаад иймэрхүү бодлогын чиглэл рүү л өөрчлөлт хийнэ. Гишүүд, улс төрчид шахна гэж бодож байгаа. Эхлээд бодлогоо баталчихъя. Гэхдээ 3 арай богино байх. Дор хаяж 5 жил байж байж улс төрийн циклээс өөр байж байж тэгээд Улсын Их Хурлаар батлуулж байж, хууль болж байж тэгээд тэрийгээ шаардах, нэхэх, хянах, тэгээд цалин ярьдаггүй, ажлаа ярьдаг болмоор байна. Баярлалаа. Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Би өнгөрсөн жил ярьж байсан нөгөө олон улсын гэрээ конвенцод 6, 7 гэрээ конвенцод Монгол Улс нэгдэж ороод, манай улс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийнхээ талаар ийм ийм зүйлүүдээ хийнэ гээд амлалт авчихсан ажил байгаа. Тэрний тэр Берлин намааны тунхаглал дээр юун дээр очиж гарын үсэг зурж уулзсан бэ гэхээр хөгжлийн зорилтот төслийнхөө 10-15 хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжихтэй холбоотой зардалд оруулна гээд амлалт, үүрэг хүлээгээд Монгол гээд нэрээ дуудуулаад хүрээд ирчихсэн байгаа. Тэгээд тухайн үед би явахдаа зөндөө сайд хүмүүсээс зөвлөгөө, чиглэл авч байсан. Тэгээд болж байна гэж байсан. Тэрнээс улбаалаад Сангийн сайд болон Сангийн яамныхантай би ярьж байсан. Та хэд маань нэг ангилал гаргаа юу гээд. Тэгээд Гэр бүлийн яам бас ангилал гаргаж өгсөн гэсэн. Тэгэхдээ сая ирсэн төсвийн нөгөө ирсэн файлыг эргүүлж тойруулж үзээд нөгөө ангилал дээр тусгагдсан зүйлээ би бол олж харсангүй. Одоо тэгээд боогдоод, базаад хаана нь ч орчхов доо нөгөө ангиллаар байсан төсөв маань гээд. Тэгэхээр энэ улсын төсөв, төлөвлөгөө, дараа нь эргээд энэ чинь тайлан болно. Нөгөө олон улсын гэрээ конвенцод нэгдсэн юмныхаа хариуг ямар баримт бичгийг ашиглаж энэ нийт зардлын 10-15 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжихэд зарцуулагдсан юм. Шууд болон шууд бус гэж ярих вэ. Сангийн яам тэр нөгөө төслийг авдаг формат, маягт байгаа шүү дээ. Яамнуудаас, төсвийн захирагч нараас. Тэд нар дотроо энэ ангиллыг тусгаж өгсөн үү. Ямар багана, нөгөө ярьсан багана чинь байгаа юм уу. Эсвэл яаж оруулсан юм бэ гэдгийг нь бүр нэг нүдэнд харагдахаар тайлбарлаад өгөөч. Тэгээд би дараа нь дахиад тодруулна.

Б.Найдалаа: Сангийн яам 8 номер. Сангийн яамнаас асуусан байна. 8 номер хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Бид нар бол хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй холбоотой зориулалт бол нээсэн байгаа. Төсвийн хавсралт дээр гарч ирж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээ гээд өмнөх жилүүд дээр байхгүй байж байгаад, тэгээд 2025 оноос тодотголоос эхлээд энэ зардал дээр бол төсөв тусаад эхэлчхэж байгаа. Одоо 1 дутагдалтай зүйл байгаад байгаа нь юу вэ гэхээр энэ дээрээ таарсан бид нар энэ зардал нь өөрөө юунд очиж хүрч байна гэдэг хяналтын асуудал 1 дүгээрт хэрэгтэй байгаа. Тавьж байгаа зорилт нь өөрөө бас чухал болчихоод байгаа. Тэгэхээр хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээр үүнтэйгээ уялдаж, энэ мөнгөтэйгөө уялдаж гарч ирэх юм бол илүү цаад зорилт руугаа уях гээд байгаа. Ямар ч тохиолдолд ямар ч байсан тусгайлан зориулалт гаргачихсан учраас энэ дээр мөнгө төсөвлөх боломжтой болчихсон. Одоо гол нь олон улсын тэр байгууллагуудын өмнө хүлээгдэж байгаа болон Монгол Улсын өөрийнхөө хөгжлийн зорилт хүлээж байгаа зүйл рүүгээ .../минут дуусав/

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тодруулъя. Саранчулуун гишүүний микрофон.

О.Саранчулуун: Баярлалаа. Тэр тодруулсан нь бол энэ ирж байгаа материал дээр бол байхгүй. Танай систем дээр байгаа юм байна гэж би ойлгож байна. Зөв үү гэдэг 1 асуулт байна.

2-т гэвэл та хэд төсвийн ерөнхийлөн захирагчид болох 30 хүн билүү тэд нараас яг энэ зардлын ангиллын дагуу материалаа өгнө үү. Төсвийн төлөвлөгөө өгнө үү гээд явуулахад чинь хэн нь дагуу зардлаа өгөөд, хэн нь өгөхгүй байгаа тухай мэдээллийг олон нийтэд ил тод болгож өгөөч ээ. Бүгдээрээ нэгэнт эхлүүлчихсэн юм чинь дуустал нь энийгээ хийчихмээр байгаа байхгүй юу. Тэгэхээр хэрвээ зардлаа,

хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан зардлыг юу гэдгийг ойлгохгүй байгаа бол судлахгүй байна гэсэн үг. Бид нарын өгсөн зааварчилгааг авахгүй байна л гэсэн үг шүү дээ тэ. Тэгэхээр ямар яам нь тэрний дагуу яг материалаа бүрдүүлж өгөөд, ямар нь тэрний дагуу материалаа өгөхгүй байгаа талаар хэл дээ.

Б.Найдалаа: 8 номер.

М.Санжаадорж: Одоогоор энэ зориулалт дээр бол ирэх 2026 оны төсвийн төсөл дээр 3 сайдын багц дээр төсөв төсөвлөгдсөн байна. Хамгийн гол зардал нь бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсөв дээр яг энэ зориулалтаар төсөв төсөвлөгдсөн. Нийтдээ 16 тэрбум 800 сая төгрөг төсөвлөгдсөн. Дээр нь нэмээд Эрүүл мэндийн сайдын багц дээр төлөвлөгдсөн байна. Мөн Боловсролын сайдын багц дээр бол төсөв төлөвлөгдсөн байна. Энэ болохоороо зөвхөн программ дээр биш, энэ программ нь өөрөө шинэ зориулалт нээчихээр Сангийн сайдын тушаалаар батлагдчихаж байгаа учраас танд тараасан төсвийн хавсралт дээр бас зориулалт гэсэн хавсралт бай байгаа. Эдийн засгийн ангиллаар ялгахаас гадна зориулалтаар ялгаж болно. Яамаар нь ялгаж болно. Аймгаар нь ялгаж болно. Тэрний зориулалт гэсэн хэсэг дээр байгаа шүү.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн дахиад тодруулна.

О.Саранчулуун: Баярлалаа. Тэгвэл ингэж болох уу. Энэ 3 яам л энэ чиглэлээр төсвөө төсөвлөж өгөөд, бусад яамд бол төсөв, зориулалт гаргаагүй байна гэдэг дүгнэлтийг хийж болох уу. Эсвэл гаргасан ч гэсэн ялгаж тодорхойлохгүй байна гэсэн үг юм уу. Эсвэл юуг тодорхойлохоо мэдэхгүй байна гэсэн үг юм болов уу. Бусад яамд болон ерөнхийдөө бусад төсвийн захирагч нар яагаад яг энэ ангиллаар материалаа өгөөгүй шалтгааныг бас тайлбарлуулмаар байна л даа.

Б.Найдалаа: 8 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Төсвийн процесс маань бол яаж явдаг вэ гэхээр Төсвийн хүрээний мэдэгдэл бол 6 сарын 1-нд батлагдчихаж байгаа. Ингээд батлагдсан төсвөөсөө бол бид нар ирэх жилээ олж болох орлоготоо тооцуулаад зарлага бол тэнд батлагдсан нийт зарлага байж байдаг. Нийт зарлагаа хуваагаад яамнууд руугаа бид нар 7 сарын 1 гэхэд процессын хувьд бол өгчихдөг. Ингээд зарлагын энэ хязгаар дотроо багтаагаад төсвийн ерөнхийлөн захирагч нар бол саналаа ирүүлэх ёстой байдаг. Мэдээж хэрэг яамд болгоны хүсэл бол маш хязгааргүй байгаа. Тэгэхээр энэ төсөв дотроо багтаагаад саналаа ирүүлэхдээ тэр санал нь тодорхой шалтгааны улмаас орж ирээгүй байна гэдэг зүйлийг төсөв талын процессоос нь бол хэлэх байна. Илүү ойлголт талаас нь юу гэдэг юм энэ зардлыг ямар учраас төсөвлөх ёстой вэ. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн тухай хуулийг яаж ойлгож байна вэ. Энэ хуулийн хэрэгжилтийн талаар яах вэ гэдгийг бол салбарын яамнуудаас нь өөрсдөөс нь тодруулах нь зөв болов уу гэж бодож байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Тодруулах цаг дууссан. Зүгээр гишүүддээ сануулахад хэрвээ хариулт хэт нуршаад ч юм уу, хариултаа авчихсан бол таслаад, цаг хэмнэх үүднээс дараагийнхаа хүнд шилжүүлж болно шүү. Гараа өргөөрэй. Би эндээс удирдаад явчихна. Дараагийн гишүүн Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: 2026 оныг Засгийн газраас боловсролыг дэмжих жил болгож зарласан байгаа. Тэгэхтэйгээ зэрэг мэдээж энэ салбарынхаа хүмүүсийн цалин

хөлсний асуудалд бас онцгой анхаарах шаардлагатай. Түүнээс гадна зарим хүмүүсийн яриад байгаа шиг бас энэ бетон цутгах ажил чинь хөдөө, орон нутагт чухал байна л даа. Мэдээж тэнд чинь ажиллаж байгаа, сурч байгаа хүмүүсийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, тэр хөдөө орон нутагт зарим газар сургууль нь нураад унах гэж байна. Зарим газар нурчихсан байна. Зарим газар зайлшгүй бас их засвар хийх шаардлага байна гээд энэ барилга байшинтай холбоотой асуудал бол бас цалин хөлснөөс дутахгүй хэмжээнд тавигдах ийм онцгой ач холбогдол өгөх асуудал л даа. Тэгээд ирэх жил Боловсролын сайдын багц дээр 1,3 их наядын дүнтэй 448 тэрбум төгрөгийн л хөрөнгө оруулалт хийгдэх юм байна. Энэ бол мэдээж боловсролын салбарт, энэ том салбарт өргөн уудам газар нутагтай манай орны хувьд бол чамлалттай төсөв. Тэгээд ер нь ирэх жилүүдэд боловсролын салбарт 100 гаруй сургууль, 100 орчим цэцэрлэг барьчихвал энэ боловсролын салбарын байшин барилгын асуудал шийдэгдэнэ гэж бид нар Галбадрах багшаар ахлуулсан ажлын хэсэг дүгнэлт гаргасан, судалгаа хийсэн байгаа. Тэгээд ирэх жилийн төсөв дээр бол 135 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, ирэх 2026 онд 46 тэрбум төгрөг нь санхүүжих 15 шинэ сургууль, цэцэрлэг, боловсролын салбарын л байшин барилгын асуудал тавигдсан байна. Нөгөө 200 гаруй байшингийн чинь дөнгөж 15 нь тавигдсан байна шүү дээ. Тэгэхээр энэ бусад асуудлаа ер нь хэзээ шийдэх юм бэ. Ямар хөрөнгө оруулалтын эх үүсвэр, ямар одоо арга замаар шийдье гэж төлөвлөж байгаа юм бэ. Боловсролын яамнаас асуумаар байгаа юм.

2 дугаарт нь ер нь өнгөрсөн жилүүдийн удсан барилга байшингуудын чинь асуудал бол ер нь зураг төсөл муу, төлөвлөлтгүй, эсвэл сонгуулийн жилд зориулж 5 тэрбумаар барих байшинг 2 тэрбумын төсөв тавьчихаад ийм заваарсан юм хийж явснаас болж л одоо ер нь сунжраад, дараа дараачийнхаа жилийн ирээдүйн хөрөнгө оруулалтуудаа гацаагаад, зогсоогоод, ингээд урд талынх нь дуусаж өгдөггүй ийм л зүйл байгаа шүү дээ. Тэгэхдээ зэрэг ирэх жилийн төсөвт Боловсролын сайдын багц дээр ирэх жилүүдэд хийх тэр олон сургууль, цэцэрлэгийнхээ барилгыг төлөвлөх зураг төслийн мөнгө төгрөг, ер нь тийм санхүүжилт тусгаж болдоггүй юм уу.

Мөн энэ боловсролын салбарт цалин хөлс, барилга байшингаас гадна дахиад хөдөө, орон нутагт багшийн дутагдал гэж том асуудал байгаа. Хөдөө, орон нутагт зарим сумдад нарийн мэргэжлийн яг мэргэжлийн багш буюу биологийн багш, газар зүйн багш байхгүй 2, 3 жил болж байгаа сумууд хүртэл байгаа. Зарим сумуудад цахимаар орж байна. Тэгэхээр энэ багшийн дутагдлыг нөхөх тал дээр ер нь хөрөнгө тавигдсан уу. Энэ дээр ер нь ямар бодлогын арга хэмжээ авч, энэ төсөв хөрөнгөтэйгөө уялдуулж энэ асуудлыг шийдэж, энэ асуудлуудыг бас хариулт өгч явах юм бэ гэдэг ийм асуултыг Боловсролын сайдаас асууя.

Б.Найдалаа: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр үнэхээрийн энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ийм зорилгоор бас таны санаа тавьж хэлж байгаа бол яг үнэн. 108 сургууль, 95 цэцэрлэгийг ер нь бид 2028-2030 оны хооронд гэхэд бүгдийг нь оруулчих юм бол боловсролын салбар тэр үед 14 хувиар хүүхэд нь нэмэгдэх юм. Ерөнхий боловсрол дээрээ. Энийгээ бүрэн шийдчих юм байна гэсэн 2 ээлжийн сургуулийг ч гэсэн цааш нь ингэж багасгаж эхлэх юм байна гэсэн ийм тооцоо хийсэн. Энэ жилийн тухайд бол бас энэ. Ер нь бол төсвийг бүхэлд нь шинэ гэхээсээ илүү шилжиж ирж байгаа энэ барилгуудыг дуусгая гэсэн ийм бас зорилтын хүрээнд бид бас энэ ажлыг төлөвлөсөн байгаа. Шинэ дээрээ бол яг одоо амьдрал дээр гараад яахаар жишиг 1 маягийн зураг гэдгийг бол хүлээн зөвшөөрөхгүй, янз бүрийн

холболтын зураг хийхээрээ маш их төсөв өөрөө хөдөлж эхэлдэг. Үүнээсээ болоод барилгууд нь удааширч эхэлдэг. Үүнээсээ болоод жишээлбэл тарифынх нь өөрчлөлт бий болоод барилгын компаниуд нь ажлаа хийхээ болиод, сүүлдээ 2 талдаа гараад эхэлчихдэг ийм зовлонтой юм байгаад байгаа. Тэгэхээр эхнээсээ зураг төсөвтэй ийм төсвүүдийг л оруулна гэснээрээ яг төсөвт орсон нь бол таны хэлсэн ийм цөөхөн тоо байгаа.

Харин Азийн хөгжлийн банктэй зээлээр ярьж байгаа бидний төсөл дээр бол нийтдээ 41 сургууль, цэцэрлэг шинээр орж ирсэн. Энэ нь болохоороо зураг төсвийг нь бас тухайн тухайн орон нутагт нь тааруулаад ингээд хийгээд явах ийм боломжтой ийм байгаад байгаа юм. Тэгэхээрээ бид бол 2025 онд бол яг энэ хөрөнгө оруулалт тал дээрээ бол энэ 470 хэдэн тэрбум дээрээ нэмэх нь 590 тэрбумаар нэмж чадсан. Ингэснээрээ бол 1 их наяд, 43 тэрбум байсан байх ийм хэмжээний хөрөнгө оруулалтыг бол сургууль, цэцэрлэг барихад зориулж байгаа. Энэ бол өнгөрсөн жилийнхээсээ 2,3 дахин нэмэгдсэн ийм төсөв байгаа.

Тэгэхээрээ бид бас цаашдаа энэ төсвийг ямар ч асуудалгүй төсөвтөө тусгадаг байхын тулд бүх сургууль, цэцэрлэгүүдээ ер нь газартай, тэгээд зураг төсөвтэй байлгах дээр л онцгой анхаарахгүй бол болохгүй байна гэсэн ийм л нөхцөл байдал үүсчхээд байгаа юм.

Багшийн дутлын тухайд бол үнэхээрийн ялангуяа хөдөө, орон нутагт бол нарийн мэргэжлийн багш нар бол онцгой дутагдаж байгаа. Яг одоо химийн багш, физикийн багш, англи хэлний багш гэх мэт. Тэгэхээр энэ дутлыг арилгахын тулд бол Боловсролын яам 6 багц арга хэмжээг оруулж, Засгийн газрын тогтоол болгож гаргасан. Ер нь багшийн дутлыг арилгахад яг орон нутагт олгож байгаа тэр 40 хувийн нэмэгдэл, сумын төвийн .../минут дуусав

Б.Найдалаа: Хосбаяр гишүүн тодруулчхаад хариулчих уу. Тодруулна биз дээ Хосбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Сангийн яамныхнаас тэгвэл асууя даа. Энэ бид нарт тарааж өгсөн төсвийн төсөл дээр 448 тэрбум төгрөгийн л хөрөнгө оруулалт ирэх жил санхүүжүүлнэ гэсэн байгаа. Тэгээд сайд болохоор сая дахиад 500 тэрбумаар 40 хэдэн сургууль барина гээд яг тийм гэрээ хэлцэл хийсэн юм уу. Энэ төсвийн төсөл дээр чинь тэгж нэмж сургууль барих юм ерөөсөө харагдахгүй л байна л даа. Тэгэхээр энийг бас нэг тайлбарлаад өгчхөөрэй. Тэгэхгүй бол бид нар боловсролын жил болгон зарлачхаад, бүх асуудлыг бас шийдчих юм шиг нийгэмд хүлээлт үүсгэчихээд, тэгээд яг хачир дээрээ ингээд 15 шинэ объект шинээр барина. Тэгээд ихэнх нь хуучин юмаа дуусгана, дуусах ч юм уу, үгүй ч юм уу одоо тэр нь тэгээд ийм байдалтай бас яваад байж болохгүй байх л даа. Тэгэхээр энэ дээр бас дорвитой хариулт өгсөн нь дээр байх гэж бодож байна.

Б.Найдалаа: Зөв зөв гишүүний асуулт бол зөв байна шүү. Боловсролын жил гэххээд яг хөрөнгө оруулалт юу яасан бэ. Сангийн яамнаас хэн байгаа билээ. Санжаадорж дарга яг саяын тоонуудыг тов тодорхой хариулаач. Юу нэмэгдсэн юм. Нэмэгдээд байгаа юм юу байгаа юм. 1 номерын микрофон өөрийгөө танилцуулаад хариултаа хэлнэ үү.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Тэгэхээр гадаад зээлийн ашиглалт талдаа Наранбаяр сайдын хэлсэн 1 их наяд 41 тэрбумын зөрүү нь бол гадаад зээлийн ашиглалт талдаа явж байгаа. Өөрөөр хэлбэл

гадаад зээлийн ашиглалт өөрөө Сангийн сайдын багц дээр нэгдсэн дүнгээр суугддаг. Гүйцэтгэл дээр нь үндэслээд бид нар гэрээ хэлэлцээр нь байгуулагдсан төслүүдийг ашиглалтыг нь гаргаад явдаг байгаа. Яг улсын төсвийн хөрөнгө оруулалт талдаа бол 448 тэрбум. Тэгээд түрүүний хэлсэн яг 2028 он хүртэл зорилтын хувьд бол ээлжийн коэффициентыг сургууль дээр 2, цэцэрлэг дээр 1,2 болгох энэ зорилтын хүрээнд 108 энэ сургууль, 95 цэцэрлэг гэдэг ийм хэрэгцээ гарсан. Тэгэхээр энэ дээр бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар яг хуулийн шаардлага дээр сүүлийн 2 жилийн зураг төсөвтэй яг бэлэн хэрэгжих боломжтой төслүүд, Азийн хөгжлийн банк талдаа бол 32 сургууль, 9 цэцэрлэг явж байгаа. Тэгэхээр энэ хэлэлцээр нь бол зөвшилцөхөөр Улсын Их Хуралд бол хүргүүлсэн байгаа.

Б.Найдалаа: Хосбаяр гишүүн сүүлийн тодруулга хийнэ.

Г.Хосбаяр: Наадах чинь зүгээр одоо нөгөө хэлэлцээр л хийгдэж байгаа болохоос биш яг 2026 онд баригдаж эхлэх юм биш шүү дээ. Тийм биз дээ. Эхлэх юм биш. Тэгээд энийгээ харин бас тодорхой хэлэхгүй бол нийгэмд хүлээлт үүсгээд л баахан сургууль, цэцэрлэг бариад эхэлчих юм шиг ийм ойлголт төрөөд бид нар бас гадаадын зээл, тусламжийн юмнуудыг чинь үзсэн л дээ. Тэгээд энэ чинь хэлэлцээрийн шатанд яваад л нөгөө өрийн тааз чинь тулчихсан учраас одоо шууд 2026 онд 41 сургууль барих юм байхгүй л юм шиг харагдаад байгаа. Тэгээд тэрийгээ хэлээрэй.

Мөн тэр сайдаас асуусан багшийн дутагдлыг нөхөх тал дээр хөрөнгө мөнгө тусгайлан тавьсан бас бодлогоор дэмжиж байгаа тийм юм байгаа юм болов уу. Тэрийг.

Б.Найдалаа: Гишүүн асуусан учраас Наранбаяр сайд тодруулаад, тэгээд дуусгая.

П.Наранбаяр: Энэ Азийн хөгжлийн банктai хийж байгаа энэ хэлэлцээ бол урьдчилсан шат нь яваад дуусчихсан. Тэгээд одоо Улсын Их Хурлаар энэ хэлэлцээг хэрвээ хэлэлцээр болгож баталж өгөх юм бол энэ 2026 ондоо эхэлчих төсөл гэж ойлгож байгаа. Энэ дээр Азийн хөгжлийн банк бол энэ дээрээ шуурхай ажиллана гэдгээ бидэнд илэрхийлээд байгаа. Энэ дээр бол яг 41 сургууль, цэцэрлэгийн барилгын жагсаалт юмнууд нь гараад, ингээд яригдаж байгаа ийм бодитой асуудал шүү гэдгийг хэлье.

Тэр багшийн дутлыг арилгах чиглэлээр багшийг дэмжих энэ хүрээнд бол бид бас өнөөдөр энэ Боловсролын зээлийн сан дээр багшийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудад тэтгэлгийг олгож байна. Тэд бол 5 жил заавал багшаар ажиллах үүрэг хүлээж суралцаж байгаа.

2 дугаарт нь болохоороо зэрэг бид бас багшийг 5 жил багшилсан багш нарыг богино хугацаанд гадаадад бэлдэх энэ хөтөлбөрөө хэрэгжүүлэх Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орчихсон ажил. Энийгээ хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Зулпхар гишүүн асуулт асууна.

С.Зулпхар: Бүгдэд нь оройн мэнд дэвшүүлье. Боловсролын хөгжлийг дэмжих жилийн хүрээнд 4, 5 асуулт байна. Сайдаас, бусад холбогдох албан тушаалтнуудаас.

Энэ багшийн цалинтай холбоотой асуудал их яригдлаа. Бид бас 2, 3 удаагийн уулзалт хийсэн. Үндсэн цалин тэрнээс гадна нэмэгдэл цалинтай холбоотой. Тэгэхээр гүйцэтгэлийн үнэлгээг бол нэмэгдэл цалин олгохтой холбоотойгоор олгодог. Тэгээд энийг бол бид үндсэн цалин руу нэг хэсгийг нь оруулах юм гэсэн ийм л ойлголт байгаа юм. Миний асуулт энэ гүйцэтгэлийн үнэлгээ боловсролын чанарыг жишээ нь нэмэгдүүлэхэд, багшийн хөгжлийг хангахад нөлөөлсөн үү гэдэг ийм асуулт байгаа юм. Хэрвээ нөлөөлсөн бол жишээ нь энийг та бүхэн цаашдаа яаж авч явах ийм бодолтой байна вэ гэсэн эхний асуулт.

2 дахь зүйл. Өнгөрсөн жил бас бид төсөв хэлж байх үед боловсролын салбарт шаардлагатай техник хэрэгслийг хангахтай холбоотой бас санхүүгийн арга хэрэгслийг санал болгоод, тэр маань хэрэгжээд явсан байх ёстой. Санхүүгийн лизинг гээд. Тэгэхээр энэ санхүүгийн лизинг төсвийн ийм хязгаарлагдмал боломжтой байгаа үед ирэх жил хэрэглэх боломжтой юу. Хэрэглэх үү. Энэ дээр салбарын яам ямар бодолтой байна. Мэдээж хэрэг энэ дээр бол төсөв санхүүгийн асуудал хариуцсан Сангийн яам бас энэ дээр ямар байр суурьтай байна гэсэн ийм 2 дахь асуулт байна.

2 тусдаа одоо тодорхой асуулт байгаа юм. Сайд өнгөрсөн уулзалтууд дээр бас хэлж байсан. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн биеийн тамирын заал байхгүй. Тэгээд энэ биеийн тамирын заалыг барихтай холбоотой хүсэлт явсан. Тэгээд энийг бол бид тодорхой түвшинд төсвийн өөрсдийн зохицуулалтаар бол хийх боломжтой юм. Асуудлыг нь шийднэ гэсэн ийм хариулт өгч байсан чуулган дээр. Энийг та бас ахиад судалсан байгаа байх. Энэ дээ дээр бидэнд бас хариулт өгөөч гэж байгаа юм.

2 дахь зүйл. Би нэг талаас Сангийн яамнаас бас давхар асууж байгаа юм. Бас Боловсролын сайд, Боловсролын яамныхан нь бас хариулна биз. Өнгөрсөн уулзалт дээр Сангийн яамнаас энэ Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын ЕБС-ийн дотуур байр байгаа юм. 100 хүүхдийн. Тэгээд 2024 оноос хойш шүүхийн маргаантай явж байгаад, тендерийн л маргаан л даа. Тэгээд тэр нь шийдэгдчихсэн байгаа боловч Сангийн яаманд бичиг очихдоо бол уг нь очсон. Сангийн яам болохоор зэрэг шүүхийн шийдвэр нь эцэслэгдээгүй гээд энийг төсөвт оруулаагүй, тусгаагүй гээд ийм юм явж байна. Тэгэхээр зэрэг энэ дээр 2 өөр хариулт авчихсан яваад байгаа юм. Тэгэхээр энэ хариултыг та бүхэн эцэслэж өгөөч. Энийг төсөвт нь суулгах чиглэлээр та бүхэн ажиллах боломжтой юу гэсэн ийм асуулт байна.

Дараагийн бас 5 дахь асуулт энэ цахим сургуулиуд их сайн ач холбогдлоо өгч байгаа гэж ойлгож байгаа. Нэн ялангуяа орон нутагт багш дутагдалтай байгаа нөхцөлд ахлах ангийн сурагчид тодорхой хичээлүүдийг цахим хэлбэрээр судлаад, сайн багшаар хичээлээ заалгаад, ингээд хичээл нь сайжирч байгаа гэж. Тэгэхээр энэ жил бол та сая хэлэхдээ миний ойлгосноор бол 30 гаруй мянган хүүхэд энд хамрагдах юм байна. Ирэх жилийн төсөвт суулгасан чинь залгаад 2026, 2027 оны хичээлийн жил рүү залгана шүү дээ. 2026-2027 оны хичээлийн жил эхлэхэд энэ цахим сургалтад хамрагдах хүүхдийн тоог та бүхэн хэрхэн үзэж байна вэ гэсэн ийм асуулт байна.

Яг эзнтэй уялдуулсан байдлаар сая бол яах вэ гишүүд асууж байна. Ийм цахим хэрэглээтэй холбоотой зардал өсчихсөн байна гэж. Өссөн байгаа нь сайн юм байна. Харин эсрэгээрээ бид бол хоцроогүй явж байна гэж би ойлгоод байгаа шүү дээ. Цахим жишээ нь сургалттай холбоотой бүх зардал мөнгийг хангалттай олгох гэж хичээсэн юм байна. Цаашдаа энэ зардал хэрхэн нэмэгдэх вэ. Энэ дотор чинь нөгөө интернэт ашиглаж байгаа дата байгаа байх. Тэрнээс гадна нөгөө цахим агуулгуудаа бэлдэхтэй холбоотой бас ийм ажлууд байгаа байх. Энэ хэр нэмэгдээд явах вэ гэсэн бас ийм асуулт байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Хариулт Наранбаяр сайдаас эхлэх үү.

П.Наранбаяр: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээрээ бид бас энэ гүйцэтгэлийн үнэлгээний сурлагын чанарт хэрхэн нөлөөлж байгаа асуудлыг та бас хөндөж байна. Ер нь бол гүйцэтгэлийн үнэлгээгээр 52 хувь нь бас үнэлүүлээд, 1-4 түвшинд бас авч байгаа. Нийт багш нарын. Тэгэхээр бид бас үзэхэд 2022 онд бол ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийн улсын дундаж нь 72,5 хувь, 2023 онд 75,9, 2024 онд 77 хувь гэж ингэж өссөн ийм үзүүлэлттэй явж байгаа. Бичгийн шалгалтын улсын дундаж гүйцэтгэл нь бол 2022 онд 51 хувь, 2023 онд 53 хувь, 2024 онд 54 хувь болж ингэж өссөн үр дүнтэй байгаа. Тэгэхээр тодорхой хэмжээнд сайн байна. Нөлөөлж байна гэж харж байна. Гэхдээ нөгөө талдаа бид энэ зохион байгуулалт дээр бас анхаарахгүй бол хэт төвлөрүүлж нэг дор хийдэг. Ингээд бас яг энэ асуудал дээр бас багш нар их бухимддаг ийм зүйлүүд байгаа учраас зохион байгуулалт тал дээр нь ялангуяа орон нутгийн боловсролын газрууд хамтрах, мөн сургуульд нь бас эрхийг нь шилжүүлэх гэх мэт олон ийм зүйлүүдийг бас давхар хийх ёстой гэж ингэж харж байна.

Санхүүгийн түрээсийг хэрхэн ашиглаж байгаа тухайд бол бид сургууль, цэцэрлэгийн хувьсах зардлын бүрэлдэхүүн болох нөхөн хангалтын зардлаар сургуулийн дотоод сүлжээг шинэчлэх, цахим анги бий болгох арга хэмжээг бол санхүүгийн түрээсийн үйлчилгээгээр авч байгаа. Тэгээд энэ бол одоо их үр дүнтэй гэж харж байгаа. Энэ жил бас энэ сандал ширээ дутаад ирэхэд бас санхүүгийн түрээсийг он дотроо бас хийх ийм Засгийн газрын тогтоол гаргаж ингэж бас ажилласан. Ер нь одоо ингээд ашиглалтад орж байгаа цэцэрлэг, сургуулийн барилга, цэцэрлэгийн барилгуудын байгаад байгаа ийм нөхцөлд бол байнгын ийм аргаар явах нь бас зүйтэй байна гэж ингэж харж байгаа.

Цахим сургуульд бид бас цааш нь өсгөх ийм бодлого барина. Энэ цахим сургууль бол үр дүнтэй нь бас харагдаад байгаа. Энэ мэдлээ сургуулийн контентыг ашиглаж сурсаар байгаад бас Стэнфордын их сургуульд сурсан тохиолдлыг ч мөн манай Улсын Ерөнхий сайд ярьдаг. Тэгэхээр зэрэг бид энэ цахим сургуулийн үр дүнтэй ашиглуулах тал дээр илүү их анхаарна. Энэ бол зөвхөн Монгол улсад биш бас хилийн чанадад байгаа Монгол хүүхдэд Монгол хэл, соёлоо сурах, Монголынхоо хичээлийг үзэж, энийгээ үнэмлэхжүүлж авах гэсэн олон талын ач холбогдолтой байгаад байгаа юм. Бид 2026 онд 1,7 тэрбум төгрөгийн төсвийг бол төсөвлөсөн. 2025 онд энэ бас буурч орж ирж байгаа нь бол зарим тал дээр бол мэдлээ цахим сургуулийн хэвийн үйл ажиллагааг хангахад бас зарим нэгэн бэрхшээлийг бий болгож байна гэж харж байна. Бид ер нь цаашдаа энэ хүүхдүүдэд нийтдээ 2025 онд 5,1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор өнөөдөр төсөвт тусгаад/минут дуусав/

Б.Найдалаа: Тодруулгыг тодруулга хийснийх нь дараа больё. Өөр асуултууд юу байлаа. Наранбаяр сайдад минут нэмж өгье. Та товчхон тодорхой шууд хариулаарай.

П.Наранбаяр: За тэгье. Уучлаарай. Тэгээд энэ юуны тухайд бол Цэнгэл сумын энэ асуудал байгаад байгаа. Цэнгэл сумын энэ зураг төсөв, юмнууд нь орж ирэх нь 2 дугаар сургуулийн Баян-Өлгий аймгийн Цэнгэл 2 дугаар сургуулийн спорт заалны магадлал гарч ирсэн нь бол хуулийн хугацаанаас хоцорсон байсан. Ийм болчхоод байгаа. Юуны хувьд бол тэр нөгөөх нь Баяннуурын дотуур байрны төсөл 2024 оны төсвийн тухай хуульд туссан байсан. 2025 оны төсвийг хэлэлцэж байх үед бол гүйцэтгэхчээд болоогүй байсан учраас энэ төсвөөс нь хасагдсан ийм нөхцөл байдалтай байгаа. Тэгэхээрээ төсвийн хязгаарт нэн тэргүүнд сургууль, цэцэрлэгийн төсөл арга хэмжээ эрэмбэлэгдэж байгаа гэсэн. Энэ утгаараа өнөөгийн байдлаар төсөлд бол багтаагүй байна. Гэхдээ ярилцах шаардлагатай гэж харж байна.

Б.Найдалаа: Зулпхар гишүүн тодруулна.

С.Зулпхар: Сангийн яам ч гэсэн бас тодорхой 2 асуулт дээр нэмэлт тайлбар өгөх байх гэж бодож байна. Наранбаяр сайд аа, өнгөрсөн бидний уулзалтаар ярьсан шүү дээ. Тэртээ, тэргүй жишээ нь биеийн тамирын хичээлийн хөтөлбөр чинь хэрэгжихгүй байгаа, хэрэгжих ямар ч боломжгүй байгаа ийм асуудлыг тухайлан авч үзье гэж. 2 дугаарт бол энэ бичгийг над руу явуулсныг би уламжилсан. Хэзээ очих ёстой байсан бол тэр хугацаанд нь. Надаас гадна 3 гишүүн гарын үсэг зурсан байгаа юм.

Тэр Баяннуур сумын асуудал бол зүгээр 2 талд 2 өөр мэдээлэл яваад байгаа учраас энийг та бүхэн бас нэгтгээд бас бидэнд тодорхой ойлголт өгөөдхөөч ээ гэж байгаа юм. Үнэхээрийн тэр шүүхийн шийдвэр нь эцэслэгдсэн болоод та бүхэн төсөв дээр нь тавьж чадаагүй юу. Эсвэл эцэслэгдээгүй байна уу гэдэг ийм зүйл байгаа байхгүй юу. Бидэнд нэг өөр мэдээлэл ирчихсэн байгаа учраас энийг тодруулж өгөөч гэж байгаа юм.

Б.Найдалаа: Наранбаяр сайд юм уу, эсвэл яамных юм уу. Яг энэ дээр тов тодорхой хариулчихмаар байгаа юм Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Надад ирсэн мэдээллээр бол түрүүнд хариулсан ийм хязгаар дотроо байгаа. Тийм учраас манай Хөрөнгө оруулалтын газраас хариулах хүн байна уу.

Б.Найдалаа: Хэн бэ. Нэрээ хэлээрэй. Хаана байгаа билээ. Тэгвэл та яг тодорхой эргээд явуулчих юм уу. Тусад нь уулзаад хариултаа өгөх юм уу. 2 дээр очоод суугаарай. Хаана байгаа билээ? Хүн байна уу, байхгүй байна уу.

П.Наранбаяр: Энэ танхимд бол зөвхөн манай Төрийн нарийн бичгийн дарга байна.

Б.Найдалаа: Тэгвэл Наранбаяр сайд Зулпхар гишүүнд хариултаа тодорхой.

П.Наранбаяр: Тэгвэл энийг би дараа нь бичгээр бүр тодорхой хариулъя.

Б.Найдалаа: Тэгээрэй. Зулпхар гишүүн болсон уу. Баярлалаа. Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Би 3 тогтолцооны шинжтэй асуулт асуучихъя гэж бодож байна. Одоо бид нар энэ тэтгэвэр нэмэх, тэтгэврийн зээлийн хүү бууруулах, тэтгэврийн сангийн тухай нэлээн тойрч яриад байгаа. Солонгос, Япон нэлээд олон улсад бол тэтгэврийн зээлийг банкаар дамжуулж хүүтэй өгдөггүй, олгодоггүй. Тэтгэврийн институт өөрөө хөгжсөн байдаг. Тэтгэврийн институт рүү тэтгэвэрт гарсан тухайн улсын иргэн 1 удаа тэтгэврийн урьдчилгаа авах эрх үүсдэг. 12-24 сарын урьдчилгаа авдаг. Энгийнээр бодох юм бол 800 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа хүн 2 жилийнхээ дүйцэхүйц урьдчилгааг онцгой нөхцөлд аваад, дараагийн сарын тэтгэвэр нь 800 мянга нь 700 мянга болж буугаад явдаг ийм юм руу орчихсон л доо. Хүмүүнлэг хэлбэр лүү. Манайх бол тэтгэврээ өндөр хүүтэйгээр зээлж авдаг ийм сонин тогтолцоотой. Тэгэхээр ийм тогтолцоонд шилжих боломж байхгүй юм уу. Яагаад заавал бид нар ийм тэтгэврийн зээлийн хүүг 1, 2 хувиар бууруулах гэсэн юм яриад байгаа юм бэ. Нэгмөсөн суурь шинэчлэл хийх боломж, бололцоо юу байгаа юм бэ гэж асууя.

2 дугаарт энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг дундыг дэмжих сан, Монгол улсад ингээд л газар тариаланг дэмжих сан, арьс ширний татаас гээд маш олон зээл татааснууд өгдөг. Ер нь үр дүн ямаршуу түвшинд гардаг юм бэ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, ЖДҮ-лэлийг дэмжих сантайгаа хэрхэн холбогддог юм бэ. Энэ сангууд гэдэг чинь мөнгө арвижуулах биш тусгай данс болчихлоо. Сайд болгон ийм тусгай данс эзэмших гэдэг уралдаан руу яваад Монгол Улс 22 ийм тусгай данстай. Тэгээд хэдэн ЖДҮ-лэл, өрхийн үйлдвэрлэл хөнгөлөлттэй зээл аваад, бойжоод, томоохон аж ахуйн нэгж болоод, экспорт хийгээд, ажлын байрыг бий болгож байгаа юм бэ гэдэг дээр тайлан судалгаа их хомс юм. Энэ дээр хариулж өгөөч.

3 дугаарт нь Сангийн яамнаас асуусан нь зөв юм уу. Энэ шилэн данстай холбоотой ойлголт сүүлийн жилүүдэд сулраад байдаг. Ингээд Шилэн дансыг ягштал мөрддөг байсан, ил тод байсан. Одоо бол тааллаараа мөрдөж байна. Тэгээд төсвийг иргэд хяналт тавих, мэргэжлийн байгууллага хяналт тавих, хэвлэл мэдээллийнхэн хяналт тавих тэр нээлттэй байдал дээр Сангийн яам хэр анхаарч ажиллаж байгаа вэ гэсэн ийм 3 асуултыг асууя.

Б.Найдалаа: Сангийн яам хариулна. 8 дугаар микрофон. 9 юм уу. 9 дүгээр микрофон.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Шилэн дансыг бол Сангийн яам хариуцаж ингэж хэрэгжүүлдэг байгаа. Тэгээд шилэн данстай холбоотой бид хуульд заасан нууцын зэрэглэлтэйгээс бусад бүх гүйлгээнүүд шилэн данс дээр бол цахимаар орж байгаа. Энэ рүү хэн ч орсон үзэх бол нээлттэй. Бид бол явцаа улирал тутам Засгийн газарт танилцуулдаг. Тэгээд шилэн дансны хөтлөлтийг бол бас Үндэсний аудитын газраас бол давхар бол хяналт тавьдаг байгаа. Тэгээд үүнтэй холбоотой Шилэн дансны хангалтгүй хэрэгжүүлж байсан төсвийн захирагч нарт бол арга хэмжээнүүдийг нь аваад, зөвлөмж байдлаар хүргүүлээд бол явж байгаа.

Б.Найдалаа: Хариулт болсон уу. 3 асуулт байсан даа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 5 номер Мөнхзул дарга.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул. Гишүүний асуултад хариулъя. 2026 оны төсөв дээр тэтгэврийн сангийн нийт зарлагын хэмжээ 5,9 их наяд. Хэрвээ тэтгэвэр авагчдын тэтгэврийг 18-24 сараар урьдчилан олгох бүх нөхцөлийг жигд хангана гэвэл 5,9 их

наяд төгрөг маань 1,5 дахин нэмэгдэнэ л гэсэн үг. Бусад улсуудад ер нь энэ тэтгэврийг орлого болгож барьцаалдаг зүйл байх уу гэдэг ийм асуудал байдаг. Улсуудын хөгжлийн шинж чанараас хамаарч харилцан адилгүй байдаг. Тэтгэврийн зээлийн хүү бол өндөр. Тэтгэвэр гэдэг маань үндсэндээ өөрөөр хэлбэл цалин авахаа болиод, хувь хүний цалин авч байх үеийн хэрэглээг хэвийн хадгалахын тулд шаардлагатай орлогоор л хангах ёстой. Хүн болгон сар бүр заавал тэтгэвэртэй байх ёстой ахмад настан..../минут дуусав/

Б.Найдалаа: Тодруулчхаад хариулах уу. Хариултаа гүйцээе. Нэмэлт минут. 5 номер.

Л.Мөнхзул: Шууд товчхон хариулахад бол 1 дүгээрт зарлагын үр дагавартай. 2 дугаарт яг хөдөлмөрийн чадвараа алдчихсан тэтгэвэр авагчдын хувьд, эсвэл өндөр настан, ахмад настны хувьд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор 1 удаа төлбөртэй тусламжид хамрагдах зорилгоор 1-3 сарын тэтгэврээ зээл гэлгүйгээр, хүүгүйгээр тэр тэтгэврийнхээ институцээс урьдчилан авах тийм кэйсүүд зарим оронд байдаг. 18-24 сар гэдэг бол би мэдэхгүй. Монгол Улсад ч гэсэн 2017 онд энэ арга хэмжээг туршиж үзэж байсан. Өөрөөр хэлбэл аргагүй нөхцөл байдлын улмаас гадаадад эмчилгээнд явах, орон нутгаас хотод эмчилгээ хийлгэх энэ тохиолдолд 1-3 сарын хугацаанд зөвхөн хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн хувьд урьдчилан авах энэ бололцоог бол тэтгэврийн даатгалын сангаас хангаж болдог. Гэхдээ тэтгэврийн даатгалын сан биеэ даасан тохиолдолд. Өнөөдөр бол тэтгэврийн даатгалын сан бас биеэ дааж хараахан чадаагүй л байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Хариулт болсон уу. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тайлан. Номер 3.

З.Бауыржан: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар Бауыржан. Гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн байдлаар 2026 онд 117 тэрбум төгрөг төсөвлөчихсөн байгаа. Өнгөрсөн жил бол 130 тэрбум төгрөг төсөвлөгдөж, зарцуулчихсан. Энд бол төсөл хөтөлбөртэй холбоотой олон арга хэмжээнүүд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнүүд, энийг бол хөдөлмөрийн биржүүдээр хамтарч зохион байгуулах ажлууд, ур чадварын сургалтууд, цогц арга хэмжээнүүд тогтмол хийгдээд явж байгаа. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, залуу малчин, малжуулах хөтөлбөр гэх мэтчилэн шилдэг start up, орчин үеийн залуучуудын инновацад тулгуурласан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн ажлууд, мөн ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мөн ажил олгогчдыг бас дэмжих чиглэлийн.../минут дуусав/

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя 3 номер.

З.Бауыржан: Хийгдээд явж байгаа. 2026 оны байдлаар давтамжтай тоогоор бол нийт 152 мянган иргэн хувиараа хөдөлмөр эрхлэгчид бичил бизнес эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагууд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөөд явж байгаа юмаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Баатархүү гишүүн тодруулж асууя.

Ц.Баатархүү: Та хэдийн ажлыг үгүйсгэх гээд байгаа юм биш шүү. Ер нь зүгээр бид нар яг ингээд 30 жилээ үнэлэхэд дэлхийн улс орнууд 30 жилийн хугацаанд ДНБ 1 хүнд оногдох нь бол 10 мянган доллар даваад байгаа. Монгол Улсыг 1992 оноос хойш тооцоход бол ДНБ тэр хөгжиж байгаа орны хэмжээнд хүрэхгүй байна л даа.

Тэгэхээр бид буруу яваад байна. Буруу менежмент хийгээд байна. Тэгэхээр энэ менежментээ өөрчлөхийн тулд оношоо зөв тавих хэрэгтэй байна л даа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг буруутгасангүй. Энэ сангийн үр дүн яг хаана байна вэ гэхээр ерөөсөө тодорхой зүйл байхгүй. Бид нар ингээд ирээдүй цаг дээр яриад байдаг. Тэгэхээр одоо энд байгаа хүмүүсийг ерөөсөө буруутгахгүй байна. Энэ сан чинь боловсролынхоо бодлоготой, тэр ЖДҮ-ийн бодлоготой, тэр үндэсний аж үйлдвэрийн бодлоготойгоо яаж уялдах юм бэ. Гал унтраах маягаар яамнууд ажиллаад байна. Гал унтраах маягаар төсвөө хуваарилаад байна.../минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Баатархүү гишүүн үг хэллээ. Галбадрах гишүүн асуулт асууна.

Ж.Галбадрах: Оройн мэнд хүргэе. Цаг ч нэлээн явсан байна. Нэлээн хэдэн асуулт асууя гэснээ ер нь товчилъё. Энэ гишүүдэд маань ч гэсэн энэ бодлогын чанартай юм энэ улс орон ер нь яаж хөгжих юм бэ гэдэг асуудлыг яриад байна. Тэгээд бид нар энэ улс орон хөгжихийн үндсийн үндэс нь боловсрол учраас л ирэх жилийг боловсролын жил болгож зарлуулсан байгаа. Зарласан байгаа. Тэгээд нэлээн хүлээлт ингээд байж байна. Тэгээд энэ Их Хурлын үед бол маш олон гишүүд маань боловсрол ярьдаг. Бүгдээрээ туршлагатай ийм хүмүүс байж байна. Миний хувьд бол яг одоо Япон Улсын боловсролын хамгийн сайныг нь оруулж ирээд, бас Монголдоо хувийн сургууль дээр нэвтрүүлээд, тэрийгээ төрийн сургууль дээр бас оруулаад ингээд яваад ирсэн хүний хувьд бол газар дээрх байдлыг харж байгаад л энэ тооцооллуудыг хийсэн юм байгаа юм. Тэгээд хүлээлт бол нэлээн байсан. Тэгээд энд хүрэхгүй байна. Тэгээд энэ 108 сургууль, 95 цэцэрлэг түрүүн Наранбаяр сайд бол бас дутуу хэлээд байна. Энэ бол яах гэж энийг 2028 он хүртэл 3 жилийн дотор бид нар эд нарыг барьж чадах юм бол хөгжлийн төлөвлөгөөнд бол бүр 45 сургууль, 45 цэцэрлэг сууна гээд маш их баярлуулж байсан. Тэгээд төлөвлөгөөтэйгөө ингээд зөрөөд ороод ирдэг. Түрүүн манай Хосбаяр гишүүн асуугаад байна. Тэгээд энийг хийснээрээ юу болох юм бэ гэвэл одоо энэ яригдаад байгаа 50, 60, 70 хүрээд байгаа энэ 1 ангид байгаа хүүхдүүд энийг л 40-өөс доош оруулах 1 сургуульд нь 5, 6 мянган хүүхдээс давчихсан дэлбэрээд байгаа сургуулиудыг л бид нар 1800 дотор нь барьж байж ингэж байж бид нар сургалтын чанар ярих тухай яригдана. Сургалтын чанар ярьж байж тэр хөгжлийн төлөвлөгөө л яригдана. Өнөөдөр сургууль гэдэг бол сургууль биш болчихоод байна. Тэгээд энийг хийх нь бол шинээр барих хөтөлбөр нь энэ. Харин насжилттай холбоотой юм уу, өмнө нь барьж байсан, өргөтгөл хийх тэр асуудал нь бол тэр явдаг жамаараа явах ёстой. Энэ нь бол ингээд тусдаа хийгдээд явах ёстой. Энэ жил тэр Азийн хөгжлийн банкны зээл орж ирж байж л энэ маань орж ирлээ шүү дээ. Хэрвээ ороогүй байсан бол яах вэ гээд түрүүн бас Хосбаяр гишүүн бас асуугаад л байна. Энэ зээл гэдэг бол бас бид нар тийм их хүсээд байх биш ийм чухал зүйлийг бид нар улсын төсвөөрөө хийж байх ёстой.

Тэгээд багшийн хомсдолыг арилгах талаар яг тодорхой юу вэ гэхээр оюутанд тэтгэлэг өгөөд л явж байгаа гэхээсээ илүү энэ бол бодлогоор бид нар одоо ажиллаж байгаа багшаа чанаржуулах гэдэг. Зүгээр л багшийг тоогоор бөглөх биш, чанартай багш гэдэг л их чухал. Самбарын өмнө багш байлаа гэдгээрээ бас бүх юм шийдэгдэж байгаа юм биш. Тэр багшийг яаж чанаржуулах вэ, хөгжүүлэх вэ гэдэг асуудал байгаа юм.

Тэгээд би зүгээр нэг юм асуух гээд байна. Бид нар одоо орлогын эрэлд гарчихсан байна шүү дээ. Боловсролын салбарт мөнгө оруулъя гэхээр орлого хаанаас, орлогын эх үүсвэр хаана вэ гэж байна. Жишээ нь нэг юм байсан. Коп-ын барилга гээд яриад байгаа. Өнгөрсөн жил 50 тэрбум байснаа энэ жил бүр даруй 3

дахин өсөөд 150 тэрбум болсон. Тэгээд энэ жилдээ 2026 ондоо бүтэн 150-ыг нь хэрэглээд явна гэж байгаа. 67 тэрбумын тоног төхөөрөмж орно гэж байгаа. Энэ бол олон улсын хэмжээнд амлаад ингэсэн юм байна. Тэгэхдээ л тэр зардал нь 1 жилийн дотор хойшлоход 3 дахин өсдөг нь ямар учиртай юм. Иймэрхүү төсөл хөтөлбөрүүд хэр их байгаа юм. Энийг ингээд шүүгээд гаргаад өгөхийг би Сангийн яамнаас бол хүсэж байна. Энийг ингээд харж байгаад бас дараа нь анализ хийе.

Тэгээд дараагийн 1 зүйл бол бид нар 100 тэрбум төгрөгөөрөө багшийн ачааллыг тооцон цалинд зарцуулна гээд байгаа. Энийг хэрхэн зарцуулах гэж байгаа юм гэдгийг Боловсролын яамнаас асууя. Тэгээд бид нар бодлогын асуудлуудыг энэ төсөвт орох ёстой. Ахлах сургуулийг төрөлжүүлнэ гэж ярьдаг. Тэгээд одоо яаж тусаж байгаа юм бол. Бүс нутгуудад коссен техникийн коллежуудыг барина гэсэн. Үүний төсөв өнгөрсөн жил жоохон мөнгө байсан. Энэ жил бүр ор тас байхгүй байна. Энэ талын асуултыг асууя.

Б.Найдалаа: Хариултыг Сангийн яам өгнө. 9 номер уу. Сангийн яамнаас асуусан даа. 1 номер. Нэрээ хэлээрэй.

Ж.Дэлгэржаргал: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Одоо яг сургуулиудын ээлжийн коэффициентыг харахаар Улаанбаатарын яг дундаж ээлжийн коэффициент бол 1.94 хамгийн өндөр нь. Аймгуудыг болохоор хамгийн бага Завхан 0,9, цэцэрлэгүүдийн хувьд бол хамгийн өндөр нь Хөвсгөл, хамгийн бага нь Дундговь, Улаанбаатар магадгүй цэцэрлэгийн хувьд бол 14-д байгаа. Тэгэхээр яг энэ 108 байршил, 95 цэцэрлэгийн хувьд бол дунджаасаа дээгүүр буюу тухайн сургуулиуд дээр 2-оос дээш ээлжийн коэффициенттой байж байгаа байршлууд байгаа. Тэгэхээр төсвийн хөрөнгө оруулалтын хувьд бол яг бид нар хязгаартаа суурилад хуулийн яг бэлэн байдал буюу яг төсөв батлагдаад худалдан авах ажиллагаа зарлаад хэрэгжих боломжтой сургууль, цэцэрлэгүүдээ төлөвлөсөн. Бусад хэрэгцээ шаардлагаа хангах дээр бол Азийн хөгжлийн банкны ийм хөнгөлөлттэй зээлээр 41 сургууль, цэцэрлэг төлөвлөсөн байгаа.

Коп-ын арга хэмжээний хувьд бол энэ жил 2025 он дээр байгаа 50 тэрбумын хувьд бол энэ хурлын зохион байгуулах дэд бүтэцтэй холбоотой барилга байгууламжийн зөвхөн дэд бүтэц нь 50 тэрбум байгаа. Ирэх оны 8 дугаар сард энэ олон улсын хурал зохион байгуулагдана. Нийтдээ 10 мянга гаруй төлөөлөгч нар оролцоно. Энэ хуралтай холбоотой байгууламжийн зардал нь дангаараа 150 тэрбум байгаа. Тийм угсардаг байгууламж байдаг. Тэгээд олон улсын өмнө хүлээсэн үүрэг гэрээнийхээ хүрээнд бол энэ хөрөнгө оруулалтыг үндэсний хорооноос ирсэн саналынх нь дагуу хянаж тусгасан байгаа. 2025 он дээр бол яг 50 тэрбум байгаа. Энэ он дээр тэр нь бол яг тэр байгууламжийн дэд бүтэцтэй холбоотой. Ирэх он дээр тавигдсан 150 тэрбум нь бол байгууламж, нийтдээ ингээд 200 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нь бүтээн байгуулалт, дэд бүтэц дээр нь тусгагдсан гэсэн үг.

Б.Найдалаа: Галбадрах гишүүн тодруулах уу. Тодруулчих. Тэгээд нэмээд хариултуудаа авчихъя. Галбадрах гишүүний микрофон.

Ж.Галбадрах: Зөндөө л юм тодруулмаар байна. Гэхдээ Дэлгэржаргал даргад бол баярлаж байгаа. Сангийн яамныхандаа, бас Боловсролын яамныхандаа их сайн суусан бид нар бол. Тэгээд сууж сууж эцсийн дүнд юу гараад ирчихээр л гомдолтой байгаад байгаа юм. Түүнээс муу ажиллаад байна гэж байгаа зүйл бол биш. Их тооцоолол дээр их сайн суугаад, эрэмбэ тогтоогоод ингээд явсан. Тэгээд

ахиад энэ дээр нэг юм хэлчихэд ээлжийн коэффициент хамгийн их нь 1.94 гэж байна. Энэ худлаа шүү. Би 1 жишээ хэлье. 14 дүгээр сургууль 6100 хүүхэдтэй. 14 дүгээр сургууль. Энэ жил хэд болсныг би мэдэхгүй байна. Өнгөрсөн жил байсан. Тэгэхдээ энэ 1500-аад хүүхдийн л багтаамжтай сургууль. Тэд нарыг 2 ээлжээр орно гээд бодохоор 3 мянга болгож байгаа. Тэгээд тэрнээсээ ахиад үзэхээр л 3 мянга гэдэг нь өөрөө 2 байхгүй юу. 1500 чинь цаашаага 2 болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд тэр чинь 2-оор ярих юм байхгүй, бүр 4, 5, 6 болох гээд байгаа юм. 2 ээлжийгээ 100 хувь гэж үзээд байдаг. Энэ байхгүй. 1 ээлжийгээ 100 хувь гэж авч явж энэ дээр их цочмоор тоог гаргаж ирэх ёстой. 1,94 биш. 3 байна гэж ээлжийн .../минут дуусав/

Б.Найдалаа: Энэ асуулт биш, үг байна. Тодруулж асуусан юм байгаа билүү. Тэгвэл дахиад 1 минутаа авчих уу. Галбадрах гишүүнд тодруулах сүүлийн 1 минут өгөөд, тэгээд хариултаа авъя.

Ж.Галбадрах: Түрүүн Боловсролын яамнаас асуух гээд байгаа нь бодлогын чанартай зүйл, ахлах сургуулийн төрөлжүүлэлд гэдэг их сайхан энэ бодлого бид нар яриад явж байсан. Энэ хэр туссан юм. Өөр нөгөө талаас нөгөө бүс нутгуудад технологийн коллежууд буюу коссен барина гээд Улаанбаатарт байгаа гурвыгаа Эрдэнэт, Өмнөговь, Дархан гээд 3 сургууль болгосон. Ахиад дараа нь үргэлжлүүлээд бид нар чинь ер нь бол энэ 15 коссен байгуулна гэсэн зорилт тавьсан байсан. Энэ рүү чиглэсэн хөрөнгө оруулалт юу байгаа юм. Тэгээд сургуулийн бие даасан байдал гэдэг бол их чухал. Энэ бие даасан байдлыг нь өөрөөр хэлбэл менежментийг нь сайжруулах, тэр багш нарынх нь ур чадварыг нь дээшлүүлэх талын энэ бодлогын ийм хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалт гэхээсээ илүү тийм төсөв мөнгө хэр сууж байгаа вэ гэдгийг асууя. Баярлалаа.

Б.Найдалаа: Хариултыг Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээр эхний бас асуултад байсан. Бид бол 45 сургууль, 45 цэцэрлэг шинээр барина гээд улсын төсвийн төлөвлөгөөнд нь бол оруулчихсан. Энийгээ бас харахаар яг энэ 45-аас 36 нь бол яг одоо орж чадсан гэж хэлж болно. Үүнээс 32 нь бол зээлээр, 4 нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах энэ дотор орж ирсэн. Тэр юуны тухайд бол бид бас 100 тэрбум төгрөгийн цалин нэмж байгааг хэрхэн нэмж байгаа юм бэ гэхээр бид бас 1 ангид суралцах хүүхдийн тоо хэтэрсэн буюу ачаалал ихтэй ажиллаж байгаа багшид хувьсах зардлаар дамжуулан нэмэгдэл хөлс олгох замаар 100 тэрбум төгрөгийг нэмж олгохоор тооцсон. Тэгэхээр энэ бол багш нарын хувьд бас нэлээн цалингийн нэмэгдэл болж чадна гэж харж байгаа.

Коссен төрөлжсөн ахлах сургуулийн тухайд бол бодлогоо бид чиглэлээ гаргачихсан. Үүнтэй холбоотойгоор .../минут дуусав/

Б.Найдалаа: Нэмэлт 1 минут Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Үүнтэй холбоотойгоор бүсчилсэн хөгжилтэй уялдуулаад таны хэлсэн энэ юунууд бол явж байгаа. Тэгэхээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолборыг төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна гэсэн энэ бодлогын хүрээнд явж байгаа. Тэгээд өнөөдөр бас Өмнөговь аймаг дээр бол Оюутолгой компанитай хамтраад анхны ТЭЗҮ нь бол гарч байгаа. Хангайн бүс дээр бол хангайн бүсийн АШУҮИС-ийн Сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолбор явж байгаа. Коссен бол өнөөдөр ингээд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 3 коссеныг бид ямар ч байсан дэмжлэгээ

үзүүлээд, статусыг нь бие даасан байдал руу оруулж ингэж явж байгаа. Үүнээс хойшоо цаашаа бол бид төрөлжсөн ахлах сургуулиуд, ялангуяа мэргэжлийн чиглэлээр хүүхдээ бэлддэг ийм сургуулиудыг бол төсөв дээрээсээ хувьсах зардлаар нь дэмжээд явах ийм бодлого барьж байгаа юм. Япон Улсын Засгийн газарт бол мянган инженер бэлтгэх энэ төслийн 2 дугаар шатыг бол тавиад .../минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Минут дууслаа. Дараагийн гишүүн Бум-Очир гишүүн асуулт асууна.

Д.Бум-Очир: Боловсролын сайдаас асууя. Нэлээд олон багш нарт Боловсролын яам маань өртэй яваад байдаг. Нөгөөдөх нь он дамжих гээд хавар, зун дамжаад ингээд нөгөө гүйцэтгэлийн үнэлгээгээ авах багш нар маань авч дууссан юм уу, дуусаагүй юм уу. Авъя гээд л яриад байх юм. Зөндөө л гишүүд, багш нар яриад байх юм. Хэзээ өгч дуусгах юм бэ. Би одоо дуусаж байгаа болов уу гэж бодоод байсан, аваагүй багш нар байгаад байх шиг. Элсэлтийн шалгалтад ажилласан багш нар мөнгөө авч чадаагүй байна гэдэг юм бас яриад байх юм. Үнэн юм уу, худлаа юм уу. Арай ч багш нар худлаа ярихгүй байлгүй. Багшийн туслах хийнэ гээд баахан багш нар цуглуулаад нийт хэчнээн ч билээ дээ асуулт, хариулт боловсруулаад ингэсэн. Тэрэнд хав хавар бас багш нар, хүмүүс ажилласан. Одоо болтол мөнгөө аваагүй байна гэдэг ийм зүйл яриад байх юм. Энэ багш нартаа, амьдрах гэж ядаж байгаа хүмүүстээ ажиллуулчихаад мөнгө төгрөгийг нь даруйхан шийдээд өгөх боломж, бололцоо байдаггүй юм уу. Ямар учиртай юм бэ. Ажиллуулсан бол мөнгө төгрөгийг нь өгөөч гэдгийг хэлмээр байна. Энэ дээр Боловсролын сайдаас хариулт авмаар байна.

Соёлын яам соёлын сайд байхгүй байх шиг байна. Бид нар өмнө нь бас ярьсан. Энэ Соёлын өвийн хамгаалал гэж нэг чухал ажил байдаг юм. Тэгээд 5,1 тэрбум байсан. Энэ жил 202 сая тавигдсан. 1 настай хүн соёлын өвлөн уламжлагч өв тээгч гэж бид нар хэлдэг. Тэр хүн бурхан болоход тэрэнтэй хамт юугаар ч хэмжишгүй их хэмжээний соёлын өвийн зүйл үгүй болж, устаж байдаг юм шүү. Одоо төсөв хэцүү байна гээд хамгийн түрүүнд соёлынхоо салбараас хасдаг. Энэ соёлын өвийн бодлого дээрээ яах юм бэ. Тэгээд цаашдаа хасаад яваад байх юм уу. Төрийн нарийн нь байх шиг байна. Энэ дээр илүү болгоомжтой анхааралтай хандмаар байна. Цаашид ялангуяа биет бус соёлын өвийг хамгаалах тал дээр Соёлын яам илүү их ажил хиймээр байна.

Нөгөө хар авдарт ном бий, хазгар өвгөнд эрдэм бий гээд байдаг энэ хазгар өвгөчүүд чинь дууслаа. Дууслаа. Тэгээд өнгөрсөн хойно нь бид нар юугаараа, яаж тэр хүмүүсээ босгож ирж энэ өв соёлын зүйл, эрдэм мэдлэг юмнуудыг энэ соёлын өвийн зүйлсээ хадгалж авах юм. Цусаар уйлаад яагаад ч нэмэргүй болно шүү дээ. Тэгээд соёлын өвөө ч мэдэхгүй, юугаа ч мэдэхгүй хэдэн орчин цагийн нөхдүүд үлдэнэ. Энэ дээр анхаармаар байна.

Дараагийн нэг зүйл би бас чуулган дээр хэлж байсан. Энэ Юнескод ном бичих тухай ажил яригдчихаад хэдэн жил болж байгаа. Уг нь бол Боловсролын яам дээр байсан ажил. Гэтэл нөгөө яам салаад Эдийн засаг, хөгжлийн яам руу явсан юм болов уу гэж би ойлгосон. Үгүй юм шиг байна. Одоо Гадаад яам руу ч явж байгаа бололтой. Юнескогийн үндэсний комисс байдаг. Тэр дээр ч мөнгө нь тавигдах гээд байгаа юм уу. Ингээд Юнеско номоо нэхээд байдаг. Нүүдлийн соёл иргэншлийн тухай ном бичнэ гээд очоод Ерөнхий Ассамблейн хурал дээр нь амлалт авчихсан. Энх-Амгалан сайдын үед шиг санагдаж байна. Тэгээд нөгөө номыг нь бичих

чадалтай улс орнууд, тэр мөнгийг нь гаргачих чадалтай улс орнууд бидний хөрш зэргэлдээ байж байгаа. Өв соёлоо булаацалддаг, түүхээ булаацалддаг, тэгээд энийгээ уг нь дархлаад авмаар байгаа юм. Тэр хэдэн төгрөгийг нь тавьж өгөөд, тэр номыг нь бичүүлчих юм сан даа. Одоо тэгээд олон улс даяар ингээд шившгээ дэлгээд байцгааж байна шүү дээ. Энэ дээр мэдэж байгаа, хариуцаж байгаа газар байна уу. Миний бодлоор одоо бараг хариуцах эзэнгүй болоод тэр чигтээ явах шиг болж байна. Ийм асуудлууд дээр хариулт авъя.

Б.Найдалаа: Баярлалаа. Наранбаяр сайдаас эхэлье. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Энэ гүйцэтгэлийн үнэлгээ дээр бол бид нийтдээ 2,3 тэрбум төгрөгийг олгочихсон. Элсэлтийн шалгалтад ажилласан хүмүүсийн 1,7 тэрбум төгрөг байгаа. Энийг нь бол санхүүжилтийнхээ хуваарийг гаргаад, яамны зүгээс бол бүрэн олгоод явчихсан байгаа гэдгийг хэлье.

Өнөөдөр энэ багшийн туслах дээр бол ажилласан хүмүүсийн 380 орчим сая төгрөг байсан байх. Ноднин жил байсан. Тэрийг нь бол олгоод явсан байх ёстой. Энийг би тодруулаадахъя. Энэ бол яг одоо над дээр мэдээлэл нь алга байна. Зүгээр ер нь багшийн туршлагатай холбоотойгоор ярихад Google бол маш сайн ийм багшийн туслах болох ийм хиймэл оюун ухааныг хөгжүүлсэн байгаа. Тэгээд манай улс өөрсдийнхөө хиймэл оюун ухааныг хөгжүүлнэ гэсэн өөрийн стратегитай болж байгаа. Энэ хүрээндээ бас бид багшийн туслахыг цаашид дэмжиж явах шаардлагатай. Гэхдээ хөрөнгө оруулалт бол үнэхээрийн өндөр юм байна лээ. Анхных нь хөрөнгө оруулалт бол манай салбар бол дийлэхийн аргагүй ийм өндөр байдаг юм байна лээ.

Б.Найдалаа: Баярлалаа. 6 дугаар Соёлын яам Даваацэрэн дарга асуулт тов тодорхой, тоотой дүнтэй байсан шүү дээ. Та бас тов тодорхой, тоотой дүнтэй шууд хариулаарай. 6 дугаар микрофон.

Б.Даваацэрэн: 2026 оны төсвийн төсөлд нийтдээ 5,1 тэрбум төгрөгийг соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах зориулалтаар төсвийн төсөлд хүргүүлсэн. Одоогийн байдлаар бол төсвийн төсөл дээр 202,1 сая төгрөг хуваарилагдаад явж байгаа. Гишүүдтэй бол санал 1 байна. Соёлын өвийг хадгалж хамгаална гэдэг бол соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, ашиглах, сурталчлах гээд цогц ажил байдаг. Бидний өмнө тавигдаж байгаа, хүлээгдэж байгаа үр дүнд хүрэхэд одоогийн байгаа төсөв бол хаанаа ч хүрэхгүй нь ойлгомжтой.

Тийм учраас бид байгаа нөөц бололцоо, олон улсын хамтын нийгэмлэгийн байгууллагуудтай хамтарч ажиллах, олон улс 2 талт хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр зарим нэг арга хэмжээгээ хэрэгжүүлээд явж байгаа гэдгийг хэлье. Дээр нь жил бүр зохион .../минут дуусав/

Б.Найдалаа: Бум-Очир гишүүн тодруулаад, тэгээд ноднин хэд байсан юм та бодож байгаарай. Ноднин хэд байсан юм соёлын өв дээр. Энэ жил 220 байж. Ноднин хэд байсан юм 5 тэрбум байсан юм уу, 300 байсан юм уу. Бум-Очир гишүүн тодруулна.

Д.Бум-Очир: Бас 1 зүйл ярья. Түрүүн Мөнхтуяа гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаад унаж байх шиг байна. Зам энэ тэр барих болохоор бонд энэ тэр гаргаад л хэчнээн тэрбумаар нь босгоод л барьчих юм. Тэгээд багш, эмч нарын

цалин нэмэх болохоор яг үнэнийг хэлэхэд хөдөлж өгөхгүй байна гэдэг дүгнэлтэд хүрэхээс өөр аргагүй болж байгаа байхгүй юу. Тэгээд мөнгөгүй гэдэг ийм хариултыг бид нар удаа дараа сонсож байна. Бүр болохгүй бол тэр бонд энэ тэрээ гаргаад хүний хөгжил гэж нэрлэнэ үү, юу гэж нэрлэнэ үү, бонд гаргаад тэндээсээ зээл авч байгаад багш, эмч нарынхаа цалинг нэм л дээ. Тэгээд эргээд төлчихдөг л юм байна лээ. Зам бариад тэр зам бол эргээд мөнгө өгөхгүй шүү дээ. Харин хүний хөгжилдөө бид нар мөнгө зарцуулчих юм бол тэр чинь эрүүл мэнд дээр, боловсрол дээр, ёс суртахуун дээр, улсын хөгжил дээр маш том хөрөнгө оруулалт болно. Эсвэл ийм шийдэл рүү явъя л даа. Ийм боломж байдаг юм уу үгүй юу. Хэн гаргах ёстой юм энэ саналыг нь. Засаг хийх ёстой юм уу. Хэн хийх ёстой юм.

Б.Найдалаа: Хариулах хүн байна уу. Энд хариулах хүн байхгүй байх шиг байна. Даваацэрэн дарга аа та түрүүнийхээ юуг хэлээдэх үү. Өнгөрсөн жил соёлын өвийг хамгаалах дээр хэдэн төгрөг байсан юм. Яг тэрийгээ л хэлчих дүнг нь. 6 дугаар микрофон.

Б.Даваацэрэн: Өнгөрсөн жил 432 орчим сая төгрөг байсан. Гүйцэтгэлээр бол 800 орчим сая төгрөг зарцуулсан байгаа.

Б.Найдалаа: Ойлголоо. Дараагийн гишүүн Ганбаатар гишүүн асуулт асууна.

А.Ганбаатар: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Ерөнхий сайд хүн бол мега төсөл гээд зарласан, тунхагласан. Тэгээд одоо зарим нэг төсвийг харахаар хүн бол мега төсөл биш сега тоглоом шиг болчих гээд байна. Тухайлбал 2024 онд Соёл, спорт, аялал жуулчлалын салбартаа 145 тэрбумыг зарцуулж байсан юм байна. Одоо бол 52,8 гээд 3 дахин багасаад ороод ирсэн. Энэ нь болохоороо нийгмийн зөөлөн хүчийг хангаж байдаг хүний хөгжлийг дэмжиж байдаг ийм салбарууд соёл, спорт, аялал жуулчлал, залуучууд гэж байгаа. Тэгээд хүнийхээ төлөө хүнээ бодлогоор дэмжих энэ салбарын төсвийг ямар аймаар танасан юм бэ. Тэгээд энэ салбарын төрийн нарийн, газрын дарга нар сайддаа хэлж энэ төсвөө хамгаалдаггүй юм уу. Тэгээд энэ чинь зөөлөн хүчний бодлогоо хийдэг энэ салбар, эко системээ бүрдүүлдэг энэ салбараа хүн бол мега төсөл гэж зарлачхаад тэгээд бүгдийг нь танаад хаячихаар чинь яах юм. Тэгээд барилга бариад суугаад байх юм. Тэгэхээр энэ хүнийхээ төлөө энэ төсөв дээр ерөөсөө ямар ч бодлого бариагүй байна. Тухайлбал хэдэн юм хэлье.

Залуучуудын салбарынх нь төсөв дээр 5 тэрбум тавьчихаад 90 хувийг нь хасаад хаячихсан юм байна. Тусгай олимп гэж бид нар мэднэ. Хүн иргэн эхээс төрсөн байдлаараа үл ялгаварлан гадуурхагдах ёстой. Үл ялгаварлагдах ёстой. Гэтэл энэ төсвийг нь бүгдийг нь хасаад хаячихсан. Тусгай олимп, энэ байгууллагаас нь бол зөндөө гомдол тавьж байна. Тэгээд энэ залуучууд гар утастай холбогдоод энд донтож байна. Тэгээд цахим залиланд их хамрагдаж байна гэж байгаа юм. Гэтэл энэ цахим кибер аюулгүй байдалтай тэмцэх 4 тэрбум гэж байдаг юм байна. Эндээс 90 хувийг нь хасчихсан байна. Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих бусад спортын төслөөс төсвөөс бас 90 хувийг нь хасчихсан. Түүхэн дурсгалаа хамгаалах төсвөөс 5 тэрбум байсныг бүгдийг нь хасчихсан юм байна. Тэгээд түүхэн дурсгал гэдэг чинь өв тээгч сая энэ Бум-Очир гишүүн энэ тэр яриад байна. Энэ бүх асуудал чинь 100 жилээр дараа нь босож ирэхгүй шүү дээ. Нэгэнт ингээд устчих юм бол. Тэгээд энийгээ хасаад хаячихсан. Тэгээд төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс энэ төсөв зарцуулалтаа зөв эрэмбэлээрэй гэж байсан. Энийг бол бүрэн алдсан байна. Хүний хөгжлийнхөө салбарт бол энэ төсвөө бол тусгаагүй байна. Тэгээд энийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд дэмжээд буцаж босгох гэдэг юм уу ийм боломж байдаг юм уу. Сангийн яам дээр боочихсон гэж

байгаа учраас энэ буцаж босоход төвөгтэй юм байна. Энэ бодлого алдагдахаар чинь яах юм бэ.

Түрүүн Мөнхтуяа гишүүн хэлээд байсан. Боловсролын салбар боловсролоос 1 их наяд хасагдсан байна гээд. Аргентины Ерөнхийлөгч гарч ирээд цомхон засаг, хямгатай төсөвтэй явж байгаа боловч 85 хувиа боловсрол, эрүүл мэнд гэсэн зөөлөн бүтэц рүүгээ оруулсан байгаа байхгүй юу. Тэгэхээр манай засгийн бодлого хүний хөгжлөө дэмжиж байна уу, яаж байна. Эрхэм төрийн нарийн, мэргэжилтнүүд яаж зөвлөж байгаа юм бэ. Энийг буцааж босгох боломж байна уу, үгүй юу гэж одоо салбарыг төлөөлөөд би асууя даа. Одоо сайд нь ярихгүй, салбарынхан нь ярихгүй учраас.

Б.Найдалаа: Эндээс асуулт байгаа билүү Ганбаатар гишүүн. Тэд нараас асуулт байгаа билүү. Соёлын яамнаас хүний хөгжлийн төсвийг ингэж танаж болж байгаа юм уу. Хамгаалж болоогүй юм уу. Өөр юу байлаа. Хариулт. Эхлээд 6 дугаар микрофон. Тэгээд 9 дүгээр микрофон. 6 Даваацэрэн дарга Соёлын яам.

Б.Даваацэрэн: 2026 оны төсвийн хязгаар 553,9 тэрбум төгрөгөөр батлагдсан. Соёлын яамнаас 561,6 тэрбум төгрөгийн саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл дээр 500,6 тэрбум төгрөг болсон өргөн мэдүүлсэн төсвөөс 61 тэрбум хасагдсан байгаа. Бид бол холбогдох хууль тогтоомж, төсвийн хязгаарт нийцүүлж, төсвийн саналаа бэлтгэж хүргүүлсэн. Сангийн яаман дээр хянаад 500,6 тэрбум болгож, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа.

Б.Найдалаа: Микрофон 9. Сангийн яамнаас Ганбат дарга.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Бид энэ жил төсвийн тодотголыг хийсэн байгаа. Ингэхдээ төсвийн орлогыг 3,3 их наядаар, зардлыг 2 их наядаар эмч, багш нараас бусад төрийн албан хаагчдыг бид нар 9 хувь цомхотгоод ийм тодотгол хийсэн. Цаг хугацаа бол амаргүй байсан. Одоо бол бас тодорхой бус байдал бүрэн арилаагүй, нөхцөл байдал бас тийм амаргүй байна. Энэ оны эхний 8 сарын байдлаар төсвийн орлого 800 гаруй тэрбум төгрөгөөр тасарчихсан. Тодотгол хийсний бууруулсны дараах яг байдлаар ч гэсэн бас 800 гаруй тэрбум төгрөгөөр буурчхаад байна. Энэ оны хүлээж байгаа гүйцэтгэл хэрвээ нөхцөл байдал цаашаа үргэлжилбэл бас 1 их наяд орчмоор төсвийн орлого буурах нөхцөл байдал үүсэж байна. Бид энэ жил 2025 болон 2026 онд төр бол ер нь хэмнэж бол бүх зардлуудыг хэмнэж байна. Тэгэхээр энэ хүрээндээ л энэ асуудлуудыг авч үзсэн. Бид төсөв бололцоотой байсан бол..../минут дуусав/

Б.Найдалаа: Нэмж хариулъя 9 номер.

Ж.Ганбат: Ийм байгаа. Энэ хүрээндээ бид бол боловсрол, эрүүл мэнд дээр 2026 оны төсөв Улсын Их Хуралд өргөн барьсан төсөв дээр боловсрол, эрүүл мэнд дээр анхаарсан. Ард иргэдийн саналыг цахимаар болон биетээр авч энэ төсвийг бол энэ жил анх удаа хэлэлцүүлгийг хийхэд нэлээн өргөн хүрээнд саналыг авч нэгтгээд, тэр эрэмбэлсэн зардал дээр бол эхний ээлжид боловсрол, эрүүл мэнд, хүний хөгжил дээр анхаарах ёстой юм байна гэдэг ийм олон нийтийн дүгнэлт гарсан. Энэ дагуу боловсрол, эрүүл мэнд дээр боломжийнхоо хүрээнд бол ингэж авч үзэж, эрэмбэлж оруулж ирсэн байгаа. Тэгэхээр үүнийг бол бид юу гэдэг юм мөнгө нь байгаад соёлын салбар дээр анхаараагүй бол биш. Бас яг тодорхой орон зайныхаа хүрээнд яг өнөөдөр байгаа нөхцөл байдлынхаа хүрээнд тооцож ингэж оруулж ирсэн байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Энэ дээр бас би Ганбаатар гишүүний асуултад хариулчихъя даа. Хариулах ч гэж дээ ерөнхийдөө зүгээр бид нар бодож байгаа, ярьж байсан зүйлс байгаа. Яг Байнгын хорооны эрх, үүргийн хүрээнд бас гишүүдийн эрх, үүрэг хуулиар заасан хүрээнд нь бас ярилцъя гэсэн тодорхой санал байгаа. Яг мэргэжлийн Байнгын хороо яг энэ салбарууд дээр алин дээр нь илүү саяын тэр алдагдсан зүйлсийг залруулах нь бидний үүрэг. Энийг бас жич ойрмог ярья гэж бодож байгаа. Одоо энд яриад дэмий байх. Тодорхой шийдлүүд бол бас байгаа. Та тодруулах уу Ганбаатар гишүүн. Ганбаатар гишүүн тодруулж асууна.

А.Ганбаатар: Яах вэ тодруулах юу байх вэ дээ. Гол нь хүн байхгүй, хөгжсөн хүн байхгүй, эрүүл чийрэг ийм иргэн байхгүй бол хэчнээн байшин сав, мега төсөл, гудамж талбай, гүүр яах юм, эзэнгүй л балгас болно шүү дээ. Тэгэхээр бид нар энэ чиглэл рүүгээ ерөөсөө төсөв рүүгээ тавихдаа дандаа нөгөө хүнээсээ хасдаг сэтгэлгээгээр хассан байна. Байшин босгох ёстой. Дотор нь амьдрах гараад юу гэдэг юм нийгэмдээ хувь хүн болох, бие хүн болох иргэнээ ерөөсөө бодоогүй байна л гэж хэлэх гээд байгаа байхгүй юу. Тэгээд боломж байдаг бол би Байнгын хорооныхоо даргаас л асууя. Найдалаа даргаас. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо гэж байгаа шүү дээ. Нэрээр ерөөсөө яг энэ дээр анхаарал тавих ёстой. Тэгээд энэ 30 гишүүн асуудлаа тавиад, болдог бол төсвийн тодотгол гэдэг юм уу эсвэл энэ 2, 3, 4, 5 дахь хэлэлцүүлэг дээр босох боломж байдаг юм уу л гэж байгаа юм. Би ийм кэйс бол мэдэхгүй. Гэхдээ ийм боломж байна уу, үгүй юу.

Б.Найдалаа: Боломж байгаа. Тэгээд тийм болохоор хэдүүлээ бас тусад нь уулзаж ярилцана. Хаана нь юу нэмэх хэрэгтэй байна, хасах хэрэгтэй байна. Яг бодлогын зарчмын алдаа байгаа бол тэрийг нь зарчмын зөрүүтэй санал дараагийн шатны хэлэлцүүлгээр орох боломжтой байгаа. Тэр дээр зөвхөн 1 гишүүн гарах биш, олуулаа ярилцаж байгаад, шүүж байгаад тэгээд бодлогын чанартай юмыг дэмжих, тэгээд төсвийн эх үүсвэр нь хаанаас авах юм бас ярилцах зүйлс байгаа. Сангийн яамтай ч бас ярилцана. Ер нь яамнуудтай бүгдтэй нь ярилцана. Харин зүгээр яамнууд маань, сайдууд маань өөрсдийнхөө асуудлыг ийм төсвийн хэмжээнд биш, аж ахуйн хэмжээнд биш, бодлогын хэмжээнд бид нарт сайн ойлгуулах хэрэгтэй байна. Өнөөдөр яг үнэндээ бол энд зарим сайд байхгүй байна. Асуултад хариулах сайд байхгүй байна шүү дээ. Гишүүд Их Хурал сайд нарыг томилсон, Ерөнхий сайдыг томилсон. Тэр хүмүүс улс төрийн бодлогоо авч явна уу гэхээс биш яг төрийн нарийнаас доошоо төрийн албан хаагчид бол яг тэр аппаратаа л ажиллуулж байгаа шүү дээ. Институт ажиллаж байгаа. Тэр дээр бодлогын шийдэл байх ёсгүй. Жишээлбэл Аубакир сайд яг нийгмийн даатгалын шинэтгэлийн тогтолцоонд шинэтгэл ийх юм уу, үгүй юу гэдгийг Аубакир сайд мэднэ үү гэхээс биш өөр хүн мэдсэн ч гэсэндээ ярих тийм эрх боломж байхгүй. Тэрийг хийхгүй бол бид нар тэтгэвэр нэмж чадахгүй. Тэтгэвэр нэмэхийн тулд тэрийг ярихаас өөр аргагүй. Ярихын тулд асуухаас өөр арга байхгүй. Тийм болохоор хэдүүлээ дараа нь жич ярина. Өнөөдөр энэ анхны хэлэлцүүлэг болохоор ингээд асуулт, хариултын хүрээнд сайд нарыг нэг их айхтар шахсангүй. Хариулт аваад явчихлаа. Тэгээд энийг жич Ганбаатар гишүүн дахиад ярья. Тодорхой санал байгаа. Энд ярихаар хурлын хэлэлцэх асуудалд ороогүй бөгөөд дээр нь бас жоохон цаг үе утгаа олоогүй байна. Жич ярилцъя. Энэ дээр маш их боломж байгаа. Одоо надад жишээлбэл тодорхой төсөөлөл байгаа юм. Ярилцана. Тэрийг хэдүүлээ ярья. Шийдэл нь яг ямар шийдвэр байх юм. Тэр бол шийдлүүд, хувилбарууд хуулийн дагуу байгаа. Одоо Ганхүлэг гишүүн асууна.

М.Ганхүлэг: 2026 оны 10 сарын 1-ний өдөр олон улсын бас ахмадын өдөр бас байгаа. Тэгээд бас нийт ахмадууддаа Байнгын хорооны хурал дээрээс бас

мэндчилгээ дэвшүүлээд, манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд нийгмийн салбар бүлгүүд, тэр дундаа ахмадууд руу чиглэсэн төсөв арга хэмжээг тодотгож асууя. Эндээс асуултаа эхэлье.

2026 онд ахмадуудад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ энэ чиглэлийн ажлууд ямар байх вэ. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаман дээр бас тодорхой ямар саналууд байна. Соёлын үйл ажиллагаа ямаршуу байна. Мөн дээрээс нь насан туршийн боловсрол түүнтэй холбогдолтой бас юмнууд бас байна уу гээд манай Байнгын хороонд харьяалагдаж байгаа харьяа яамнууд бас энэ чиглэлээр бас албан ёсны мэдээлэл өгөөч гэж асуултаа эхэлье.

Үндсэн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой би бас яг Байнгын хорооныхоо нүдээр харахаар энэ удаагийн төсөв дээр бас анхаарах зүйлүүд бас нэлээн байгаа юм. Гишүүдтэйгээ би бас санал нэг байна. Манай Байнгын хороо Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо гэдэг ийм бас нэршилтэй концепттой болсон. Тэгээд ер нь сахил хүртээд шал дордов гэгчээр нэр усаа өөрчлөө, тодорхой концепцоо шинэчлээд, өөрчлөлт гарахгүй байгаа ийм байдлууд дээр бас жоохон санал нийлэхгүй бас байгаа юм. Манай байнгын хороо дотроо 2 дэд хороотой. Миний бие Соёл, спорт, залуучуудын асуудал хариуцсан дэд хороог ахалж байгаа. Соёлын асуудал дээрх төсөв сая бас гишүүд маань бас хэллээ. Өмнөх 2, 3 жилүүдээс хэд дахин буурчихсан. Залуучуудын асуудлын төсөв бүх бүхэл бүтэн Монгол Улс дийлэнхийг бүрдүүлж байгаа энэ залуучууд руугаа чиглэсэн 1 жилийн маань төсөв 200 сая төгрөг. Тэгээд соёлын өвийг хамгаалах энэ чиглэлийн ажил 200 сая төгрөг. Одоо 2-ын хооронд ийм мөнгө тавьж байхаар бараг тавиагүй нь дээр хэмжээний төсөв орж ирж байгаа учраас энэ яг хүний хөгжлийн, нийгмийн бүлгүүдийг дэмжих ийм төсөв мөн үү гэдэг дээр бид нар бас бодох зайлшгүй шаардлага гарч байна гэдэгтэй би бас санал 1 байгаагаа илэрхийлье. Сая ерөнхий бас тайлбарууд бол авлаа.

Дахиад би нэмээд хэлье. Мега том төсөл хүний хөгжлийн тухай асуудал яриад боловсролыг дэмжинэ гэдэг тухай ярьж байгаа хэр нь Боловсролын сайдын энэ багц төсөв маань 1,3 хувиар буурсан байдалтай орж ирж байгаа юм. Тэгээд яг бид нар уриа гаргах байдаг юм уу, эсвэл ингэж нэрлэхээ болих ёстой юм уу. Ойлгохгүй байгаад байна л даа. Боловсролын салбарт сая хичээлийн шинэ жил эхлэхэд хүртээмжийн тухай асуудал бол хамгийн номер нэгд яригдсан. Тэгээд би бас салбарын яамнаас асуухаар коэффициенттой нэг мэдээлэл өгөөд ингээд ойлголтын хувьд бол бас тийм бүрэн мэдээлэл авч чадахгүй байна. Ирэх 2026 оны төсөв боловсролыг дэмжих ийм төсөв юм бол яг ямар үр дүнг энэ салбарт гаргах юм бэ гэдэг дээр та бүхэн маань тодорхой бас хариултыг өгөөч ээ.

Багш нарын цалин нэмэгдэх гэхээр болохгүй гээд байгаа юм. 1 ээлжийн байдаг юм уу, ядаж 2 ээлжийн болгоё гэхээр бас боломжгүй гээд байгаа. 108 сургууль, 120 сургууль хэрэгтэй гэхээр одоогийн байгаа төслөөр бол 60 сургууль шинээр барина. 27200 хүүхдийн асуудал байна гэдэг ийм төсвийн тухай бид бүхэн яриад байгаа юм. Тэгэхээр энэ боловсролыг дэмжих жилийн хүрээнд тодорхой хүртээмж, цалин хөлс, энэ реформын шинжтэй байдаг юм уу, суурь асуудлуудаа ер нь шийдэж чадахгүй юм байна. Тэгэхээр яг юуг шийдэх гэж бид бүхэн анхаарал хандуулж байгаа вэ гэдгийг би тодотгож, энгийн үгээр бас иргэдэд ойлгогдохоор тайлбарлаж өгөөч ээ гэдгийг бас хэлье.

Боловсролын зээлийн сантай холбогдолтой асуудал дээр би бас өмнөх Байнгын хорооны хамгийн сүүлийн тогтоол болгож гаргуулсан байгаа. Зээлийн сан

дээр хэдэн төгрөг тавигдаж байна. Ямар зохион байгуулалтаар явж байна вэ гэдгийг бас .../минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Наранбаяр сайд хариулах уу. Наранбаяр сайдын микрофон.

П.Наранбаяр: Энэ жил боловсролыг дэмжих жилийн хүрээнд чухам яг төсөв нь юу болчхов гэдэг дээр бас тодорхой хариулт өгөх шаардлагатай байна. Тэгэхээр үүний хувьд бид ноднин 2025 оныхоо төсөв дээр бол нийт мөнгөн дүнгээрээ 4 их наяд 263 тэрбум төгрөгийн төсвийг бид төсөвлөж оруулж байсан байна. Энэ жилийнх бол түрүүнд өгсөн янз бүрийн тоонууд, бас гишүүдийн хэлээд байгаа тоо нь бол Азийн хөгжлийн банкнаас оруулж ирж байгаа 590 тэрбумыг нэмж тооцоогүй, тэр нь энэ нөгөө зээл учраас Сангийн яаман дээрээ Сангийн сайдын багц руу орчихсон учраас ингээд байна. Тэрийг нэмж тооцсон дүнгээр нь би хэлье. Тэгсэн энэ тохиолдолд бол 4 их наяд 803 тэрбум 148 сая төгрөг болж ингэж ойролцоогоор 600 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ийм төсөв орж ирж байгаа юм. Тэгээд энэ бол ДНБ-үүд эзлэх хувь нь 4,7хувь, улсын төсвийн зарлагад эзлэх хувь нь бол 14,6 хувь болж ингэж орж ирсэн ийм төсөв. Яах вэ, эндээсээ жишээлбэл бид ямар үр дүнг хүлээж байна вэ гэдэг энэ асуудал дээр бол ээлжийн коэффициентыг бууруулж, ингээд ээлжийн коэффициент буурснаараа сурлагын чанар өснө гэсэн ийм үр дүнгүүдийг бид хүлээж байгаа. Ер нь бол ээлжийн коэффициент 0,03 функтээр буурснаар бол сурлагын амжилт бол 2 нэгжээр нэмэгдэх боломжтой талаар ийм урьдчилсан тооцоолол гарчхаад байгаа. Ийм нөхцөл байдалтай байгааг танд хэлье.

Боловсролын зээлийн сангийн тухайд бол бид бас Улсын Их Хурлаас гарсан тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өнөөдөр Боловсролын зээлийн сан бол нийтдээ ноднин жилийн байдлаар 269 тэрбум төгрөгийн авлагатай байсан. Энэ жил бол 261 тэрбумын авлагатай явж байгаа. Ноднин жилээс эргэн төлөлт бол сайжирсаар байгаа. Үүний 1 гол шалтгаан нь бол гадаад, дотоодын зээлд хамрагдсан гэх нь хамаагүй, бүх хүнийг бол Монголбанкны нөгөө бүртгэлд оруулдаг болсноор зээлийн эргэн төлөлтүүд сайжирч эхэлсэн. Бид бас өнөөдрийн байдлаар бол 13 тэрбум төгрөг эргүүлэн төлүүлсэн ийм нөхцөл байдалтай явж байна. Цаашдаа энэ зээлийн эргэн төлөлтийг сайжруулах дээр бол онцгой анхаарч ажиллана. Энэ дээр бас соён гэгээрүүлэх нь их зүйтэй байгаа юм. Зээлээ эргэн төлж байна гэдэг бол дараа үедээ зориулж тэтгэлэг болж байна гэдэг ийм сайн өвийг үлдээж байна гэдэг энэ зүйлийг зээл авсан хүмүүс маань сайн ойлгож, өөрсдөө бас төлөх шаардлагатай байна гэдгийг хэлье.

Б.Найдалаа: Баярлалаа. Өөр хэнээс асуусан билээ. Ахмадын асуудал. Микрофон 5. Нэрээ хэлээд явахгүй бол тэмдэглэлд орно.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичиг Мөнхзул. Гишүүний асуултад хариулъя. 2026 оны төсөвт ахмад настанд нийт Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад 270,9 тэрбум төгрөг зарцуулагдахаар төсөвлөгдсөн. Үүнд Нийгмийн халамжийн сангаас 543 мянган ахмадад 250,5 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж өгнө. Хөнгөлөлт тусламж. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2000 гаруй ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж 11,7 тэрбум, улсын төсвөөс ахмад настны асрамжийн үйлчилгээнд 8,7 тэрбум төгрөг зарцуулна. Түүнчлэн нийгмийн даатгалын сангаас өндөр настны тэтгэвэр гэсэн зориулалтаар 4,9 их наяд төгрөг бас зарцуулна. Ингээд ахмад настанд зарцуулах Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсвийн дүн бол 5 гаруй их наяд болж байна.

Б.Найдалаа: Эрүүл мэндийн яамнаас асуулт байсан. Тийм ээ. Чинбүрэн сайд хариулах уу. Чинбүрэн сайдын микрофон.

Ж.Чинбүрэн: Ахмадын тухай хууль батлагдаад 2025 оноос хэрэгжээд эхэлсэн. Бас эрүүл мэндийн салбарт 1 амжуулж хийж чадсан зүйл бол ахмадын геронтологи гэж нэрлэдэг ахмад судлалын эмнэлэг баригдаад дуусаад, ашиглалтад авахад бэлэн болчихсон 60 ортой эмнэлэг байж байгаа. Мөн Ахмадын үндэсний зөвлөгөөн энэ 10 сард багтаад хийхээр Геронтологийн төвтэй хамтраад хийх гэж байна. Тэгэхээр гол нь бол чанартай урт наслах гэдэг энэ том бодлого 10 сард хийгдэнэ. Үндэсний зөвлөгөөн. Дараагийн асуудал бол ахмадуудад чухал зүйл бол хорт хавдар өвдөх эрсдэл байдаг учраас эрт илрүүлгийн тогтолцоог илүү сайн болгож, хорт хавдраар өвдөх эрсдэлийг бууруулах илүү оновчтой эрт илрүүлгийн тогтолцоог 10 сарын дундаас шинэ хөтөлбөр хэрэгжиж эхэлнэ. Үүгээрээ дамжуулаад бид ахмад настнуудад элбэг тохиолддог хорт хавдруудыг эрт үед нь..../минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Ганхүлэг гишүүн тодруулах билүү. Даваацэрэн дарга. 6 номер.

Б.Даваацэрэн: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад 2026 онд нийтдээ 59,8 тэрбум төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардал одоогоор явж байгаа. Тэгээд энэ зардалд тохируулга хийгээд бид соёл, спорт, залуучуудын чиглэлийн хууль тогтоомж, бодлого шийдвэрүүдийн хэрэгжилтийг сүлжээгээрээ дамжуулж, тогтолцоогоороо дамжуулж ард иргэддээ хүргэнэ. Энэ дунд бол ахмад настнууд хамт ороод явна. Мөн залуучууд ороод явна гэж хэлье.

Б.Найдалаа: Баярлалаа. Бас байгаа юу. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Насан туршийн боловсролын тухайд бол бид бас бүх аймгууддаа насан туршийн хөгжлийн төвүүдийг тэгээд захаас нь байгуулаад ингээд явж байна. Тэгээд энэ дээр бол их идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг төвүүдээр нь явахад бол үнэхээрийн хүрч ажиллаж байгаа юм. Ахмадууддаа хүрч байна. Мөн ахмадууд очиж тэнд суралцсанаараа өөрсдөө бас илүү амьдралын эрч хүч, илүү их идэвхтэй болж байна. Ийм зүйлүүдээр нь бид энд хөтөлбөр талаас нь дэмжээд явна. Хөтөлбөр талаас нь илүү дэмжээд явна. Одоо насан туршийнхаа төв дээр зориулдаг төсвүүдээ бол энэ жилийн төсөвт ч гэсэн оруулж ирсэн байгаа. Энийгээ дэмжээд явна. Баярлалаа.

Б.Найдалаа: Ганхүлэг гишүүн тодруулна.

М.Ганхүлэг: Төсвийг нийгмийн бүлгүүдийн талаас нь бид бүхэн бас харж дүгнэх хэрэгтэй байгааг бас энэ саяын ахмадын асуултаар харуулъя гэж бодсон юм. Залуучуудын нүдээр харах юм бол үнэхээр хэцүү ийм төсөв бол байгаа. Саяын ярьж байгаа асуудлыг, бас ингээд хэлэхэд ер нь хэлэх зүйлүүд бас их бага байх байх гэж бодож байна. Энэ чиглэлээр бол цаашдаа бид бүхэн анхаарах ёстой гэдгийг дахиад сануулъя.

Боловсролын зээлийн сан дээр яг хэдэн төгрөг тавигдаж байгаа вэ. Хэчнээн зээлийг дотоодын болон гадаадын зээлдэгч нарт олгох вэ. Энэ хувь хэмжээ ер нь цаашдаа ямар бодлого барих вэ гээд ингээд нэлээн нарийвчлах юмнууд бас байгаа юм. Энийг та бас нэлээн дэлгэрүүлж өгөөч ээ. Эргэн төлөлттэй холбогдолтой асуудал дээр бас тодорхой журмуудыг бас гаргаад зохицуулъя гээд ялангуяа хуулийн байгууллага эргэн төлөлтийн тодорхой хувийг аваад ажиллах ийм журмууд

бас явж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ асуудал Сангийн яам дээр байна уу, Боловсролын яаман дээр байна уу. Хэрвээ тэгвэл бас эх үүсвэр илүү/минут дуусав/

Б.Найдалаа: Наранбаяр сайд товчхон, тодорхой хариулаарай.

П.Наранбаяр: Боловсролын зээлийн сан дээр бол 120 орчим тэрбум төгрөгийг тавьж, үлдсэн 30 орчим тэрбум төгрөгийг эргэн төлөлтөөсөө авна гэсэн ийм зорилго тавьдаг. Эргэн төлөлтийн тухайд бол сүүлийн 4 жилд 2021 онд 0,4 тэрбум, 2022 онд 0,7, 2023 онд 7 тэрбум байна. 2024 онд 30 тэрбум төгрөг баталснаас 14,6 тэрбумыг улсын төсөвт төвлөрүүлсэн ийм нөхцөл байдалтай байна. Ер нь бол нийт гарсан зээлүүдийн бараг 75 хувийг зөвхөн гадаадын зээл нь эзэлж байгаа. Яагаад гэвэл гадаад зээлд бол асар үнэтэй сурдаг ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа. Тэгэхээр бид бас энэ эргэн төлүүлэхийн тулд ямар механизмыг ашиглаж байна гэхээр түрүүнд хэлсэнчлэн Монголбанканд бүх мэдээллийг явуулсан. Түүний зэрэгцээ соён гэгээрүүлэх ажлыг явуулж байна. Мөн түүний зэрэгцээ араас нь ярих, сануулах, мөн гэрээ байгуулж хуулийн компаниудад хандах гэх мэт ийм ажлуудыг зохион байгуулж байгаа болно..../минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Гүйцээж хариулъя Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Ер нь бол хуулийн байгууллагуудад бид мэдээллийг хүргүүлж, тэнд тендер зарлаж, эргэн төлүүлэх ийм ажлуудыг эхлүүлж байгаа. Мөн Улсын ерөнхий прокурорын газар, бусад И-монголиа цахим системтэй хамтраад бол зээлээр суралцсан 15 мянга гаруй иргэнд бол 2 удаа зээлийн мэдэгдэл хүргэх ажлыг зохион байгуулсан. Ер нь бол зээлийн эргэн төлөлт ороод ирчихсэн тохиолдолд энийг нөгөө төрийн сан руу шууд аваад захиран зарцуулалт дээр нь бол нэлээн тийм хүндрэлтэй тал үүсдэг. Тийм учраас энийг уян хатан байхаар ЖДҮ эд нар шиг шууд үйл ажиллагаандаа зарцуулаад явах ийм боломжийг бий болгох тал дээр бас бид анхаарах шаардлагатай байна гэж харж байгаа. Тэгэхгүй бол яг хүүхдүүдийн тэр авч байгаа оюутнуудын энэ зээл нь заримдаа цагтаа орохгүй ийм тохиолдлууд нэлээн гараад байгаа ийм нөхцөл байдалтай байгаа юм.

Б.Найдалаа: Баярлалаа. Гишүүд асуулт тавьж, хариулт авч дууслаа. Одоо Монгол Улсын 2026 оны төсвийн төслүүдтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу. Нэрсээ оруулаарай. 4 гишүүн байна. Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Ганхүлэг гишүүнээс эхэлнэ.

М.Ганхүлэг: Манай Байнгын хороо 2026 оны төсвийг бол нэлээн ул суурьтай авч үзэх ёстой гэдэг энэ саналыг та бүхэн маань их сайн анхаараарай. Яг одоо зорилгыг маань хангах гэж байгаа юм шиг хэр нь байгаа төсөл нь бол шал өөр байгаа ийм дүр зураг бас ажиглагдаж байгаа шүү гэдгийг бас хэлье. Цаашдаа бол залуучуудын төсөв дээр, соёлын өвийг хамгаалах чиглэлийн төсөв дээр зайлшгүй анхаарах ийм саналтай байгааг хэлье. Харьяа яамнууд, ажил хариуцсан албан хаагч нар маань ямар санал байж болох вэ гэдэг дээр бас илүү нарийвчилж гишүүдэд бас мэдээлэл өгч ажиллахыг хүсье.

Боловсролын зээлийн сан тэргүүтэй 7, 8 асуудал дээр Нийгмийн бодлогын байнгын хорооны хамгийн сүүлийн шийдвэрээр бид бүхэн бас залуучуудыг дэмжих чиглэлийн хүрээнд тогтоол гаргасан юм. Энэ тогтоолын хэрэгжилтийг цаашдаа нэлээн одоо бас шахаж ингэж ажиллана.

Боловсролын зээлийн санг яриад байгаа гол шалтгаан бол залуучууд хүртээмжийг нэмэгдүүлэх тухай хүсэлтүүдийг удаа дараа хэлээд байгаа юм. Заавал ч үгүй бас үнэгүй байдаг юм уу, буцалтгүй тусламж байгаа энэ хэлбэрийг бол хүсэхгүй байгаа. Тодорхой хугацаанд зээлээ аваад, ашиглаад, үүнийгээ бас эргэн төлөх нөхцөл нь ойлгомжтойгоор хийж чадах юм бол илүү олон залуучуудад өөрөө өөрсдөө бие даагаад явах эхний ийм концепц руу боловсролын зээлийн санг ороосой гэдэг ийм саналтай байгаад байгаа. Тэгээд энийг бас цаашдаа анхаараач ээ.

2-т нь Боловсролын зээлийн сангаар бид нэг талдаа зөвхөн гадагшаа явах тухай асуудлыг бид бүхэн яриад байгаа юм. Одоо бид бүхэн дотооддоо гаднын сайн боловсон хүчнийг, багш нарыг авчрах тухай боловсролын зээлийн сангийн тодорхой хувийг энэ рүү чиглүүлэх тухай ийм асуудлуудыг энэхүү тогтоолоор бас чиглэл болгож өгсөн байгаа юм. Мөн дээрээс нь залуучуудын асуудал дээр нийгмийн чухал асуудлуудыг бид бүхэн бас мартаад байна. Залуу малчдын тухай асуудлууд, залуу гэр бүлийн тухай асуудлууд, залуучуудын хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой асуудлууд, хорт зуршил, соёл, сэтгэл зүй гээд энэ олон асуудлуудыг бид бүхэн энэ Нийгмийн бодлогын байнгын хороо тодорхой энэ төсвийн хэмжүүрүүд дээрээ тавьж ажиллахгүй бол хүн амын дийлэнх болсон энэ хэсэг бол хаягдаад дуусаж байгаа. Гадагшаа том нүүдэл бий болоод явж байгаа. Төр засаг, ирээдүйдээ итгэх итгэл энэ үеийнхэнд бас байхгүй байгаа мэдрэмжүүд удаа дараагийн жагсаал цуглаан янз янзын хэлбэрээр илэрч байгаа. Гэтэл бид эрэмбийн хойгуур байх ёстой, чухал асуудал биш ээ гэдэг ийм өнцгөөр харж, энэ байдал үүссэнээс боловсролын тэгш бус байдал нийгэмд аль хэдийнээ бий болсон. Хот, хөдөөг байг гэхэд Улаанбаатар хотод сурч байгаа өсвөр үеийн хүүхдүүдийн боловсрол авч байгаа энэ байдал бол эрс өөр байгааг бид бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд нийгмийн энэ зааг ялгаа, гэр бүл, тэгээд малчдын хувьд бол илүү хүндрэлтэй байгаа асуудлууд гээд энэ асуудлын тухай бид нар ингээд ярихгүй, судлахгүй, төсвийн тодорхой асуудлыг чиглүүлэхгүй ийм байдалтай бас яваад байвал энэ нийгмийн том хуваагдал руу бас орох эрсдэл байгаа шүү гэдгийг бас анхааруулж бас хэлье. Энэ чиглэлээр бид нар илүү сайжруулах боломж байвал ажиллах зайлшгүй шаардлагатай байна гэдгийг бас сануулж хэлмээр байна.

Тэгээд боловсролын жил гэж зарлаж байгаа бол илүү юмаа тодорхой болгоё. Би хүртэл яг энэ боловсролын жилийн хүрээнд яг ямар өөрчлөлт Монгол Улсад авчрах гээд байгаа юм бэ гэдгийг бүрэн дүүрэн ойлгохгүй хэмжээнд байгаа хэр нь хүний хөгжил бол мега том төсөл юм гэдэг энэ үгийг бид бүхэн бас яриад явахаар бас ийм зөрүүтэй ойлголт бий болоод байна. Тэгэхээр энэ зүйлүүдийг нэлээн анхаарсан илүү сайжруулах ёстой асуудлууд бас байна. Дараа дараагийн шатны хэлэлцүүлгүүд дээр илүү детальчлаад бас ярих нь зөв гэсэн ийм байр суурьтай байгаагаа илэрхийлье.

Б.Найдалаа: Баярлалаа. Мөнхтуяа гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнхтуяа: Маргааш ахмадын өдөр тийм ээ. 3 хоногийн дараа Дэлхийн багш нарын өдөр тохиож байгаа. Тэгээд ахмадуудаасаа, багш нараасаа хүлцэл өчье. Уучлал хүсье. Үнэхээр ахмаддаа сэтгэлгүй, энэ ачааны хүндийг үүрч яваа боловсролын салбар, эрүүл мэндийн салбарынхандаа ээлгүй ийм төртэй байгаадаа харамсаж байна. Үнэхээр яг энэ юмыг хийе гээд сэтгэл гаргавал болохгүй юм бол байхгүй шүү дээ. Манайх гуравхан сая хүнтэй. Өчнөөн их баялагтай ийм баян оронд төрчхөөд гуйлгачин шиг амьдруулж байгаад нээрээ үнэхээр ичмээр байна. Уйлмаар байна. Тэгээд үнэхээр энэ төсвөө баталж чадахгүй юм бол төсвөө буцаад татаад,

Засгийн газар нь огцор. Тэгээд бүр болохгүй байгаа бол Улсын Их Хурал нь ч ч гэсэн тарсан нь дээр. Ийм муухай эх орон, ард түмэндээ ивээлгүй, ээлгүй, хайргүй ийм төр засгаар яах юм. Тэгээд энэ хүн рүү чиглэсэн юм ярингуут дандаа бие биеэ адална. Зөв, үнэн хэлсэн хүмүүсийг дандаа адална. Одоо маргааш бол би зөндөө сэвүүлнэ. Хүний төлөө дуугарсан хүн бүхэн алуулдаг, хэрчүүлдэг ийм муухай байдлаар бид нар ингэж ажил хийхгүй ээ. Одоо больё хэдүүлээ. Өглөөнөөс хойш Өргөдлийн байнгын хороон дээрээс эхлээд л стресс. Өдөржин стресс. Одоо шөнө хэдэн цаг болж байна. 9 цаг болох гэж байна.

Тэгээд энэ дотор нөгөө сайд нар нь байхгүй. Чинбүрэн сайд, Наранбаяр сайд 2-оос өөр сайд байхгүй. Өөрсдөө сонгогдох болохоороо энүүгээр зүгээр пиг дүүрэн чихээд сууж байдаг шүү дээ. Тэгээд сайдын суудлаа авчихаараа ард түмэн байхгүй мартагдана. Баяртай. Ийм муухай хүмүүсийг бид нар сонгож байгаа байхгүй юу. Одоо тэгээд тарвал таарна.

Б.Найдалаа: Баярлалаа. Зулпхар гишүүн үг хэлнэ.

С.Зулпхар: Бид бас орой болтол ингээд төсвөө яриад байж байгаа нь тал талдаа их тийм мэдээлэл авахаас гадна тодорхой ойлголт нэг талаасаа чухал байх. Болохоосоо болохгүй хүртэл ярьцгааж байгаа гэж бодож байна.

Би энэ боловсролын хөгжлийг дэмжих жилтэй уялдуулаад Наранбаяр сайдад бас зарим нэг зүйлийг санал болгож, дайя гэж бодож байна. Энэ цахим сургалттай холбоотой цахим сургууль гээд бидний том зорилт явж байгаа. Энийг цааш нь бол үргэлжлүүлээрэй. Энэ дээр байж байгаа мөнгийг ерөөсөө хасаж болохгүй шүү. Бүүр нэмээд явах ёстой гэж байгаа. Цахим ангиуд нээгдэх ёстой. Тэгж байж бид нар энэ сургалтын чанарыг илүү сайн түвшинд гаргах тодорхой жишээ нь арга зам нээгдэж байгаа гэдгийг мэдэж байгаа. Тийм ч байгаа. Бусад улс орнууд ч гэсэн тэгж байгаа. Бид тэрнээс хоцрохгүйн тулд энэ дээр бол зоригтой байна шүү гэдгийг хэлж байгаа юм.

2 дахь зүйл мэргэжлийн боловсрол дээр энэ хөдөлмөрийн зах зээл чинь эрэлт, нийлүүлэлт нь үндсэндээ мэргэжлийн боловсролын энэ тогтолцоогоор дамжаад зохих түвшинд бол хангагдах учиртай гээд бид судалгааг нь хийгээд, бүх тооцоог нь хийчихсэн. Энэ дээр танай дээр бүхэл бүтэн дэд тогтолцоо байж байгаа. Энэ дээр 20-26 мянган хүн болж сурч эхэлж байгаа юм байна. Тухайлан анхаараарай гэж байгаа юм. Цаашлаад танай дээр уг нь газар байсан. Газрыг нь жишээ нь механик байдлаар байхгүй болгочихсон. Энэ таны алдаа бол биш. Угаасаа цаанаас нь ийм аргачлал өгсөн юм байна лээ. Энэ газрыг буцаж байгуулаарай гэж байгаа юм. Газар байж байж бид нар энэ бодлогоо тодорхой болгоод бодлогынхоо хэрэгжилтийг хангана шүү дээ. Ингэж байж бид нар явахгүй бол заримдаа ерөөсөө л бүгд адилхан байх ёстой. Бүгдээрээ нэг бол цагаан өнгөтэй, бүгдээрээ нэг бол хар өнгөтэй байх ёстой гэдэг ийм бодлого бол байхгүй учраас энийг та анхаараарай гэж байгаа юм.

3 дахь зүйл. Та их тодорхой хариулж байна. Ноднин бид нар бол тийм ч байх болов уу гэж бодсон. Энэ санхүүгийн лизинг. Тэртээ тэргүй бидэнд төсвийн боломж бол хязгаартай байгаа бол боломжоо хараад суугаад байж болохгүй гээд бүгдээрээ хэлж байгаа бол энэ санхүүгийн лизингээ ашиглаарай. Сургуулиудад жишээ нь анги танхимуудад сандал ширээ нь хүрэлцэхгүй байна, техник хэрэгсэл нь хүрэлцэхгүй байгаа бол энийг чинь ингээд л авна шүү дээ. Тэгж байж бид нар боловсролынхоо хөгжлийг хангана. Ядаж хугацаа алдахгүй сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр энэ дээр анхаарах боломж нь байгаа бол энийг хэрэглээрэй гэж байгаа юм.

4 дэх зүйл нэгэнтээ бидэнд ахиад санхүүжилтийн тодорхой нөөцүүд, боломжууд, арга хэрэгслүүд байгаа. Тэр нь бол олон улсын санхүүгийн байгууллагаас бид бас тодорхой зээлүүд авч байгаа. Энэ ерөнхий боловсролын чиглэлээр 150 сая доллар, мэргэжлийн боловсролоор 20 сая доллар. Тэгээд энийгээ бүрэн аваад, оны эхнээс энийг яаралтай жишээ нь үүнтэй холбоотой бүх процессыг нь эхлүүлээд, тэгээд энийг бол хэрэглээрэй гэж. Тэгж байж бид нар бол үр дүнг нь 2026 оны төгсгөл гэхэд эхнээс нь харна. Тэгэхгүй энийг хэрэглэж чадахгүй бол ахиад л ирэх жил бие биеийнхээ урдаас болсон, болоогүй гээд хэдүүлээ яриад сууж байгаа учраас энийг анхаараач ээ гэж бас зориуд хэлж байгаа юм.

Тэрнээс гадна би түрүүн бас танд 2 зүйл хэлсэн. 1 нь Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум. Энийг газар дээр нь ажиллаад ирсэн хүний хувьд би бол тухайлан хэлсэн. Та чуулган дээр бас их бас тодорхой гаргалгааг нь бид хийнэ гэсэн. Энэ бол угаасаа таны үүрэг. Та ч гэсэн энэ дээр бол эрмэлзэлтэй байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Тэнд бол спортын хичээл, биеийн тамирын хичээл ерөөсөө байхгүй байгаа. Энэ аль хэдийн 2, 3 жил яригдсан зүйлийг одоо дахин дахин яриад байх бол биш. Энийг тэртээ тэргүй хэрэгжүүлэх ёстой юмыг нь та зохицуулаад эхлүүлж байгаач ээ.

Дараагийн зүйл Баян-Өлгий аймгийн Баяннуур сум. Энэ дотуур байрны асуудал чинь нэг ийм тендерийн маргаанаас болоод л жишээ нь зогсчихсон шүү дээ. Хэсэг хүмүүсийн хоорондын маргаан нь эцсийн дүндээ боловсролын салбарын хувь заяанд, хүүхдүүдийн хувь заяанд нөлөөлж байгаа бол энийг шуурхай шийдээд өгөөч ээ. Энэ дээр Сангийн яам бас Ганбат дарга аа, та бас анхаарал хандуулаад өгөөч ээ. Энэ угаасаа танай дээр өөр мэдээлэлтэй, Боловсролын яам дээр нэг өөр мэдээлэлтэй байна. Энийг нэгтгээд өгөөч ээ гэсэн ийм хүсэлтэй байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

С.Эрдэнэбат: Тэгээд 2, 3 байнгын хороо, чуулган гээд дамнаад л хэллээ. Яг энэ боловсрол, эрүүл мэндийн суурь 2 салбар яг бүх ард түмэнд хамгийн их хамаатай ийм 2 салбар луугаа бид нар бол илүү их анхаарах ёстой. Тэгээд тэр цалин хөлснийх нь асуудал, тэр эм тарианы асуудал, мөн дээрээс нь сандал ширээг л Их Хурлын гишүүн тойрогт очоод ажиллахаар захын эмнэлэг, сургуулиасаа авхуулаад л янз бүрийн л зүйл нэхдэг. Тэгээд ийм юмыг гаргамааргүй байна гэдгийг бол 1 дүгээрт хэлмээр байна. Тэр нэхэж байгаа хүмүүсийн буруу ерөөсөө биш шүү. Бид нар шийдэхгүй байгаад байгаа юм.

2 дугаарт харамч хүн 2 дахин төлнө гэгчээр хөдөлмөрийн аюулгүй байдал гээд би түрүү жилжингээ л үглэж байсан. Тэгээд ёр юм шиг нөгөө станц дээр осол гарсан. 400 сая төгрөг энэ эрчим хүчний салбарт манай Энхцэцэг гишүүн бид 2 хэлээд л тавьсан. Тэрийг нь огт тавьж зарцуулаагүй. Тэгсэн 100 тэрбумын хохиролтой осол аваар гарсан. Тэгэхээр ийм зүйл дээрээ манай төсөв зохиогч нар маань анхаараарай. Хэлэх юмаа хэл, гуйх юмаа гуй. Байхгүй гэж хэлчхээд гарлаа гэдэг шиг л байна шүү дээ. Одоо энд бараг 20, 30-аад гишүүд л үг хэллээ. Тэгээд саналыг нь авах юм уу, авахгүй юм уу. Тэгээд авахгүй болоод ирэнгүүт нь яадаг вэ гэхээр зарчмын зөрүүтэй санал гээд энэ төсөв чинь эвдэгдэх юм гарна. Тэгэхээр ийм тодорхой саналуудаар гарц гаргалгаа гаргаач ээ. Гишүүд бол байр сууриа хэллээ. Тодорхой саналууд дээр бол байр суурь нээгдэж байна. Тэр 24 хувийн төсвийн урсгал зардал гэдэг ийм юмыг хэрэгтэй заалтаа бол тэр жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнөөсөө бол татаад аваад хэрэглээд байгаа юм. Яг хажууд нь зэрэгцээд байж байгаа заалтуудыг бол үл тоогоод байгаа. Байгаа нь боломж нь л энэ юм байна лээ гэж.

Тийм учраас үнэхээр тэр зардал төсвөө хэмнэх бол тэр том том өрөөтэй дарга нараасаа авхуулаад шахаад суу. Их Хурлын гишүүд 2,3-уулаа суугаад иргэдтэй уулзах гээд үүдэнд нь очерлоод болоод л байна. Тэрнээсээ авхуулаад тэр орон зайгаа гаргаад, тэр сургууль, цэцэрлэгийнхээ хүрэхгүй байгаа юмаа оруулахаас авхуулаад эхэлмээр байна. Манай төрийн байгууллагад бол яг ний нуугүй хэлэхэд бол байшин барилга бол бас байгаа шүү дээ. Тэгэхээр ийм шинэчлэлийг бол хийнэ гэж бодож байгаа. Төсөв энэ дээрээ тулж байгаа бол. 1 хэсэг нь хаан шиг залраад, 1 хэсэг нь хичээллэх байргүй, сургуульгүй. Тэр Хөвсгөлийн Монгол Улсын хамгийн хойд талын 1 суман дээр очоод харсан 50 хэдэн зуухтай сургууль байж байна лээ. Тэгээд 21 дүгээр зууныхаа үеэрээ л байж байна лээ. Сургуулийн төсөвт тавьсан. Тийшээ нь ордог хүн байж байхгүй. Тэгээд үүнээс авхуулаад төсөв дээр бодохоор зүйл бол их байна. Яг үнэнийг хэлэхэд хөрөнгө оруулалт гэж байгаа юмнууд чинь ихэнх нь бол ерөөсөө маш цөөхөн хүн хүртэхээр л юмнууд байгаа шүү дээ. 1 сум дээр жишээ хэлэхэд усанд ордог газрын барилгыг бараг 3, 4 жил барьж байгаа. 150 сая төгрөгийн юмыг. 100 жил болж байгаа сум тэгээд нөгөө усанд орох газрынхаа барилгыг 4 жил дамнуулан барина гэдэг бол энэ цаанаа бүр ингээд тендер аваад сурчихсан хэсэг хүмүүс юм.

Нийгмийн бодлогын байнгын хороо бол үндсэндээ боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг гээд нийгмийн суурь салбар хөрөнгө мөнгө нэхдэг. Тэгэхдээ энэ хөрөнгө мөнгөний асуудал нь маш олон хүнд хамаатай. Бидний үр хүүхдүүдээс авхуулаад ахмадууд. Одоо тэр ажлын хэсэг байгуулсан. Би тэр Байнгын хороодын зүгээс тавьсан Сангийн яамны үүдэн дээр очиж ахмадууд тэтгэврийнхээ асуудлыг нэхнэ биз. Гэр бүл, хөдөлмөрийн яам дээр очно биз. Эмч, сувилагч нар нь Эрүүл мэндийнхээ яам дээр очно биз. Уг нь ая эвийг нь олчих гээд дунд нь нэлээн л үзэх юм. Тэгээд хамгийн гол нь ямар ч боломж байхгүй, үгүй гэдэг л байр суурийг бол илэрхийлээд суугаад байгаа юм. Энэ байр сууриа эргэж бодоорой. Тэгээд энэ төсөв дээр хэлсэн саналуудыг бол та бүгд маань бас авч, дараагийн ээлжид бас оруулж ирээрэй гэдгийг хүсье.

Б.Найдалаа: Баярлалаа. Би бас нэг товчхон товчхон үг хэлье.

Ямар ч байсан өнөөдөр ийм орой болтол суугаад, хуралд оролцоод, мэдээлэл өгсөн, асуултад хариулсан тайлбар өгсөн ажлын хэсгийн дарга, мэргэжилтнүүддээ маш их баярлалаа.

Тэгээд улсын төсөв гэхээр бид нар зүгээр хандлагаа өөрчлөх гээд бас буруу байгаад байна. Улсын төсөв гэхээр бид нар яамны төсөв баталгаагүй байхгүй юу. Улсын төсөв бол Улсын Их Хурлын, парламентын аль ч улсын хамгийн чухал сэдэв. Яагаад гэвэл тэр жил өмнөхөөсөө юу хийх юм гэдгийг бид нар ярьж байгаад баталдаг. Тийм болохоор энд сайд нар байх ёстой байдаг. Өнөөдөр жишээлбэл Чинбүрэн сайд байсны ачаар бид нар Эрүүл мэндийн даатгалын сан цаашаа яаж өөрчлөгдөж байгаа, 8 зүйлтэй юм орж байгаа юм байна, бас өөрчлөлт хийх гэж байгаа юм байна гэдэг мэдээлэл аваад, ерөнхийдөө гишүүд бол асуулт асуухгүй болчихож байгаа байхгүй юу. Ханачхаж байгаа юм. Тэр мэдээллийг нь ирэхээр ярилцъя. Тэгье ингэе гээд өөрөөс нь мэдээлэл авчихаар. Наранбаяр сайд ирээд сая тэр боловсролын жил дээр ингэж байгаа, тэгж байгаа, сайн, муу бүгдийг нь яриад бас мэдээллийг өгчхөж байгаа юм. Манай нөгөө 2 яамныхан сайд нартаа дамжуулаарай. Бид нар сайд нарыг байлгах гээд байгаа юм биш. Зүгээр сайд нараа дэмжих гээд, яг юу хийх гээд байгааг нь асуух гээд байгаа байхгүй юу. Түүнээс биш хэдэн сандал авч байгаа юм бэ гэдгийг бол та бүхэн хариулж байна. Гэхдээ цаашдаа ер нь сандал авах юм уу, үгүй юм уу гээд бодлогын чанартай өөр

шинэчлэлт нь юу юм. Энэ талаар л лавлах гээд байгаа болохоос яг зүгээр бодсон төсөв өмнөх жил шигээ явж байгаа, урсаж байгаа төсвийг бол гишүүд сонирхох нь бага байхгүй юу. Тэгэхээр ялангуяа Аубакир сайдад сануулаарай.

Дараагийн удаа нийгмийн даатгалын тэр тогтолцооны шинэчлэлийн талаар асуумаар байна, яримаар байна. Яг яах гээд байна. Бид нар дэмжмээр байна. Ахмадуудын тэтгэвэр нэммээр байна. Нэмэхийн тулд тэр тогтолцоогоо шинэчлэхгүй бол боломжгүй байна. Эмч нарын цалинг нэммээр байна. Нэмэхийн тулд Эрүүл мэндийн даатгалын тэр тогтолцоо, сангийн тогтолцоог өөрчлөхгүй бол болохгүй байгаа юм. Иймэрхүү маягаар төсөв бол ер нь сайд нарын ажил шүү. Улс төрийн бодлоготны ажил. Тэгээд мега төсөл гэж ярьж байгаа. Хүний нөөц мега төсөл мөн. Хүн мега төсөл мөн. Боловсролын жил гэсэн байгаа. Ер нь улс төрч болгоноос гардаг. Тэгэхдээ яг амьдрал дээрээ бид нар төслөө эрэмбэлэхгүй байгаа асуудал байна. Төсөл гэхээр бид нар нөгөө байшин, зам ч юм уу тиймэрхүү объект бодоод байгаа. Хүний хөгжил эмч, багшийн цалинг нэмэх, ахмадын цалинг нэмэх бол төсөл мөн байхгүй юу. Яг бүгдийг нь зэрэгцүүлж байгаад эрэмбэлмээр байгаа юм. Энийг яам гэхээсээ илүү Засгийн газар дээр сайд нарын дунд эрэмбэлэх ёстой гэж бодож байна. Тийм болохоор бид нар тэрийг асуугаад байгаа байхгүй юу. Яг эрэмбэ нь хэд юм бэ. Ахмадын тэтгэврийг нэмэх нь 10 дугаар асуудал юм уу, 100 дугаар асуудал юм уу, 2 дугаар асуудал юм уу гэдгийг хэлээд өгөөч ээ гэж байгаа юм. Тэр нь зөв, буруу нь хамаагүй. Багш нарын цалинг нэмэх нь хэддүгээр асуудал юм бэ. 10 бол 10-аа хэл, 1 бол 1-ээ хэл. Засгийн газрын бодлого гэдэг нь тэр. Тэгээд тэр бодлогоо гаргачих юм бол төсөвт тавигдаж л таараа байхгүй юу.

Тэгээд зарим гишүүдийн бухимдаад байгаа нь үнэн шүү дээ. Ямар ч бодлогогүй болохоор бүгдээрээ жагсаж байдаг. Цалин нэм, цалин нэм гээд ярьдаг юм нь цалин. Чадна, чадахгүй ярьдаг. Тэгээд эргээд бараг тэрийгээ ярингуут цалингаа нэмээгүй байхад инфляц явчихдаг ийм сонин урвуу, гаж эдийн засгийн тогтолцоонд орчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар Байнгын хороо дээрээ ярьж байгаа. Манай Байнгын хороо бол Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Шинээр зохион байгуулагдсан хуучин боловсрол, соёл, эрүүл мэнд, шинжлэх ухаан тэр асуудлууд бүгдээрээ орсон байгаа. Тэгэхээр бид нарын энэ сольдог нь бол нэрийг нь сольж байгаа асуудал биш, Улсын Их Хурлын стратегийн төлөвлөгөө дээр хүн төвтэй хөгжил гэж орсон. Өөрөөр хэлбэл энэ 4 яам байна шүү дээ. Манай Байнгын хорооны асуудал нь харьяа 4 яам. Соёлын яам соёлын төв барихдаа биш. Эрүүл мэндийн яам эмнэлэг барихдаа биш. Боловсролын яам сургууль барихдаа биш. Эцсийн дүндээ цаана нь 1 л хүнд зориулж байгаа биз дээ. Цаана нь 1л хүн байгаа шүү дээ. Тэнд л тал талаас нь үйлчилж байгаа байхгүй юу. Тэгэхээр Байнгын хороон дээрээ гишүүд ярьж байгаа. Энэ салбар хоорондын уялдааг хангахгүй бол салбарынхаа хөгжлийн төлөө яваад байна. Хүний хөгжлийн төлөө явахгүй байна гээд. Энэ дээр бид нар бас ярьж байгаа зүйлс байгаа. Жишээлбэл түрүүн тэр багш нарын цалинг нэмэхтэй холбоотой асуудал дээр Засгийн газраас тодорхой бодлогын шийдвэрийг шаардана. Эх үүсвэр нь ер нь бол хамаагүй асуудал. Эх үүсвэр бол олдоно. Энэ бол яг манай Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дээр гишүүдийн хүрээнд бодлогын хэмжээнд эрх зүйн орчныг нь бүрдүүлэх чиглэлээр Засгийн газарт чиглэл, шаардлага тавих чиглэлээр хоорондоо мэтгэлцэхдээ биш, асуудалтай мэтгэлцэх ийм орчныг бүрдүүлэх гээд ажиллаж байгаа.

Гишүүд Монгол Улсын 2026 оны төсвийн төслүүдтэй холбогдуулан үг хэлж дууслаа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгаа манай байнгын хорооноос Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Оролцсон бүх гишүүд, ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

20.30 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ